

Лиахона



**Аврагчийн амар амгалан,
баяр баяслын бэлэг, х.18**

**Утаа униараас Түүний
гэрэл руу, х.42**

**Нифай аав бид хоёрт
тусалсан нь, х.56**

**Христийн Мэндэлсний Баярын
тухай Угдорф эгчийн дурсамж, х.66**



Есүсийн төрөлт, Филлис Лак

Мэргэн хүмүүс Есүс Христийн төрөлтийн үеэр тэнгэрт гарч ирсэн шинэ одыг даган явж саяхан төрөөд байсан нялх хүүхдэд бэлэг өгснийг бид Матай 2:9–11-ээс мэддэг билээ.

“Тэдний зүүнтэйд харсан од тэдний өмнө явсаар

Хүүхдийн байсан газар хүрээд тогтов.

“Тэд одыг хараад, үлэмж баяр хөөр болжээ.

“Тэгээд гэрт орж, Мариагийн хамт байгаа Хүүг хараад сөгдөн Түүнд мөргөж, эрдэнэсийн хайрцгаа нээгээд алт, гүгэл, мирийг бэлэг болгон барив.”

ЗАХИАСУУД

- 4 Тэргүүн Зөвлөлийн захиас бичиг: Талархалтай байхаар сонгох нь**
Ерөнхийлөгч Хенри Б.Айринг
- 7 Айлчлагч багшийн захиас бичиг: Өргөн цар хүрээтэй үйл ажиллагаа**

ОНЦЛОГ ӨГҮҮЛЛҮҮД

- 18 Аврагч амьд гэдгийг мэдсэнээс ирдэг амар амгалан ба баяр баясал**
Ахлагч Рассел М.Нелсон
"Хэрэв та нар Түүнийг хайрлаж, зарлигуудыг нь сахих юм бол Тэр та нарыг хайрлаж, өргөн дэмжснэ, Өөрийгөө та нарт харуулах болно."
- 24 Ариун сүмд хүрэх зам**
Чад Э.Фарез
Украйны Хожмын Үеийн Гэгээнтнүүд өөр өөр замыг сонгосон ч ариун сүм рүү хөтөлдөг зөв замыг олсон юм.
- 28 Боломжуудаа нээх түлхүүр: Боловсролын Тасралтгүй Сангийн 10 жилийн ойг тэмдэглэв**
Ребека Аткин
2001 онд хэрэгжүүлж эхэлсэн Боловсролын Тасралтгүй Сан Сүмийн мянга мянган гишүүдийн амьдралыг адислаад байна.

- 34 Алдагдаад олдсон нь**
Адам К.Өүлсон
Гэр бүлийн нэгэн хос өдөр тутам гаргадаг шийдвэрүүдээ мөнхийн хувь тавилантайгаа хэрхэн холбодог тухай өгүүлэх нь.

ХЭСГҮҮД

- 8 Өчүүхэн бөгөөд энгийн зүйлс**
- 11 Бидний гэр орон, бидний гэр бүл: Ая нь буруу байсан ч урам хайрласан дуу**
ЖаНийл Б.Фрийман


ХАВТСАН ДЭЭР

Нүүрэн талд: Маттью Рейерийн хавсаргасан зураг. Ар талд: Карл Хайнрих Блокийн зурсан "Есүсийн төрөлт". Дани улсын Хиллерод хотын Фредериксбургын Үндэсний Түүхийн Музейн зөвшөөрлөөр авч ашиглав.

- 12 Сүмд үйлчилсэн нь: Ганц бие гишүүн миний үйлчлэл**
Жюли Бёрдетт
- 14 Бид Христийн тухай ярьж байна: "Хэрэв тэгсэн бол?" гэсэн асуулт бүрийн хариу**
Майкл Д.Вудбери
- 16 Сайн мэдээний сонгомол бүтээл: Их Эзэнээс авсан сургамж**
Ахлагч Марвин Ж.Аштон
- 38 Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн дуу хоолой**
- 74 Сүмийн мэдээ**
- 79 Гэр бүлийн үдшийн санаанууд**
- 80 Биднийг дахин уулзалт: Хүүгийн Гэрэл**
Жефф С.Мкинтош

Украйны Киевийн
Ариун сүм

24





42

42 Тэд бидэнд хандан ярив: Ирцгээ, Түүнийг шүтэн биширцгээе

Ахлагч Патрик Керон



Энэ дугаарт нуусан
Лиахонаг олоорой.
Санамж: сүлд мо-
дон доор тавьсан
бэлэг.

46 Асуулт, хариултууд

*Би ирээдүйнхээ талаар хэр-
хэн өөдрөг үзэлтэй байх вэ?*

48 Үзүүлэн: Чи хэзээ ч ганцаараа биш

49 Би хэрхэн мэдсэн бэ?: Их Эзэн үй олон адислалыг юүлсэн юм

Ким Коунг

50 Баттай гэрчлэл

Ахлагч Карл Б.Пратт

*Моронайн амлалт танд
хамаатай юу?*

52 Энэ нь танд тэмдэг болно

Витни Хинкли

*Есүс Христийн төрөлтийн
тухай бошигложууд гайхам-
шигтайгаар биелэгдсэн юм.*

55 Утга учиртайгаар сонгосон бэлэг

*Нялх хүү Христэд бэлэглэсэн
алт, гүгэл, мирийн далд утга
санаа.*

56 Тэд өөрчлөгдөх ёстой

Франциско Хавиер Лара
Хернандез

58 Иосеф Ахтай танилцана уу

*Бошиглогч Иосеф Смитийн
тухай та нарын мэдэхгүй
байж болох зарим зүйлийг
өгүүлэе.*



72

59 Тусгай гэрч: Би Аврагчийг хэрхэн дагах вэ?

Ахлагч Квинтин Л.Кук

60 Бүдүүлэг үгс

Анги Бергстром Миллер

*Найз нар нь бүдүүлэг үгс
хэлэхийг сонсоод Шелбай
яха хэрэгтэй байсан бэ?*

62 Бидний хуудас

63 Ариун сүмийн карт

64 Хүүхдийн Хэсгийг гэртээ авчрах нь: Судрууд Авраг- чийн төрөлт ба Хоёр дахь ирэлтийн тухай надад заадаг

Женнифер Мадди

66 Христийн Мэндэлсний Баярын сүлд мод

Харриет Р.Угдорф

*Герман дахь хүүхэд ахуй
насны минь Христийн Мэн-
дэлсний Баярын дурсамж.*

68 Миний номлолын сан

Спенсер С.

*Та нар номлолдоо зориулан
одооноос мөнгө хуримт-
луулж болно.*

69 Итгэлийн Тунхаг

*Бидний үндсэн итгэлийн
арвангурван тунхаг.*

70 Бага насны хүүхдүүдэд зориулав

2011 ОНЫ АРВАНХОЁРДУГААР САРЫН ДУГААР ЛИАХОНА 09692 363

Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн
Сүмийн олон улсын сэтгүүл

Тэргүүн Зөвлөл: Томас С.Монсон, Хенри Б.Айринг,
Диетер Ф.Угдорф

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулга: Бойд К.Пакер,
Л.Том Перри, Рассел М.Нелсон, Даллин Х.Өүкс,
М.Рассел Баллард, Ричард Г.Скотт, Роберт Д.Хейлс,
Жеффери Р.Холланд, Давид А.Беднар, Квинтин Л.Кук,
Д.Тодд Кристофферсон, Нийл Л.Андерсен

Эрхлэгч: Пол Б.Пайпер

Зөвлөхүүд: Кейт Р.Эдвардс, Кристоффел Голден Бага,
Пер Ж.Малм

Гүйцэтгэх захирал: Давид Л.Фричнет

Редакцийн захирал: Винсент А. Вон

Зургийн дарга: Аллан Р.Лоиборг

Гүйцэтгэх редактор: Р.Вал Жонсон

Гүйцэтгэх туслах редактор: Женифер Л.Грийнвүүд,
Адам К.Өүлсон

Туслах редактор: Сюзан Баррет, Раян Карр

редакцийн ажилтнууд: Бриттани Бийти, Давид А.
Эдвардс, Маттью Д.Флиттон, Ларина Портер Гаунт,
Карри Кастен, Женнифер Медди, Лиа МакКаллахан,
Меллиса Меррил, Майкл Р.Моррис, Салли Ж.Өүдкөрк,
Жошуа Ж.Пөржи, Чад И.Фарес, Жан Пинбороу, Паул
Ванденберг, Мелиса Зентено

Гүйцэтгэх Зургийн захирал: Ж.Скотт Нудсен

Зургийн захирал: Скот Ван Кампен

Уран бүтээлийн менежер: Жейн Анн Петерс

Ахлах дизайнерууд: К. Кимбалл Ботт, Томас С.

Чайльд, Коллеен Хинкли, Эрик П.Хонсен,

Скотт М.Мооё

Уран бүтээлийн ажилтнууд: Коллетт Небекер

Аун, Ховард Ж.Браун, Жюли Бёрдетт, Режиналд

Ж.Крисченсен, Ким Фенстермейкер, Катлийн Ховард,

Денис Кэрби, Жинни Ж.Нилсон

Хэвлэлийн эх бэлтгэгч: Жефф Л.Мартин

Хэвлэлийн захирал: Крейг К.Седвик

Хуваарилалт хариуцсан захирал: Эван Ларсен,
Нэгдсэн Улс, Канадаас бусад орнууд дахь захиалга
болон үнийн талаар орон нутгийн Сүмийн хангамжийн
төв болон тойрог, салбарынхаа удирдагчтай холбоо
барина уу.

Гар бичмэл болон асуултаа интернэт вебсайт
liahona.lds.org руу; шуудангаар **Liahona, Rm. 2420,**
50 E. North Temple St., Salt Lake City, UT 84150-0024,
USA хаягаар; эсвэл э-мэйлийн: **liahona@ldschurch**
.org хаягаар ирүүлнэ үү.

Ли́ахона нь (Мормоны Номон дахь утгаараа бол
“луужин” буюу “залагч”) албани, англи, армен,
бислам, болгар, вьетнам, гаити, герман, грек, дани,
индонез, ирланд, испани, итали, камбож, кирибати,
латви, литва, малагаш, маршалл, монгол, нидерланд,
норвеги, орос, польш, португали, румын, самоа,
себуано, солонгос, тагало, тай, тахити, тонга, украин,
унгар, урду, фижи, фин, франц, хорват, хятад,
чех, швед, эстони, япон хэлээр нийтлэгддэг. (Жилд
нийтлэгдэх дугаарын тоо улс бүрд өөр байна.)


© 2011 by Intellectual Reserve, Inc. Бүх эрх
хамгаалагдсан. Америкийн Нэгдсэн Улсад хэвлэв.

Ли́ахона дахь сэдэв, үзүүлэн, материалуудыг онцгой
тохиолдолд арилжааны бус зорилгоор сүм болон
гэрт ашиглахын тулд хувилж болно. Урлагийн
бүтээлийг хуулбарлахыг хориглосон бол үзүүлэнг
хувилан олшруулж болохгүй. Зохиогчийн эрхийн
талаарх асуултаа Intellectual Property Office, 50 E.
North Temple St., Salt Lake City, UT 84150, USA хаягаар;
эсвэл электрон шуудангийн: **cor-intellectualproperty@**
ldschurch.org хаягаар ирүүлнэ үү.

For Readers in the United States and Canada:
December 2011 Vol. 12 No. 6. LIAHONA (USPS 311-480)
Mongolian (ISSN 1525-7584) is published six times a
year (January, April, June, July, October, and December)
by The Church of Jesus Christ of Latter-day Saints,
50 E. North Temple St., Salt Lake City, UT 84150. USA
subscription price is \$5.00 per year; Canada, \$6.00
plus applicable taxes. Periodicals Postage Paid at Salt
Lake City, Utah. Sixty days' notice required for change
of address. Include address label from a recent issue;
old and new address *must* be included. Send USA and
Canadian subscriptions to Salt Lake Distribution Center
at address below. Subscription help line: 1-800-537-
5971. Credit card orders (Visa, MasterCard, American
Express) may be taken by phone. (Canada Poste
Information: Publication Agreement #40017431)

POSTMASTER: Send address changes to Salt Lake
Distribution Center, Church Magazines, PO Box 26368,
Salt Lake City, UT 84126-0368.

Дэлгэрэнгүй мэдээллийг онлайнаас үзэж болно Liahona.lds.org



ТӨРӨЛХ ХЭЛЭЭРЭЭ

Ли́ахона болон Сүмийн бусад
материалуудыг олон хэлээр www.languages.lds.org—аас үзэж болно.

НАСАНД ХҮРЭГЧДЭД ЗОРИУЛАВ

Ерөнхийлөгч Гордон Б.Хинкли 10
жилийн өмнө **Боловсролын**
Тасралтгүй Санг зарласнаас хойш уг
сан эрчимтэй хөгжиж байна. БТС-гийн
зээлээр мэргэжил боловсрол амжилт-
тай эзэмшсэн түүхүүдийг болон энэ
сангийн зээлийг хэрхэн олж авах,
уг санд хэрхэн хандив өргөж болохыг
мэдэхийн тулд ref.lds.org-т орж
үзнэ үү.

ЗАЛУУЧУУДАД ЗОРИУЛАВ

Украины Киевийн Ариун сүм гэр
бүлүүдийг хэрхэн бэхжүүлсэн
(хуудас 24-ийг үз) болон ариун сүмийг
онцгойлон адислахын өмнө болсон
залуучуудын соёлын үйл ажилла-
гаа үүнд оролцсон өсвөр үеийнхний
гэрчлэлийг хэрхэн хүчирхэгжүүлсэн
тухай уншина уу. Мөн youth.lds.org-т
орж, (“Kyiv Ukraine Temple”-ийг олж)
сүнснлэг нөлөө бүхий видеог үзнэ үү.

ХҮҮХДЭД ЗОРИУЛАВ

Хуудас 64, 66, 70 дахь Христийн
Мэндэлсний Баярын тухай түүхүү-
дийг уншаарай. Тэгээд **Лук 2 дээр**
үндэслэн зохиосон анхны Христийн
Мэндэлсний Баярын тухай видеог
үзнэ үү. [lds.org/new-testament-](http://lds.org/new-testament-videos)
[videos](http://lds.org/new-testament-videos) хаягаар орж үзээрэй.

ЭНЭ ДУГААР ДАХЬ СЭДВҮҮД

Тоонууд нь өгүүллийн эхний хуудсыг
зааж байгаа болно.

Адислалууд, 4

Ариун Сүнс, 50

Ариун сүмийн ажил,
24, 63

Боловсрол, 28

Боловсролын
Тасралтгүй Сан, 28

Бошиглогчид (эш
үзүүлэгчид), 52, 58
Гэр бүл, 11, 34, 56

Гэрчлэл, 50

Дуудлагууд, 12

Дуу хөгжим, 11

Есүс Христ, 4, 14, 16,
18, 42, 48, 52, 55, 59,
64, 70, 80

Жишгүүд, 60

Зан авир, 46

Идэвхжүүлэлт, 34

Итгэл, 69

Найдвар, 42, 46

Наманчлал, 24, 34, 42

Нийгмийн Халам-
жийн Бүлэг, 7

Номлолын ажил, 39,
49, 50, 56, 68

Смит, Иосеф, 58

Снөү Лорензо, 10

Сургалт, 11, 16

Сүмийн түүх, 8

Талархал, 4

Христийн
Мэндэлсний Баяр,

4, 9, 12, 18, 38, 39,
40, 41, 42, 52, 55, 66,
70, 72, 73

Хөрвөлт, 49, 50, 56

Цагаатгал, 4, 14

Эдгээлт, 14

Үг яриа, 60

Үйлчлэл, 4, 7, 12, 28,
38, 39, 40, 41, 68

Үлгэр дууриал, 7,
11, 60

Ерөнхийлөгч
Хенри Б.Айринг

Тэргүүн Зөвлөлийн
нэгдүгээр зөвлөх



Талархалтай

БАЙХЫГ СОНГОХ НЬ

Тэнгэр дэх бидний Эцэг юм бүхэнд талархалтай байхыг бидэнд зарлиг болгосон билээ (1-р Тессалоник 5:18-ыг үз). Мөн бид хүлээн авсан адислалуудынхаа төлөө талархаж байхыг Тэрбээр биднээс хүсэн хүлээдэг (С ба Г 46:32-ыг үз). Түүний бүх зарлиг биднийг аз жаргалтай болгохын төлөө байдгийг, бас зарлигуудыг зөрчих нь зовлон зүдгүүр рүү хөтөлдгийг бид мэднэ.

Тиймээс бид аз жаргалтай байж, зовлон зүдгүүрээс зайлсхийхийн тулд чин сэтгэлээсээ талархалтай байх ёстой. Талархал, аз жаргал хоёр хоорондоо холбоотой болохыг бид амьдралаасаа хардаг билээ. Амьдралд хүнд сорилт тохиолдсон үед бүх зүйлд талархалтай байх нь амаргүй ч бид бүхэн талархлын мэдрэмжтэй байх хэрэгтэй. Өвчин, санаа сэтгэлээр унах, хайртай хүмүүсээ алдах нь бидний амьдралд үе үе тохиолддог. Гай зовлон бидэнд зориулан Бурханы бэлтгэсэн адислалуудыг олж харан, тэдгээрийн төлөө талархалтай байхыг хэцүү болгодог.

Гэхдээ үнэн хэрэгтээ бид өөрсөддөө тохиолдсон сайн зүйлсийг талархалтайгаар хүлээж авдаггүйгээс адислалаа тоолоход хэцүү байдаг билээ. Бид орон гэргүй, идэх хоолгүй болж, элгэмсэг сэтгэлт анд найз нар, гэр бүлээ алдсан үед эдгээр эрхэм үнэт зүйлстэй байхдаа л талархалтай байх минь яав даа гэж халагладаг.

Хамгийн гол нь, бид хүлээн авдаг олон агуу адислалуудынхаа төлөө, тухайлбал Есүс Христийн төрөлт, Түүний Цагаатгал, амилалтын амлалт, гэр бүлтэйгээ хамт мөнх амьдрах боломж, сайн мэдээг санваар болон үүний түлхүүрүүдийн хамт Сэргээсний төлөө зохих ёсоор талархалтай байх нь заримдаа хэцүү байдаг. Бид гагцхүү Ариун Сүнсний тусламжтайгаар эдгээр адислалууд бидэнд болон бидний хайртай хүмүүст ямар учир холбогдолтой болохыг ойлгож чадна. Зөвхөн ингэсэн

тохиолдолд л бид бүх зүйлд талархалтай байж, талархалгүй байснаараа Бурханыг гомдоохоос зайлсхийж чадна.

Бидэнд амьдралын хүнд сорилтууд дунд ч адислалуудаа тод томруунаар олж харахад Бурхан Ариун Сүнсний хүчээр туслахын төлөө залбирах ёстой. Тэрбээр Сүнсний хүчээр бидэнд соёрхогдсон адислалуудыг таньж, тэдгээрийн төлөө талархалтай байхад тусалж чадна. Надад хамгийн их тусалсан зүйл бол “Таны нэрийн өмнөөс миний тусалж болох хэн нэгэнрүү намайг чиглүүлнэ үү?” хэмээн Бурханд хандан залбирч гуйсан явдал юм. Өөрийн хүлээж авсан адислалуудыг тод томруунаар олж харах нь бусдыг адислахад Бурханд тусалж байгаа хэрэг юм.

Өмнө нь миний таньдаггүй байсан гэр бүлийн хос намайг эмнэлэг дээр хүрч ирнэ үү гэж хүссэн үед миний нэгэн залбирал хариулагдаж билээ Би эмнэлэг дээр очоод өрөөсөн гарт минь л багтах өөдсийн чинээхэн хүүхдийг олж харлаа. Төрөөд хэдхэн долоо хоногсон атлаа тэр охин өдий төдий мэс засал хийлгэсэн байв. Бурханы энэхүү бяцхан хүүхдийн амийг аврахын тулд зүрх, уушгинд нь бүр илүү хүнд мэс засал хийх хэрэгтэйг эмч нар эцэг эхэд нь ярьсан ажээ.

Би эцэг эхийнх нь хүсэлтээр тэр хүүхдэд санваарын адислал өглөө. Миний адислалд бяцхан охин илүү урт удаан амьдрах болно гэсэн амлалт багтсан юм. Бид адислал өгснөөсөө илүү их чин сэтгэлийн талархлыг өөрөө хүлээн авч билээ.

Бид бүгд Тэнгэрлэг Эцэгийнхээ тусламжтайгаар үлэмж их талархлыг мэдэрч чадна. Бидний нөхцөл байдал, амьдрал ахуй ямар ч байлаа гэсэн адислалуудаа илүү тод томруунаар олж харахад туслахыг Түүнээс гуйж болно. Тэр өдөр миний зүрх сэтгэл, бие махбод өмнө нь хэзээ ч байгаагүйгээр гайхамшигт талархлыг мэдэрсэн юм. Бурханы болон бидний эргэн тойрон дахь



Бурхан Эцэг бидэнд Хүүгээ өгсөн бол Есүс Христ бидэнд бүх бэлгүүдээс хамгийн агуу нь болох Цагаатгалыг өгсөн юм.

сайн санаат хүмүүсийн нинжин сэтгэлийн гайхамшгийн улмаас хүүхдүүдээ ирсэн үй олон адислалын төлөө тэр өдөр би харих замдаа баярлан талархаж явлаа.

Хамгийн гол нь, санаа зовон түгшүүлэсэн тэр эцэг эх хоёр болон өөрийн амьдралд Цагаатгал үйлчилсний төлөө би баярлан талархсан юм. Би тэдний нүүр царайнд, бүр аймшигт сорилтын үед ч итгэл найдвар, Христийн цэвэр хайр гэрэлтэж байхыг хардаг байсан. Итгэл найдвар, хайр энэрлийг мэдрэх боломжийг Цагаатгал олгох болно гэдгийг өөртөө илчлэхийг та Бурханаас хүсэх юм бол үүний нотолгоог мэдэрч чадна гэж би бодож байна.

Аврагчийн төрөлтийг тэмдэглэдэг жилийн энэ үеэр бид бүгд Бурханд хандсан залбирлаар талархлаа илэрхийлж, бусдад үйлчлэх удирдамж чиглэлийг Түүнээс хүсэж болно. Бурхан Эцэг бидэнд Хүүгээ өгсөн бол Есүс Христ бидэнд бүх бэлгүүдээс хамгийн агуу нь болох Цагаатгалыг өгсөн юм (С ба Г 14:7 -г үз).

Залбирлаар дамжуулан талархал илэрхийлэх нь эдгээр адислалуудаас гадна бусад олон адислалын ач холбогдлыг ойлгож, талархагч зүрх сэтгэлийн энэхүү бэлгийг хүлээн авах боломжийг олгодог билээ. ■

ЭНЭ ЗАХИАСААС ЗААХ НЬ

Өөрсдийн туршлага, адислалуудыг болон өнгөрсөн үеийн ямар нэг зүйлийг сэргээн санахад туслах зүйлсийг бич. Хүлээн авсан адислалуудаа санахад тусалж болох талархалтай байдаг зүйлсээ тэмдэглэн, одоо байгаа адислалуудаа таньж мэдэн, ирээдүйд авах адислалуудаа сэтгэл дүүрэн хүлээхийг зааж буй хүмүүсээсээ хүс.

Туслах болон үйлчилж болох хэн нэгэн рүү удирдахыг Тэнгэрлэг Эцгээс гуйсан Ерөнхийлөгч Айрингийн үлгэр жишээг дагахад заадаг хүмүүсээ урамшуулан дэмжих хэрэгтэй.

ЗАЛУУЧУУДАД ЗОРИУЛАВ

Бусдад талархал илэрхийлэх зорилго тавьж түүнийгээ хэрэгжүүл

Жон Хилтон III, Антони Свет нар

Адислалуудаа зөвхөн тоолох биш харин бусдыг хэрхэн адислах тухай ярилцацгаая! Талархалтай байдаг 100 зүйлээ жагсаан бичнэ үү. Хэрэв хэтэрхий олон санагдвал дараах байдлаар жагсаалтыг хий:

1. Талархалтай байдаг бие бялдрынхаа 10 чадварыг жагсаан бич.
2. Талархалтай байдаг 10 эд хогшлоо нэрлэн бич.
3. Өөрийн талархаж явдаг, одоо амьд байгаа 10 хүний нэрийг бич.
4. Өөрийн талархаж явдаг, нас барсан 10 хүний нэрийг бич.

5. Өөрийн талархдаг байгалийн 10 зүйлийг бич.
6. Өнөөдөр талархаж явдаг 10 зүйлийг бич.
7. Өөрийн талархаж явдаг дэлхийн 10 газрын нэрийг бич.
8. Өөрийн талархалтай байдаг орчин үеийн 10 бүтээлийг бич.
9. Талархаж явдаг 10 хүнсний бүтээгдэхүүнийг нэрлэ.
10. Өөрийн баярлан талархаж явдаг, сайн мэдээний 10 зүйлийг бич.

Бид ийм жагсаалт хийснээр энэ нь Бурханаас бидэнд өгсөн бүх зүйлийн ердөө өчүүхэн хэсэг нь болохыг ойлгоно.

ХҮҮХДЭД ЗОРИУЛАВ

Адислалуудаа олж харахад надад туслаач

Фелир амьдралдаа хүлээн авсан адислалуудаа олж харахад өөртөө туслахыг Тэнгэрлэг Эцгээс гуйжээ. Талархалтай байж болох зүйлсийг нь олоход түүнд тусал. Эдгээр зүйлсийг дугуйл. Зурганд юу юу нуусныг анхааралгүй өнгөрөв өө. Энд:

байшин, нохой, сүм, сургууль, хувцас, унадаг дугуй, гитар, бөмбөг, цэцэг бий,

Өөрийн талархалтай байдаг зүйлсийн жагсаалт хийж, гэр бүлтэйгээ хуваалцахыг хичээ.





Өргөн цар хүрээтэй үйл ажиллагаа

Энэ материалыг судалж, гэрээр нь очиж заадаг эгч нартай аль болох тохиромжтой арга замаар ярилиц. Эгч нарыг хүчирхэгжүүлэх болон Нийгмийн Халамжийн Бүлэг амьдралд тань идэвхтэй үүрэг гүйцэтгэхэд туслах асуултуудыг асуу.

Итгэл • Гэр бүл • Халамж

Их Эзэн, Түүний Сүм, гэр бүлүүд болон нийгэмд зөв шударга эмэгтэйчүүдийн нөлөө хэрэгтэй байна. Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Ахлагч М.Рассел Баллард, “Их Эзэнтэй хийсэн гэрээнүүд, энэ Сүмийн эгч бүр хүмүүсийг аврах, дэлхийн эмэгтэйчүүдийг удирдах, Сионы гэр бүлүүдийг бэхжүүлэх, Бурханы хаант улсыг байгуулахад туслах, заавал биелүүлэх бурханлиг үүрэгтэй юм” хэмээн сургажээ.¹

Ийм өргөн цар хүрээтэй зорилгыг биелүүлж чадах юм болов уу гэж зарим эгч нар эргэлзэж магадгүй. Гэвч Нийгмийн Халамжийн Бүлгийн хоёр дахь ерөнхий ерөнхийлөгч Элиза Р.Снөү (1804–87), “Дэлхий дээр Бурханы хаант улсыг байгуулах агуу зорилгыг хэрэгжүүлэх үйлсээс хөндий тасархай, энэ хэрэгт нөлөө үзүүлдэггүй эгч нэг ч байдаггүй” гэжээ.² Нийгмийн Халамжийн Бүлэг “эрхмээс эрхэм, агуу ажлыг гүйцэлдүүлэхийн төлөө” зохион байгуулагдсан юм гэж Снөү эгч бас сургажээ.³

Нийгмийн Халамжийн Бүлгийн ажилд оролцох нь итгэлээ төлөвшүүлэх, гэр бүлүүдийг бэхжүүлэх, эх орондоо болон дэлхий даяар үйлчлэл үзүүлэх боломжийг эгч бүрд олгож, бидний нөлөөний хүрээг өргөжүүлдэг. Хувь хүмүүс болоод Нийгмийн Халамжийн Бүлгийн хувьд бидний гаргаж буй хүч чармайлт бүх талыг хамарсан өргөн цар хүрээтэй байх шаардлагагүй, харин сайн бодож боловсруулсан, байнгын байх ёстой. Өдөр бүр хувиараа болон гэр бүлээрээ залбирч, судар судлах, Сүмийн дуудлагадаа хичээл зүтгэл гарган ажиллах нь итгэлээ нэмэгдүүлж, Их Эзэний хаант улсыг байгуулахад туслах болно.

Ахлагч Баллард, энэхүү даруухан мэт санагдах хувь нэмэр нь өөрчлөлт гаргах болов уу хэмээн эргэлздэг эгч нарт хандан: “Үнэн ба зөв шударга ёсны төлөө бат зогсдог эгч бүр хилэнцэт нөлөөг бууруулдаг. Гэр бүлээ бэхжүүлж, хамгаалдаг эгч бүр Бурханы ажлыг хийж байгаа нь тэр. Бурханы эмэгтэйн хувиар амьдардаг эгч бүр зөв шударга байдлын үрийг суулгаж, ирээдүйд хадаж авах үр нөлөөг нь дагахад бусдад гэрэлт цамхаг болж байна” хэмээн нотолжээ.⁴

Би юу хийж чадах вэ?

1. Зөв шударга нөлөө үзүүлэх чадвараа танин мэдэж, энэ дагуу үйл ажиллагаа явуулахад нь би уулзсан эгч нартаа хэрхэн тусалж болох вэ?

2. Би өөрийн өвөрмөц бэлэг, авьяас чадварыг бусдыг адислахад хэрхэн ашиглаж болох вэ?

Судруудаас

1 Коринт 12:4–18;
1 Тимот 6:18–19;
Мозай 4:27; Итгэлийн Тунхаг 1:13

Нэмэлт мэдээллийг
reliefsociety.lds
.org-аас үзнэ үү.

Бидний түүхээс

Наувуд Нийгмийн Халамжийн Бүлэг зохион байгуулагдахад нарийн бичгийн даргаар үйлчилсэн Элиза Р.Снөүг Нийгмийн Халамжийн Бүлгийг тойргууддаа зохион байгуулахад бишопуудад тусалцуулахаар Сүм даяар томилолтоор явж ажиллуулахаар Ерөнхийлөгч Бригам Янг (1801–77) дууджээ.

“Хэрэв Израилын охид, эмэгтэйчүүдийн хэн нь ч гэсэн үйл ажиллагаандаа оролцох чадвар нь хязгаарлагдмал гэж боддог байсан бол эдүгээ сайн ажлыг хийх энэхүү чадвар тэдэнд үлэмж их буйг мэдэх болно. . . . Ерөнхийлөгч Янг өргөн цар хүрээтэй, үр ашигтай үйл ажиллагааны боломжийг нээж өгсөн юм.”⁵

Эшлэл

1. М.Рассел Баллард, “Women of Righteousness,” *Лиакхона*, 2002 оны 12-р сар, 39.
2. Элиза Р.Снөү, “An Address,” *Woman's Exponent*, 1873 оны 9-р сарын 15, 62.
3. Элиза Р.Снөү, “Female Relief Society,” *Deseret News*, 1868 оны 4-р сарын 22, 81.
4. М.Рассел Баллард, *Лиакхона*, 2002 оны 12-р сар, 39.
5. Элиза Р.Снөү, *Deseret News*, 1868 оны 4-р сарын 22, 81.



Өчүүхэн бөгөөд энгийн зүйлс

“Өчүүхэн мөн энгийн зүйлүүдээр агуу их зүйлүүд улиран авчрагддаг” (Алма 37:6).

СҮМИЙН ТҮҮХ ДЭЛХИЙ ДАХИНАА



Мексик

Хожмын Үеийн Гэгээнтэн анхны номлогчид 1875 онд Мексикт иржээ. Тэд хоёр бүлэгт хуваагдсан гэнэ. Нэг бүлэг нь орон даяар нэр нөлөө бүхий удирдагчдад испани хэлээр түүвэрлэн хэвлэсэн Мормоны Номын хэсгүүдийг илгээж, олон хүмүүст заасан

боловч хөрвөгчидтэй болж чадсангүй. Нөгөө бүлэг нь Сонорагийн Хермосиллод Мексикийн Сүмийн анхны таван гишүүнд баптисм хүртээсэн аж. 1875 онд Сүмийн ном зохиолыг хүлээн авсан удирдагчдын нэг Мексик хотын Плотино К.Родаканати дөрвөн жилийн дараа өөртөө болон бусад зарим хүмүүст баптисм хүртээнэ үү гэж хүсчээ. 1885 он гэхэд Мормоны Номыг испани хэлэнд орчуулж дуусав.

Энэ орон олон жилийн турш улс төрийн хурцадмал байдалтай байсан ч анхны гишүүд нь итгэлтэй хэвээр үлдсэн юм. 1961 оны 12-р сарын 3-нд Сүм дэх анхны испани хэлтэй—Мексик Гадас зохион байгуулагдав. Сүм нэлээд хэдэн сургууль, түүний дотор Benemérito de las Américas сургуулийг Мексик хотод 1963 онд байгуулсан нь одоо хүртэл ажиллаж байна.

Мексик хотод орших Мексикийн анхны ариун сүмийг 1983 онд онцгойлон адисласан. 2000 он гэхэд Мексикт найман ариун сүм онцгойлон адислагдаад байлаа.

2004 онд Мексик Америкийн Нэгдсэн Улсаас гадна нэг сая гишүүнтэй анхны орон болов.



Сүмийн удирдагчид 1963 оны 11-р сарын 4-нд Benemérito de las Américas сургуулийн газар хөндөх ёслолд оролцов.



МЕКСИК ДЭХ СҮМ	
Гишүүнчлэл	1,234,545
Номлол	23
Гадас	221
Тойрог, салбарууд	2,009
Ариун сүм	Үйл ажиллагаа явуулж байгаа 12; зарлагдсан 1

Эхэн үеийн Анхдагчуудын Христийн Мэндэлсний Баяр

Христийн Мэндэлсний Баяр гэвч энэ нь анхдагч нарыг баярын өдрөө онцгой дурсамжтайгаар өнгөрүүлэхэд саад болоогүй юм. Христийн Мэндэлсний Баяр

Миний хамгийн сайхан Христийн Мэндэлсний Баяр

“Миний хамгийн сайхан Христийн Мэндэлсний Баяр [Солт Лейкийн] Хөндийд бямба гарагт болж билээ. Бид энэ баярыг Хүндэтгэлийн өдөр тэмдэглэсэн юм. Бид цайзын төвд төрийн далбааг тойрон цуглаалаа. Тэнд бид цуглаан зохион байгуулав. Тун сайхан цуглаан болсон. Бид Бурханд зориулан магтуу дуунууд дуулав. Нээлтийн залбирал хийсний дараа тэр өдөр үг хэлсэн хүнийг би үргэлж санадаг. Тэр хүн талархал, урам зоригийн үгс хэлсэн бөгөөд гутрангуй үг хэллэг ганц ч сонсогдоогүй. Хүмүүс ирээдүйдээ итгэлтэй байсан учир итгэл найдвар, урам зоригоор дүүрэн байлаа. Цуглааны дараа бүх хүмүүс гар барив. Зарим хүмүүс баярласандаа уйлж байлаа. Хүүхдүүд тэр үдэш асаасан мугваагийн түүдэг галыг тойрон хашаан дотор тоглож байв. Бид хамтдаа цуглан ‘Ирцгээ, ирцгээ, Гэгээнтнүүд ээ, хүнд хүчир ажлаас бүү ай, замаараа баяртай алхал’ хэмээн дууллаа. Туулайн мах чанаж, талхаар хачирлан хооллов. Энэ хоол бидэнд бүгдэд нь хүрсэн бөгөөд амар амгалан, өөдрөг сайхан сэтгэлийн мэдрэмж төрж байлаа. Миний амьдралд тийм сайхан Христийн Мэндэлсний Баяр хэзээ ч байсангүй.”

Нэр нь үл мэдэгдэх зохиогчийн эдгээр үгсийг Кейт Б.Картерын эмхтгэсэн, 20 боть *Our Pioneer Heritage* номонд Брайнт С.Хинкли эш татжээ. (1958–77), 14:198.

Цаг хугацаа нисэх мэт өнгөрч билээ

“Намайг арван зургаатай байхад нэг үдэш аав маань өөрийн хүүхдүүдэд болон ойрын хөршүүдийнхээ гэр бүлүүдэд зориулж, Христийн Мэндэлсний Баярын үдэшлэг зохиож билээ. Бид бүжиглэв. Ах нар маань хөгжим

тоглов. Аав үдэшлэгийг арван цагт дуусахаар төлөвлөж байсан учир дөрвөл бүжгийн дундуур хөгжимчдөд тоглолтоо зогсоо гэлээ Гэвч ах нар маань тэр үдэш намайг цагруу олон удаа өргөж, зүүт ухраасныг аав мэдээгүй ажээ. Би тэгэх бүрдээ цагийн зүүт гучин минутаар ухраасан. Үдэшлэг дуусахад шөнө дунд өнгөрч байсан нь лавтай.”

Христэд итгэгч Өүлсоны гэр бүлийн цэдгээс (Картерын эмхтгэсэн) *Our Pioneer Heritage*, 15:199.

Хөгжилтэй цаг

“1849 онд Христийн Мэндэлсний Баярын өглөө хүүхдүүдийг сэрэхэд тэр нутаг даяар айлуудад хүүхэддэй байтугай иштэй ганц чихэр эсвэл ганц алим ч байсангүй. Гэсэн ч хүүхдүүд болон тэдний эцэг эхчүүд бүгдээрээ баяртай байлаа. Бага сага идэх юмтай байсандаа хүмүүс баяртай байснаас

гадна шинэ гэр орондоо аз жаргалтай, гэрэл гэгээтэй байх хэтийн төлөв тэдний өмнө өдөр бүр өссөөр байлаа. Хэдийгээр хүүхдүүд нь хүүхэддэйнээс эхлээд тоглох тоглоомгүй байсан ч аав ээж нар нь Христийн Мэндэлсний тэр Баярыг мартаагүй төдийгүй өдөр өнгөрч үдэш болохоос өмнө тэд бүгд баяр хөөрөөр дүүрэн байлаа.

“Үдэш нь тэд Жон Рөүберрийн өмгөр байшинд цуглав. Эднийд анхны цуглаанууд болдог байв. Христийн Мэндэлсний Баярыг хэзээ ч тийм хөгжилтэй тэмдэглэж байгаагүйгээрээ тэд тэнд хуучны бүжиг бүжиглэн өдрийг өнгөрүүлсэн ажээ. . . . Харин хөгжим л байсангүй. Ямар ч хөгмийн зэмсэг олдсонгүй. Сирус Кол маш сайн исгэрдэг учир хөгжилтэй анхдагчуудыг бүжиглэхэд аялыг нь исгэрсэн юм.”

Сара Толман, Кейт Б.Картерын эмхтгэсэн, 6 боть *Treasures of Pioneer Heritage*–д эш татжээ. (1952–57), 4:197–98.



АГУУ ХҮМҮҮСИЙН АМЬДРАЛ МАРТАГДДАГҮЙ

Ерөнхийлөгч Лорензо Снөү (1814–1901)



Лорензо Снөү хожим нь Сүмийн тавдахь Ерөнхийлөгч болсон ч эгч Элиза нь түүнийг Огайогийн Кертландахь Бошиглогчдын Сургуульд еврей хэлний хэлний хичээлд суухыг урих хүртэл баптисм хүртэхийг сонирхсонгүй. Энэ сургуульд Иосеф Смит болон Сүмийн бусад удирдагчид явдаг байлаа. Лорензо удалгүй сайн мэдээг сонирхож, 1836 оны 6-р сарын 19-нд Сүмд нэгджээ. Тэгээд Ахлагч Снөү Итали, Сандвич арлууд (одоогийн Хавай), Их Британид номлолд үйлчилж, Хатан Хаан Викторид Мормоны Номыг өгсөн ажээ.



Ахлагч Снөү гайхамшигтай бэлгүүдтэй байсан бөгөөд үүнийгээ Их Эзэнд үйлчлэхэд ашигладаг байв. Түүний патриархын адислалд тэрээр өндөр наслах хэдий ч өтөлж хөгширснөө мэдэрэхгүй хэмээн амласан ажээ. Түүний эрч хүч хижээл насандаа ч идэвхтэй хэвээр байж, төлөөлөгч, бошиглогч болох боломжийг түүнд олгосон юм. Тэр бас хэдэн үхсэн хүнийг санваарын хүчээр амь оруулсан юм.

Ерөнхийлөгч Снөүг бошиглогч байх үед өмнөд Юта дахь Хожмын Үеийн Гэгээнтнүүд ган гачигт нэрвэгдсэн ажээ. Ерөнхийлөгч Снөү өмнөд Ютагийн Сейнт Жорж хотод чуулган дээр үг хэлэхдээ хэрэв тэд аравны нэгээ төлбөл бороо орж, ган тайлагдан, арвин их ургац хураах болно гэсэн сүнсэлэг нөлөө бүхий амлалтыг Гэгээнтнүүдэд өгчээ. Гишүүд аравны нэгээ төлсөн ч бороо оролгүй хэдэн сар өнгөрч. Ерөнхийлөгч Снөү бороо оруулж өгөхийг Тэнгэрлэг Эцэгээс гуйв. Тэрээр дараа нь “Сейнт Жоржид бороо орлоо” гэсэн цахилгаан мэдээ хүлээн авсан ажээ.

Нэмэлт мэдээллийг Францис М.Гиббонс, Lorenzo Snow: Spiritual Giant, Prophet of God (1982)-оос үзнэ үү.

Дээд талд: Лорензо Снөүгийн хөрөг зураг (1865 оны орчим). Дунд талд: Ерөнхийлөгч Снөү (дундах нь) Тэргүүн Зөвлөл дэх өөрийн зөвлөхүүд Жорж К.Каннон (зүүн талд), Жозеф Ф.Смит (баруун талд) нарын хамт 1900 онд. Доод талд: Хожмын Үеийн Гэгээнтнүүд аравны нэгээ төлөх тухай Ерөнхийлөгч Снөүгийн зөвлөгөөг дагасны дараа бороо орж, арвин ургац хураан адислагдсан юм.

АЯ НЬ БУРУУ БАЙСАН Ч УРАМ ХАЙРЛАСАН ДУУ

ЖаНийл Б.Фрийман

Аав цээл ч биш, баргил ч биш хоолойтой ч, өөрийнхөөрөө, энэ хоёр хоолойтой төстэй хоолойгоор дууг дуулав. Аав С, А хоёрын дундуур дуулж чадаагүй ч, чанга, тод дуулаа.

Аавынхаа муу дуулснаас ичиж байснаа би огт санадаггүй ч хөгжилтэй чанга дуунд нь инээд хүрч гайхдаг байлаа. Бусад хүмүүс сонсож байгаа гэдгийг аав мэддэггүй юм болов уу?

Аав минь сайн мэдээний дуулуудад дуртай байсан бөгөөд дуулахдаа сайнгүй байсан нь түүний шүтлэг бишрэлд нөлөөлөөгүй юм. Тэрээр баяр баясал, урам зориг, сэтгэл хөдлөлтэйгөөр дуулдаг байлаа. “Бурханы Сүнс” зэрэг дууллыг эхлээд эрч хүч, итгэл үнэмшилтэйгээр дуулж байснаа хэсэгхэн хугацааны дараа түүнийгээ хүндэтгэлтэй, намуухнаар дуулж чаддагт нь би дуртай байлаа.

Нэг орой аав надад нэг дуулаар дамжуулан сэтгэлд хоногшсон сайхан хичээлийг зааж билээ. Би ахлах сургуульд байхдаа хичээлийн дараа их төлөв төгөлдөр хуур тоглодог байлаа. Аав минь болж л өгвөл надад хамт байхыг хичээж, над дээр орж ирдэгсэн. Аав орж ирээд дууны номны хуудас эргүүлж, нэг дуу олоод, надаар аяыг нь тоглуулаад өөрөө дагаж дуулдаг байлаа.

Харин тэр нэгэн өдөр аав дуулын ном гаргаж ирээд, нэг дууллыг гаргаснаа,

“Энэ бол маш сайхан дуу. Миний дуртай дуунуудын нэг дээ” гээд

номоо төгөлдөр хуур дээр тавилаа. Энэ бол “Хөөрхий зовсон бадарчин” гэдэг дуу байсан юм. Энэ дуу Бошиглогч Иосеф Смитийн дуртай дуу байсныг, мөн Картейж шоронд Иосеф, Хайрум хоёр алагдахаас өмнөхөн Иосеф энэ дууг дуулж өгөөч гэж Жон Тейлороос хүссэн тухай надад ярьж билээ.

Тэгээд аав намайг аяыг нь тоглож байх үед бүх долоон бадгийг бүгдийг нь дуулав. Тэр үед хоёр сонин зүйл болсон юм. Нэг нь гэвэл аав дууг бүгдийг яг ноотоор нь дуулав. Түүний А доошлуулга яг таарч байлаа! Аавын хоолой мадаггүй зөв, энгийн байсан бөгөөд надад их сайхан санагдлаа. Хоёрдахь зүйл нь гайхаад баймааргүй ч маш чухал юм. Аавыг дуулж байхад тэр Иосеф Смитэд хайртай бөгөөд түүний бошиглогчийн дуудлагын талаар гэрчлэлтэйг нь би мэдсэн. Иосеф Смит бошиглогч байсан гэдгийг Сүнс надад гэрчилсэн юм.

Хэдэн жилийн дараа аав минь өөд болсон бөгөөд би тэр нэгэн өдрийн тухай бас тэр өдөр надад хэрхэн нөлөөлснийг олонтоо боддог билээ. “Дуулж чаддаггүй” аав минь бүх зүрх сэтгэлээрээ дуулахыг хичээсэн нь сайн мэдээний тухай миний гэрчлэлийн нэг чухал хэсэг болон зүрх сэтгэлд минь бат бөх шингэсэн юм. ■



ЗААХ БОЛОМЖУУДЫГ АШИГЛА

“Бид залуучуудад үлгэр жишээгээр замыг үзүүлэхээс гадна тэдний зүрх сэтгэлийг ойлгож, сайн мэдээний замаар хамтдаа замнаснаар тэднийг удирдаж чадна. Бид тэдний зүрх сэтгэлийг жинхэнэ ёсоор ойлгохын тулд нэг өрөөнд эсвэл нэг гэр бүлд хамт байж, Сүмийн үйл ажиллагаануудад хамт оролцохоос илүү их зүйлийг хийх ёстой. Тэдний зүрх сэтгэлд гүн гүнзгий, өнө удаан орших гэрчлэлийг төлөвшүүлэх ажлыг бид төлөвлөж, энэ талаар заах боломж бүрийг ашигладаг байх ёстой. . . .

“Бурхан амьд бөгөөд Есүс бол Христ гэдгийг мэддэг тухай гэрчлэлээ хуваалцах боломж бидэнд байх болно гэдэгт би итгэлтэй байна. Бид гэрчлэлээ хуваалцсанаар зүрхний гүнд орших өөрсдийн хүүхдүүддээ хайраа мэдрүүлж чадна гэдэгт би итгэдэг. Хамгийн агуу хайр, хамгийн агуу багшлалт бидний гэр оронд байх ёстой.”

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Ахлагч Роберт Д.Хейлс, “Our Duty to God: The Mission of Parents and Leaders to the Rising Generation,” *Лиахона*, 2010 оны 5-р сар, 95, 98.

ГАНЦ БИЕ ГИШҮҮН МИНИЙ ҮЙЛЧЛЭЛ

Жюли Бёрдетт

Сүмийн сэтгүүлүүд

Би шинэ дуудлага хүлээн аваад балмагдан сандарч билээ. “Би энэ ажлыг хийж бардаг болов уу”? гэж өөрөөсөө асуулаа.


Би долоон жил орчмын өмнө 29-тэйдөө АНУ-ын Орегоноос Ютад шилжиж ирсэн юм. Дуудлагынхаа талаар сайтар бодсоны эцэст өөрийн явж байсан ганц бие гишүүдийн тойргоо өөрчилж, гэр бүлийн тойрогт явахаар шийдэв.

Эцэг эх минь намайг Сүмийн дуудлагыг үргэлж хүлээн авдаг бай гэж хүмүүжүүлсэн болохоор би дуудлагат ажилтай болохыг хүсч байгаагаа бишопт танилцуулахын тулд түүнтэй цаг товлов. Удалгүй би Хүүхдийн Хэсгийн таван настнуудад заадаг боллоо. Энэ ажил надад их таалагдсан. Бишоп таван сарын дараа намайг Хүүхдийн Хэсгийн ерөнхийлөгчөөр дуудав. Би балмагдан сандарч, “энэ ажлыг хийж бардаг болов уу?” гэж өөрөөсөө асуулаа.

Би ганц бие, тэгээд хүүхэдгүй байж энэ албан тушаалд үйлчлэхэд тохирох юм байх даа гэж бодож

билээ. Гэр бүлтэй гишүүдийн тойрог дахь өөрийн туршлагаас харахад Хүүхдийн Хэсгийн ерөнхийлөгчид гэрлэсэн, чадварлаг, халамжтай ээжүүд байлаа. Гэвч аав ээж хоёр минь надад заадаг байсныг санаад шинэ дуудлагыг хүлээн авлаа. “Ганц бие залуу насанд хүрэгч бүрд чухал дуудлага” өгдөг байх тухай зөвлөгөөг манай бишоп жинхэнэ ажил хэрэг болгосон хүн байлаа.¹ Энэ дуудлага миний бодсоноос арай илүү чухал байж болох юм, гэвч би үүнд баяртай байлаа.

Шинэ дуудлагаа аван үйлчилснээр аятай сайхан, хөгжилтэй, сүнсэлэг нөлөө бүхий олон үйл явдал надад тохиолдсон юм. Нэг жил бид Христийн Мэндэлсний Баяраар нэгэн онцгой хуваалцах цагт зориулж, Христийн төрөлтийг жүжигчлэн тоглов. Бид олон дуу дууллаа. Хоньчид болон Иосефт зориулж, нөмрөг, олон нугалаастай толгойн



алчуурууд хийж билээ. Тэнгэр элч нарт зориулж, саатай дурдангаар хэлхээ цэцэг, Мэргэн хүмүүст зориулж хатуу зузаан цаасыг мөнгөн саагаар бүрж титэм хийв.

Христийн мэндэлсэн тухай түүхийг жүжигчлэн тоглож, энэ баярт зориулсан ариун дуунууд дуулж байх үед би Мариагийн дүрд тоглосон хөөрхөн, жаахан охиныг ажиглалаа. Тэр охин хүндэтгэлтэй, эелдэг дөлгөөн байдлаар өвдөг сөгдөн, нялх хүүхэд Есүсийг төлөөлсөн хүүхэддэйг энхрийн ялдамхнаар тэвэрч байсан нь миний сэтгэлийг ихэд хөдөлгөлөө. Тэр агшинд сүнс намайг хайрт Тэнгэрлэг Эцэгтээ болон Аврагчдаа баярлан талархах сэтгэлээр дүүргэж, хайр дээр үндэслэсэн Түүний агуу үүрэг зорилгын



тухай гэрчлэлийг минь бэхжүүлсэн юм. Бас үйлчлэхээр дуудагдсаныхаа ачаар хүлээн авсан агуу адислалынхаа төлөө, тэрхүү үйлчлэлийг үзүүлэхэд надад тусалсан бишоптоо баярлан талархаж байлаа.

Сургаал ба Гэрээнээс бид, “Тиймийн тул, хэрэв та нар Бурханд үйлчлэх хүсэлтэй аваас та нар уг ажилд дуудагдсан болой” (С ба Г 4:3) хэмээн уншдаг билээ. Энэ шүлэг хэдийгээр номлолын ажилтай холбоотой ч, үүнийг бас сайн мэдээн дээр суурилсан үйлчлэлийн аливаа хэлбэрт хамааруулж болно гэж би боддог.

Бид бүгд гэрлэлтийн болон нийгмийн байдлаасаа үл хамааран, Түүнд эргэж очихын тулд өсч хөгжин, авьяас чадвараа хөгжүүлж,

Түүнийх байж, бие биендээ үйлчлэн, бие биендээ тусалж байхыг биднээс хүсэн хүлээдэг Тэнгэрлэг Эцэгийнхээ энхрий хайртай хүүхдүүд нь юм.

Тэр тойрогт миний мэдэрсэн хайр, хүндэтгэл өнөөг хүртэл зүрх сэтгэлд минь оршсоор байдаг билээ. Үйлчлэх тухай миний хүсэл биеллээ олж, олон хүмүүс надад туслан дэмжиж, Тэнгэрлэг Эцэг намайг үнэхээр адисалсан юм. Анхаарал халамжтай, эелдэг найрсаг удирдагчдын ачаар би Түүний хамгийн гайхамшигтай хүүхдүүдэд зааж, тэднээс суралцахаар адислагдсан билээ. ■

ЭШЛЭЛ

1. Гарын авлага 2: Сүмийг удирдах нь (2010), 16.3.3.



ХАЙРЫН АНХААРАЛ ХАЛАМЖ

“Ганц бие, насанд хүрсэн олон гишүүд

амьдрал болон түүнээс үүдэлтэй олон асуудал бэрхшээлүүдэд амжилттай дасан зохицдог ч, өөрсдийнх нь үнэ цэнийг болон Бурхан тэдэнд бүгдэд нь хайртай гэдгийг нотлон харуулахын тулд Сүм болон түүний гишүүдийн зүгээс тэднийг хайрлаж, анхаарал халамж тавих хэрэгтэй байдаг.

Ерөнхийлөгч Жеймс И.Фауст (1920–2007), Тэргүүн Зөвлөлийн Хоёрдугаар зөвлөх, “Welcoming Every Single One,” Лиахона, 2007 оны 8-р сар, 4.



ЦАГААТГАЛЫН ЭДГЭЭГЧ ХҮЧ

“[Есүс Христ] бидний зовлон зүдгүүрийг мэддэг, Тэр бидний төлөө санаа тавьдаг. Түүний сургаалт зүйрлэл дэх сайн самари хүнтэй адил Тэрбээр биднийг замын хажууд шархадсан байхыг олоод шархыг маань боож, анхаарал халамж тавьдаг билээ (Лук10:34-ийг үз). Ах, эгч нар аа, Түүний Цагаатгалын эдгээгч хүч бид бүгдийн төдийгүй бүх хүмүүсийн төлөө байдаг.”

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Ахлагч Даллин Х.Өүкс, “He Heals the Heavy Laden,” *Лиахона*, 2006 оны 11-р сар, 7.

“ХЭРЭВ ТЭГСЭН БОЛ?” ГЭСЭН АСУУЛТ БҮРИЙН ХАРИУ

“Мөн [Есүс Христ] бүх төрлийн өвчин мөн зүдгүүрүүд мөн уруу таталтуудыг тэвчих болно; мөн энэ нь тэр өөрийн хүмүүсийн шаналал мөн өвчинүүдийг өөр дээрээ авах болно гэсэн тэрхүү үг биелэгдэж болохын тулд бөлгөө (Алма 7:11).

Майкл Д.Вудбери

Хэдэн жилийн өмнө би мотортой дутуйныхаа суудлаас сута үсэрч замын голд уначихсан юм.

Бараг тэр даруйд өөр нэг том тээврийн хэрэгсэл намайг шүргэж, зам дагуулан чирэх нь тэр. Үүнийг харсан хүмүүс мэдээллэхдээ автын ослоор хүн нас барлаа гэжээ.

Бага эмч нар намайг амьд байгааг мэдээд тэр дор нь эмнэлэг рүү авч дахисан гэнэ. Дараагийн хэдэн өдрийн турш надад яаралтай цуврал мэс засал хийсэн ажээ. Намайг эмнэлэгт ухаангүй, сэхээнд байхад аавтай хамт хэдэн хүн миний толгой дээр гараа тавин санваарын хүчээр адисалсан гэдэг. Түүнээс хойш эдгэрэлт гайхамшигтай хурдан болсон гэнэ. Гэвч надад бие бялдрын хувьд тохиолдсон зүйлээс сүнсэлг байдлын хувьд тохиолдсон зүйл илүү чухал юм.

Энэ туршлага миний зүрх сэтгэлийг Аврагчийн нөлөөнд нээж өгсөн юм. Осол болсноос хойш долоо хоногийн дараа би ухаан орж, юу болсныг

мэдэж билээ. Их Эзэн намайг хамгаалж, эхнэр хүүхдүүдтэйгээ хамтдаа амьдрах боломжийг олгосныг мэдсэн. Тэгээд би Бурхан намайг хэзээ ч орхидоггүйд санаа амарч өөрийгөө тайтгарууллаа. Бэртэж зэрэмдэг болсондоо, бас цаашид удаан хугацаагаар эмчлүүлэх болсондоо санаагаар унахын оронд амар амгаланг мэдрэв.

Дараагийн өдөр хоногуудад Тэнгэрлэг Эцэг, Есүс Христ хоёрыг хайрлах миний хайр улам гүнзгийрч, бүх амьдралынхаа туршид итгэлтэй байх хүсэл минь бүр ч хүчтэй болов. Хувь тавилангаар тааралдсан сайн хүмүүсээр дамжуулан би Их Эзэний хайрыг харсан юм. Бас миний төлөө манай сүмийн хүмүүсийн хийсэн залбирал, мацаг барилтыг Тэнгэрлэг Эцэг сонсож, хариулсныг би харсан.

Би энэ түүхийг бусадтай хуваалцахад, “хэрэв тэгсэн бол?” гэсэн асуултыг эцэс төгсгөлгүй тавьж байлаа. “Хэрэв та үхсэн бол яах байсан бол?” “Хэрэв



та явж чадахгүй болсон бол яах байсан бэ?” “Хэрэв та амьдралынхаа үлдсэн бүх хугацаанд хүнд өвчинтэй тэмцэлдэж үйлээ үзэх болсон бол яах вэ? Надад тохиосон гайхамшиг бол “хэрэв тэгсэн бол” гэсэн асуулт бүрд Цагаатгал хариулсан явдал мөн.

Би Цагаатгалын ачаар үхлийн дараа амилж, бие бялдын бэртэлт гэмтлээ арилгана. Би эхнэр, хүүхдүүдтэйгээ мөнхийн гэр бүл болж лацдан холбуулсан. Үүнийг бас л Цагаатгал боломжтой болгосон юм. Хэрэв бид Аврагчид итгэх итгэлтэйгээр урагш ахин, амьдралын сорилт бэрхшээлүүдийг даван туулж, эцсийн хүртэл тэвчих юм бол Цагаатгал биднийг дагах ёстой замаар хангаснаар эцэстээ мөнх амьдралын амлаалт хэрэгжих болно. ■

Энэ сэдвээрх нэмэлт мэдээллийг Матай 11:28–30; 3 Нифай 17:7–9; түүнчлэн Брюс К.Хафен, “Beauty for Ashes: The Atonement of Jesus Christ,” *Лиахона*, Apr. 1997 оны 4-р сар, 39-өөс үзнэ үү.

“Мөн тэрээр үхлийг өөр дээрээ авах болно, тэр өөрийнх нь хүмүүсийг хүлсэн тэрхүү үхлийн хүлээсийг тайлж болохын тулд бөлгөө; мөн түүний зүрх сэтгэл бие махбодийн дагуу нигүүлслээр дүүргэгдэж болохын тулд, тэрээр бие махбодийн дагуу өөрийн хүмүүсийг тэдний сул байдлуудынх нь дагуу хэрхэн халамжлахыг мэдэж болохын тулд, тэрээр өөр дээрээ тэдний сул дорой чанаруудыг авах болно” (Алма 7:12).

ИХ ЭЗЭН БИДНИЙГ ХЭРХЭН ХҮЧИРХЭГЖҮҮЛДЭГ ВЭ?

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Ахлагч Давид А.Беднар ерөнхий чуулган дээр өөрийн хэлсэн “In the Strength of the Lord” (*Лиахона*, 2004 оны 11-р сар, 76–78) гэсэн үгээр энэ асуултанд хариулахад тусалсан юм:

- “Бид Их Эзэний хүчээр бүгдийг хийж, бүхнийг тэвчин, бүр даван туулж чадна.”
- “Цагаатгалын боломж олгогч, хүч чадал өгөгч тал нь бид өөрсдийн мөнх бус чадвараа танин мэдэж, хэрэгжүүлж чадахгүй зүйлээ харж, хийснээр төгөлдөржихөд маань тусалдаг.”
- “Их Эзэний хүч болон Түүний ач ивээлээр дамжуулан та бид бүх зүйлийг гүйцэлдүүлснийхээ төлөө адислагдаж чадна гэдгийг би мэднэ.”

Есүс Христийн Цагаатгалын үр дүнд өөрт чинь ирсэн адислалуудын тухай гэрчлэлээ өөр хүнтэй хуваалц.

Их Эзэнээс

АВСАН СУРГАМЖ



**Ахлагч Марвин
Ж.Аштон (1915–94)**

Арванхоёр
Төлөөлөгчийн Чуулгын

Марвин Ж.Аштон 1971 оны 12-р сарын 2-нд Төлөөлөгчөөр томилогджээ. Доорх өгүүлэл бол Бригам Янгийн Их Сургуулийн онцгой цугларалт дээр 1988 оны 6-р сарын 5-нд түүний хэлсэн үгийн эшлэл юм.

Би Есүс Христэд онцгой хайртайгаа үеийн үед санаж явах болно. Тэр бол амьд Бурханы Хүү гэдгийг надад заадаг байлаа. Тэр бол миний анд найз, багш, бас миний хүч чадал мөн гэдгийг надад заадаг байлаа. Түүний онцгой гэрч байх дуудлага, үүрэг хариуцлага хийгээд нэр хүндийг амьдралдаа хүлээсэн өнгөрсөн он жилүүдэд би Түүний амьдрал, Түүний замуудын тухай ихийг заалгалаа. Тэр үнэхээр Онцгой багш. Би ажил үүрэгтээ тус дэм, хүч чадал, удирдамж, үлгэр жишээ авахын тулд Шинэ Гэрээний Иоханы наймдугаар бүлгийг олон дахин уншдаг. Хэрэв та нар татгалзахгүй бол, бидний амьдрал, Есүстэй харилцах харилцааг маань бэхжүүлэх зарим шүлгийг уншицгаая. Эдгээр мөрүүд болон үгс Түүнийг илүү сайн ойлгоход надад тусалж, улам ихийг хийж, Түүнтэй илүү адилхан байх хүслийг надад төрүүлсэн юм. . . .

[Хуулийн багш нар болон фарисайчууд] завхайрч байгаад баригдсан нэг эмэгтэйг Түүн дээр авчирсан билээ. Тэдгээр дайснууд . . . Түүнийг мэхлэн сорихыг хичээсэн. Тэд тэр эмэгтэйг нүгэл үйлдэгч, бузар хүн болохыг харуулахын тулд дундаа суулгасан байлаа. Тэрбээр сайхь эмэгтэйн

дэргэдээс зугтаасангүй. . . . Тэр завхайрч байгаад үйлдэл дээрээ баригдсан аж. Тэр эмэгтэй гэм буруутай нь эргэлзээгүй байлаа. Тэд Түүнийг булзах аргагүй байдалд оруулахаар шийдсэн аж. Мосегийн хуулиар бол тэр эмэгтэйг чулуугаар шидэж алах ёстой байв. “Харин та юу гэж хэлэх вэ?” Иохан 8:5 гэж тэд асуугаад, Түүнийг сорин, урхидаж, гарцаагүй байдалд оруулахыг санаархаж байв.

Тэр юу ч гэж хэллээ гэсэн буруудаж, үүнийхээ төлөө яллагдах байв. Тэд Түүний уурыг хүргэж, Хэн болохоо мартахад хүрэхийг нь харахын тулд Түүнийг сорьсон ажээ. Тэр эмэгтэйг чулуугаар шидэх нь хэрцгий балмад явдал болох байв. Бас үл хайхрах нь буруу байв. . . . Тэрбээр доошоо бөхийж, тэднийг сонсохгүй байгаа юм шиг (тэднийг анхаарлыг татаж, зааж байгаа зүйлд хүн бүхний анхаарлыг хандуулахын тулд), хуруугаараа газар дээр бичиж байлаа. . . . Хормын төдийд чимээгүй байснаа тэд дахин асуулаа. Энэ асуултыг чинь би саваагүй асуулт гэж бодож байна: “Тэгээд цааш нь, асуу л даа. Бид таныг мартчих шахлаа. Та хариулахаас айж байна уу?” Гэвч Есүс завгүй байлаа. . . .

Есүс даруухан, номхон дөлгөөн атлаа сүрлэгээр тэргүүнээ өргөн, дараах сүрдэн бишрэм үгсийг хэлсэн билээ: “Та нарын дундаас нүгэлгүй хүн нь эхлээд энэ эмэгтэй уруу чулуу шид” [Иохан 8:7]. Төгс хүнээс ирсэн төгс хариулт.

Өнөөдөр бид үүрэг хариуцлага, нөхцөл байдал, дуудлагадаа үүнийг дахин дахин

санаж байх хэрэгтэй. Бүх хүмүүстэй харилцах бидний харилцаанд нүгэлгүй хүн л эхлээд шүүмжилж, дутагдал олох буюу хэн нэгнийг басамжлан дорд үзэж байг. . . . Тэр дахин бөхийж, газарт бичив. Тэд Түүний хэлснийг сонсчээ. Түүнийг юу ч хэлээгүй үед Түүний дөлгөөн тайван байдлын нөлөөг мэдэрсэн үедээ тэд ухамсартаа зэмлүүлэн, гарч явалгүйгээр тэндээ байсан юм. Тэдэнд шидэх чулуу олдсонгүй, харин сүнсний шархлаагаа бодсоор нэг нэгээрээ гарч явсан юм.

Тэрбээр нөгөөх эмэгтэйтэй хоёулхнаа үдлээ. Энэ тухай цэдэг байдагт би баяртай байна. Бидний зарим нь унасан хүмүүстэй хамт байхаас зайлсхийх хандлагатай байдаг. . . . “Тэд байна?” гэж Тэр асуусан юм. Чамайг хэн ч шийтгэсэнгүй юү?” гэж Тэр асуужээ. Иохан 8:10. . . . Есүс асуух, сонсох цаг гаргадаг байв. Бид ахиухан асууж, сонсох цаг гаргадаг байгаасай хэмээн би хүсдэг! Бидний хариулт энгийн атлаа сайтар бодож боловсруулсан байгаасай . . .

Завхайрч байгаад баригдсан эмэгтэй, түүнийг шийтгэсэн эсэхийг асуусан Их Эзэний асуултанд, “Эээн, хэн ч шийтгэсэнгүй” гэж хариулжээ. Тэгэхэд нь “Яв. Үүнээс хойш дахин нүгэл бүү үйлд” [Иохан 8:11] гэж Тэрбээр гайхан биширмээр хариулсан юм. Их Эзэн тэр өдөр ийн заасан юм. Яг энэ мөчид ч бас ийн зааж байна. Нүглийг үзэн яд, харин нүгэлтнийг хайрла. Энэ бол Түүний агуу захиас. Энэ захиас бидэнд хүч чадал, итгэл үнэмшлийг өгч, Аврагч Есүс Христэд улам ойртуулж чадна гэдэгт би итгэдэг. Есүс садар самууныг өөгшүүлээгүй юм. Тэрээр сайхь эмэгтэйд зандрангуйгаар сургаал айлдахын оронд түүнийг хайрласан билээ. Тэр эмэгтэй болон түүнийг буруутгагчдад хайрын сургамж хэрэгтэй байжээ. Дээрх нөхцөлд нигүүлсэл, өрөвч нинжин сэтгэл шаардлагатай байлаа. Хүн хэдийгээр олон нүгэл үйлдсэн ч, нүглээсээ илүү чухал юм гэдэгт Есүс итгэдэг байсныг мэдэх нь юутай сайхан билээ. Түүнийг “Сайн Хоньчин” гэдэгт гайхах хэрэг байна уу? Хонинууд нь замаасаа гажсан байна уу, өлссөн байна уу, арчаагүй дорой, даарсан эсвэл төөрсөн байна уу ялгаагүй Тэр бүгдийг нь хайрладаг байлаа.

Энэхүү агуу заах туршлагын төгсгөлд хайр энэрэл, өрөвч нинжин сэтгэлийн сургамж болсон нэг чухал шүлэг байдаг.



“Тэгээд Есүс тэдэнд дахин, Би бол ертөнцийн гэрэл мөн. Намайг дагадаг хүн харанхуй дотор явахгүй, харин амийн гэрэлтэй болно гэж айлдав” (Иохан 8:12).

Түүний гэрлийг дагацгаая. Энэ хэдэн үгийг олонтоо хэлж байцгаая. Эдгээр үгс хүн бүрийн сайн сайхны төлөө зориулагдсан юм гэдгийг би та нарт гэрчилж байна. ■

Зөв бичгийн дүрэм, цэг тэмдэг, том үсгээр бичих дүрмийг стандартын дагуу болгосон. Хэлсэн үгийн бүрэн бичлэгийг англи хэлээр сонсохыг хүсвэл speeches.byu.edu хаягаар орж үзнэ үү.



АВРАГЧ АМЬД

ГЭДГИЙГ МЭДСЭНЭЭС ИРДЭГ АМАР АМГАЛАН БА БАЯР БАЯСАЛ



Би Түүний ариун нэрийг гэрчлэх онцгой гэрчийн хувиар Есүс Христ бол амьд Бурханы тэнгэрлэг Хүү гэдгийг гэрчилж байна.

Би Арванхоёр Төлөөлөгчийн нэгнийх нь хувьд Арванхоёрын гишүүд хайрт Аврагчийнхаа тухай зааж, гэрчлэх онцгой боломжоо эрхэмлэн дээдэлдэг гэдгийг хэлж чадна. Бид Түүний амьдрал, үйлчлэл, мөнх бус амьдрал дахь Түүний үүрэг зорилгын тухай гэрчлэлээ хуваалцахад баяртай байдаг.

Аврагч арванхоёрдугаар сард төрөөгүйг бид мэддэг ч жилийн энэ үед Түүний даруухан төрөлтийг бид тэмдэглэдэг билээ. Их Эзэн дөрөвдүгээр сард төрсөн байх хамгийн их магадлалтай юм. Судар болон түүхийн баримт аль аль нь энэ цагийг хавар буюу Иудейн Дээгүүр Өнгөрсний Баярын ойролцоо гэсэн байдаг (С ба Г 20:1-ийг үз).

Түүний эх Мариа Иосефтой сүй тавьсныг судруудад тэмдэглэсэн байдаг (Матай 1:18; Лук 1:27-г үз). Тэдний сүй тавилтыг өнөө үеийн сүй тавилттай зүйрлүүлж болох юм. Ийм сүй тавилтын дараа гэрлэлтийн ёслол хийдэг.

Тэнгэр элч Габриел Мариа дээр хүрч ирсэн үед тэр бүсгүй мөнх бус амьдралд

гүйцэтгэх үүргийнхээ тухай мэдсэнийг Лукийн шастирт ийн өгүүлсэн байдаг:

“Орж ирээд тэнгэр элч түүнд, Ивээгдэгч ээ, баярла! Эзэн чамтай хамт байна гэв. . . .

“Тэнгэр элч түүнд, Мариа, бүү ай. Чи Бурханы ивээлийг олжээ.

“Үзэгтүн, чи хэвлийдээ үртэй болж хүү төрүүлнэ. Түүнийг чи Есүс гэж нэрлэх болно.

“Тэр Хүү агуу нэгэн болох ба Хамгийн Дээдийн Хүү гэж дуудагдана” (Лук 1:28, 30–32).

Х болон Дүсгүүдийг томоор бичсэнийг анзаарагтун, Бидний Тэнгэрлэг Эцэг бол Хамгийн Дээд юм. Есүс бол *Хамгийн Дээдийн Хүү* мөн.

“Мариа тэнгэр элчид, Би онгон атал энэ нь яаж бүтэх билээ? гэхэд,

Тэнгэр элч түүнд “Ариун Сүнс чам дээр ирж, Хамгийн Дээдийн хүч чамайг бүрхэнэ. Тиймээс төрөх ариун нэгэн нь Бурханы Хүү гэж дуудагдах болно” (Лук 1:34–35) гэв.

Иосеф, Мариа хоёр гэрлэхээс өмнө Мариа Ариун Хүүхдийг хэвлийдээ олж хөл



**Ахлагч
Рассел М.Нелсон**

Арванхоёр
Төлөөлөгчийн Чуулгын

хүнд болсон байв. Албан ёсоор гэрлэлгүйгээр жирэмсэн болсон эмэгтэйд оноодог шийтгэлээс түүнийг хэлтрүүлэхийн тулд Иосеф Мариагаас нууцаар салъя гэж бодож байжээ (Матай 1:18–19-ийг үз), Иосефыг ингэж бодож байтал тэнгэр элч Габирел түүн дээр хүрч ирэн:

“Давидын хүү Иосеф оо, Мариаг эхнэрээ болгохоос бүү эмээгтүн. Учир нь түүнд олоод байгаа нь Ариун Сүнснийх юм.

Түүнийг хүү төрүүлэхэд, чи Түүнийг Есүс гэж нэрлэ. Учир нь Тэр Өөрийн ард түмнийг нүглээс нь аварна гэж хэлжээ (Матай 1:20–21).

Есүс гэдэг нэрийн гүнзгий утгыг Мариа, Иосеф хоёрт заах хэрэг байсангүй. Еврей хэлэн дэх энэ үгийн язгуур нь *Жехошуа* гэдэг үгнээс гаралтай бөгөөд “Иехова бол аврал” гэсэн утгатай ажээ.¹ Иймээс удалгүй Есүс хэмээн нэрлэгдэх Их Эзэн Бурхан Иеховагийн ажил бол аврал байлаа. Тэрбээр дэлхийн Аврагч болох ёстой байв.

“Бурханы хүлцлийг мэдэх үү, та” хэмээн асуусан тэнгэр элчтэй Нифай ярилцсан тухай бид Мормоны Номноос уншдаг.

Нифай хариулсан нь, “Тэрбээр хүүхдүүдээ хайртайг нь мэднэ, би; тийм болохоор, бүх зүйлүүдийн утгыг мэдэх нь үгүй би хэмээв.

“Мөн тэр надад хандан: Болгоогтун, таны харж буй тэр онгон бүсгүй бол Бурханы Хүүгийн махан бодь биеийг төрүүлэгч эх нь бөлгөө хэмээв.

“. . . Тэр бүсгүйг Сүнс авч одохыг би харав; мөн Сүнс бүсгүйг авч одсоны дараа хэсэг байзнаад тэнгэр элч надад хандан: Харагтун! хэмээв.

“Мөн би сайхь онгон бүсгүйг харж, гар дээрээ хүүхэд тэвэрсэн байхыг болгоов.

“Мөн тэнгэр элч надад хандан: Бурханы Хургыг, тийм ээ, бүр Мөнхийн Эцэгийн Хүүг болгоогтун! Эцэгийнхээ харсан тэр мод ямар учиртайг мэдэв үү, та? хэмээв. (1 Нифай 11:16-21).

Лукийн эшлэлүүд

Лукийн 2-р бүлэг дэх: “Тэр өдрүүдэд газар бүрд хүн амын тооллого явуулах тухай Цезарь Августын зарлиг гарчээ” (Лук 2:1) гэсэн шастир бол Христийн Мэндэлсний Баярын үеэр бидний дуртай уншдаг, хэн бүхний мэдэх, үнэ цэнэтэй цэдэг юм.

Энэ бол хүн бүрд татвар оногдуулах зорилгоор хийдэг байсан хүн амын тооллого, Ромын эзэнт гүрний иргэний харьяалалын бүртгэл байлаа. Херод хаан хүмүүсийг төрөлх нутагт тоолох ёстой гэсэн захирамж



өгсөн байж. Тэр үед Назарт сууж байсан Мариа, Иосеф хоёр өмнө зүг, ойролцоогоор 145 км зайтай оршдог Давидын хотруу явах шаардлагатай байв. Хэрэв тэд Назар, Бетлехем хоёрын дунд орших, хүмүүс нь иудейчүүдэд дайсагнан ханддаг Самари мужийг тойрч явбал бүр ч хол аялах байсан биз ээ.

Тэд мөн төрөлх нутагтаа дуудагдсан төрөл төрөгсөдтэйгөө хамт явсан нь бараг тодорхой юм. Энэхүү хүнд хүчир аялалд тэд нохой, илжиг зэрэг гэрийн амьтдаа авч явсан нь эргэлзээгүй. Тэдний аялалд гурав юм уу дөрөв хоног шаардлагатай байсан учир нэлээд хэдэн



Мариа, Иосеф хоёрын буусан каравансерай (буурчийн газар) тэгш өнцөгт хэлбэртэй, аянчдын мал амьтад байрладаг хүмүүс амардаг байсан болов уу гэмээр голын хашааг бүхээгээр хүрээлсэн.

шөнө хээр буудалласан байж таарна. Тэднийг Бетлехемд хүрч ирэхэд Ариун Хүүхдийн төрөх цаг болсон ажээ.

“Тэр ууган хүүгээ төрүүлж, Түүнийг даавуунд ороож тэжээлийн тэвшин дотор тавив. Учир нь дэн буудалд тэднийг хоноглуулах өрөө байсангүй (Лук 2:7).

Энэ шүлэг Шинэ Гэрээний грек хэлний эх сэдвээс авсан нэг үгийн утга, тэр нутгийн тэр үе дэх зан заншлын тухай мэдлэгээр арвин баялаг юм. “Дэн буудал” гэсэн үг *каталума гэж орчуулагддаг байжээ*.² Грек хэлний *ката* гэдэг утгвар үг цаг хугацаа болон газарзүйн хувьд “доош” гэсэн утгатай. *Ката* утгвар үг *лума*-тай нийлж, хүмүүс аянаасаа завсарлан амардаг газар гэсэн утгатай үг үүсгэдэг ажээ. Грек хэлний Шинэ Гэрээнд *каталума* гэдэг үг өөр хоёр хэсэгт гардаг бөгөөд хоёуланд нь “дэн буудал” гээгүй “зочны өрөө” (Марк 14:14; Лук 22:11) гэсэн байдаг.

Тэр үед мөн тэр газарт Азийн дэн буудал нь орчин үеийн зочид буудалтай адилгүй байжээ. Тэр үеийн хоноглох газар нь аяны цуваа, түүний дотор хүмүүс бүр тэдний унаа хөсөг болох мал амьтанд зориулсан байр юм. Аянчдын буюу жингийн цуваа тэр үед (одоо ч ингэж нэрлэгддэг) *каравансерай (буурчийн газар)* буюу *аянчдын хоноглож амрах газарт буудаг байжээ*. Толь бичигт эдгээр нэр томъёог дорно зүгийн (эсвээс Азийн) орнуудад аянчид шөнө буудаллаж амардаг, хашаагаар хүрээлэгдсэн дэн буудал хэмээн тайлбарласан байдаг.³

Ийм дэн буудал нь ихэвчлэн тэгш өнцөгт хэлбэртэй, аянчдын мал амьтад байрладаг гол төв дэх хашааг бүхээгүүдээр хүрээлсэн байх бөгөөд тэнд аянчид амардаг

байжээ. Бүхээгнүүд нь мал амьтадаас арай дээр байрлалтай, эзэд нь мал амьтдаа харж байх цонхтой байсан ажээ. Лук 2:7-гийн Иосеф Смитийн орчуулга, “дэн буудлуудад” тэдэнд өрөө байсангүй гэдгийг аянчдын хоноглож амардаг бүх бүхээг хүнтэй болсныг харуулдаг.

Дэн буудлын эзэд зочломтгой бус тэр ч байтугай дайсагнасан байдалтай байсан тухай бодол санаа буруу бололтой. Тэр үеийн хүмүүс одооных шиг зочломтгой байсан нь эргэлзээгүй. Ялангуяа Иерусалим болон хөрш зэргэлдээ Бетлехемийн үндсэн хүн ам орон нутгийн хүмүүсийн дунд олон садан хамаатантай байснаас энэ нь бүр ч үнэн байж болно

Азийн аянчдын хоноглох газарт мал амьтдаа шөнө хашааны буланд хашиж манадаг байжээ. Ийм хашаанд илжиг, нохой, хонь, магадгүй тэмээ, үхрээ хаших бөгөөд мал амьтдын ялагдас хөглөрч, үнэр нь тархдаг байж.

Малын хашааг хүрээлсэн зочны өрөөнүүд хүнээр дүүрсэн учир Иосеф Мариаг каравансерайн хашааны голд малтай хамт байлгахаар шийдсэн бололтой. Энэ нь Бурханы Хурга ийм доогуур нөхцөлд төрснийг харуулсан байж болох юм.

Лук 2-т даавуунд өлгийдсөн гэсэн үг хоёр удаа гардаг. “Түүнийг даавуунд ороож” (Лук 2:7) гэсэн үг ямар утгатай вэ? Би энэ үгийг жирийн живх юм уу эсвэл өлгий болгож ашигладаг хөнжил гэж бодохгүй байна. Монгол хэлний орчуулганы гурван үгний оронд грек хэлний Шинэ Гэрээнд ганцхан үг хэрэглэсэн байдаг. Энэ үг бол *спарганоо* буюу сая төрсөн хүүхдийг хажуу талаас нь нөгөө хажууруу ороож өлгийдөх, тусгай нарийхан бөс даавуу гэсэн утгатай юм.⁴ Ийм

даавууг аль гэр бүлийнх болохыг нь тусгай тэмдгээр таньдаг байсан бололтой. Ийм зан үйлийг ялангуяа ууган хүүг төрөхөд үйлддэг байжээ.

Тэнгэр элч ийн мэдэгдсэн юм. “Тэжээлийн тэвшинд байх даавуунд өлгийдсөн нялах хүүхдийг та нар олж харна. Энэ нь та нарт тэмдэг болно” (Лук 2:12). Түүний өлгийдсөн даавуу бусдаас ялгархуйц, онцгой байсан байх ёстой.

Харин тэжээлийн тэвшний тухайд? Тэжээлийн тэвш гэдэг нь малын хашаанд байдаг, мал тэжээх зориулалттай тэвш буюу задгай хайрцаг юм. Хашааны бохир шалнаас дээр байдгаараа тэжээлийн тэвш тэндээ хамгийн цэвэрхэн газар байсан нь лавтай. Тэжээлийн ийм тэвш бидний Их Эзэнд өлгий болсон гээд бод л доо!

Аврагчийн онцгой угсаа гарал

Аврагч туйлын даруухан нөхцөлд төрснөө илүү чухал зүйл бол Түүний угсаа гарал юм. Нэлээд хэдэн судар, “Хэн Түүний удмын тухай бодох вэ?” гэж асуусан байдаг. (Исаиа 53:8; Үйлс 8:33; Мозая 14:8; 15:10). Энэ нь “Хэн Түүний угсаатай хамаатай болох вэ?” гэсэн утгатай юм. Эдүгээ хоёр мянган жилийн дараа бид Есүс Христ үхэшгүй мөнхийн Эцэг, мөнх бус эх хоёроос төрсөн хэмээн тунхаглаж байна. Есүс үхэшгүй мөнхийн Эцэгээсээ үүрд амьдрах хүчийг өвлөн авсан юм. Тэрбээр мөнх бус эхээсээ биеийн үхлийн хувь тавиланг өвлөн авсан билээ.

Хүмүүс амь насанд нь заналхийлсэн үед Есүс дээрх шинж чанаруудыг хүлээн зөвшөөрч: “Хэн ч Миний амийг авахгүй. Харин Би өөрийн санаагаар түүнийг өгнө. Амиа өгөх эрх мэдэл Надад бий. Буцааж авах эрх мэдэл ч Надад бий. Энэ тушаалыг Би Эцэгээсээ хүлээн авсан юм (Иохан 10:18) гэжээ.

Түүний угсаа гарлын энэхүү онцгой шинж нь бүх хүн төрөлхтний нүглийг цагаатгах Түүний үүрэг зорилгод зайлшгүй чухал байсан юм. Тийнхүү, Есүс Христ үхэхийн тулд төрж, үхээд дахин мөнх амийг олж боссон билээ (3 Нифай 27:13–15-ыг үз). Бид дахин амьдарч болохын тулд Тэр үхсэн юм. Бүх хүмүүс үхлийн ялзралыг ялж, дахин амьдарч болохын тулд Тэрбээр төрсөн билээ (1 Коринт 15:55; Мозая 16:7–8; Алма 22:14; Мормон 7:5).

Хөдс цусны дусал мэт дусалж байсан Гетсеманид

(Лук 22:44), түүнчлэн “гавлын газар” буюу үхэл гэсэн утгатай Голгота (эсвэл Калвари) дээр Түүний бие загалмай дээр өргөгдсөнөөр Цагаатгал хийгдсэн юм (Марк 15:22; Матай 27:33; мөн 3 Нифай 27:14-ийг үз). Энэхүү хязгааргүй Цагаатгал төгсгөлгүй үхлээс хүмүүнийг чөлөөлсөн юм (2 Нифай 9:7 -г үз). Аврагчийн Цагаатгал амилаалт, мөнх амьдралыг бүх хүмүүст боломжтой болгосон билээ. Түүний Цагаатгал бүх хүн төрөлхтний түүхэнд гол үйл явдал болсон юм.

Бошиглогч Иосеф Смит Цагаатгалын ач холбогдлыг онцлон тэмдэглэж, “Манай шашны тулгуур зарчим бол Есүс Христ егүүтгэлээр наснаас хальж, оршуулагдаад, гурав дахь өдрөө амилж, тэнгэрт дээшлэн одсон тухай Бошиглогчид, Төлөөлөгчдийн гэрчлэл юм. Ийнхүү манай шашинд холбогдолтой бусад бүх зүйл нь ердөө л эл гэрчлэлийн хавсралтууд юм” гэж хэлсэн билээ.⁵

Хэдэн жилийн өмнө Аврагчийн мэндэлсний 2000 жилийн ой ойртож байсан үед энэхүү тунхаглал нь Тэргүүн Зөвлөл ба Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгад агуу сүнслэг удирдамж болсон юм. Хаант улсын түлхүүрүүдийг итгэмжлэл хүлээн авсан бидний 15 хүн гэрчлэлээ бичихээр бэлтгэж байлаа. Бид гэрчлэлээ “Амьд Христ: Төлөөлөгчдийн гэрчлэл” гэж нэрлэсэн юм.⁶ Тэр үед амьд байсан 15 Төлөөлөгч энэ гэрчлэлд гарын үсгээ зурсан юм.

Их Эзэний тухай гэрчлэлтэй хүн бүр Түүний бурханлиг угсаа гарлыг мэдэж, Есүс бол амьд Бурханы Хүү гэдгийг итгэлээр гэрчлэх онцгой боломжтой юм. Эцэг Хүү хоёр Бошиглогч Иосеф Смит дээр хүрч ирсэн тухай баримт энэхүү гэрчлэлд багтдаг. Түүний төрсөн өдрийг бид арванхоёрдугаар сарын 23-нд тэмдэглэдэг билээ. Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүм үнэн бөгөөд Түүнээс хүлээн авсан удирдамж чиглэлд хариулдаг, эрх олгогдсон удирдагчдад өгдөг бошиглол болон илчлэлтээр дамжуулан амьд Их Эзэн энэ Сүмийг удирддаг гэсэн баримт энэ гэрчлэлд багтдаг юм.

Ороо бусгаа өнөөгийн цаг үед энэ мэдлэг бидэнд амар амгаланг авчирч байна. “Зоригтой байгтун, мөн бүү эмээ, учир нь Их Эзэн бибээр та нартай хамт байна мөн та нарын дэргэд зогсч байх болно, мөн та нар Миний тухай, бүр Есүс Христийг, би бол амьд Бурханы Хүү, Би байсныг, Би байгааг, Би байх болно гэдгийг



*Аврагчийн Цагаатгал амилалт,
мөнх амьдралыг бүх хүмүүст
боломжтой болгосон билээ. Түүний
Цагаатгал хүн төрөлхтний түү-
хийн гол үйл явдал болсон юм.*

гэрчлэх ёстой” (С ба Г 68:6) хэмээн Их Эзэн хэлсэн билээ. Бид Түүний энэхүү ариун амлалтыг дээдэлж, сэтгэл зүрхэндээ ямагт хадгалж явдаг.

Түүнд өргөх бидний бэлэг

Хүнд өдрүүд бидний өмнө байна. Нүгэл хилэнц газар авсаар байна. Сүмийн гишүүд хавчлагыг тэсэн гарна гэдгийг Паул угтан харсан юм (2 Тимот 3:1–13; С ба Г 112:24–26 -г үз). “Хэрэв Христийнх гэдгээсээ болж зовдог бол бүү ич. Харин энэхүү нэрээрээ Бурханыг алдаршуул” (1 Петр 4:16) хэмээн Петр зөвлөсөн билээ. Есүс бүхнээс дээгүүр босч ирэхийн тулд бүхнээс доогуур бууж ирсэн юм. Тэрбээр Өөрийнхөө үлгэр жишээг дагахыг биднээс хүсэн хүлээдэг билээ. Бид бүгд Түүний буулгыг авснаар бидэнд тохиолддог аливаа сорилт бэрхшээл хэчнээн хэцүү байлаа ч, тэдгээрийг даван туулж чадна (Матай 11:29–30-ийг үз).

Бидний төлөө Аврагчийн хийсэн, хийж байгаа бүх зүйлийг цэгнэн бодож үзээд, бид хариуд нь Түүнд зориулан юу хийж чадах вэ? Христийн Мэндэлсний Баяраар Их Эзэнд бидний өгч чадах хамгийн сайн бэлэг бол өөрсдийгөө дэлхийгээс толботуулалгүй, Түүний ариун сүмд орохоор зохистой байх явдал мөн. Харин бидэнд өгөх Түүний бэлэг бол Тэрбээр хэзээ ч хүрч ирлээ гэсэн бид Түүнийг утгахад бэлэн байгаагаа мэдэхээс ирдэг амар амгалан байх болно.

Их Эзэний үйлчлэлийн бүрэн байдал ирээдүйд тохиох болно. Түүний Хоёр дахь Ирэлтийн тухай бошиглолууд гүйцэлдсээр байна. Мэдээж хэрэг, Бид Христийн Мэндэлсний Баяраар Түүний төрөлт дээр

анхаарал төвлөрүүлдэг. Энэ дэлхийд Тэрбээр дахин ирэх болно. Есүсийн анхны ирэлт нууцлаг байсан юм. Зөвхөн мөнх бус хэдхэн хүмүүс л Түүний төрөлтийг мэдэж байв. Харин Түүний Хоёр дахь Ирэлтээр бүх хүн төрөлхтөн Тэрбээр эргэж иржээ хэмээн мэдэх болно. Харин одоо Тэр “дэлхий дээр аялагч хүн” (С ба Г 49:22) шиг бус, харин “Эзэний алдар илэрхийлэгдэж, бүх махан бие үүнийг хамтдаа үзэхээр” (Исаиа 40:5; мөн С ба Г 101:23-ыг үз) хүрч ирэх болно.

Би Түүний ариун нэрийг гэрчлэх онцгой гэрчийн хувиар Есүс Христ бол амьд Бурханы тэнгэрлэг Хүү гэдгийг гэрчилж байна. Хэрэв та нар Түүнийг хайрлаж, зарлигуудыг нь сахвал Тэр та нарыг хайрлаж, өргөн дэмжиж, Өөрийгөө та нарт харуулах болно (Иохан 14:21-ийг үз). Амьдрал дээр, ухаант мэргэн эрэгтэйчүүд, эмэгтэйчүүд Түүнийг шүтэн биширсэн хэвээр байна. ■

2002 оны арванхоёрдугаар сарын 10-нд Бригам Янгийн Их Сургуулийн онцгой цугларалтад хэлсэн үгнээс Англи хэл дээрх бүрэн эхнийг speeches.byu.edu-гээс үзнэ үү.

ЭШЛЭЛ

1. Эрик Д.Хантсман, “Glad Tidings of Great Joy,” *Ensign*, 2010 оны 12-р сар, 54-ийг үзнэ үү.
2. Жеймс Стронг, “Greek Dictionary of the New Testament,” *Strong's Exhaustive Concordance of the Bible* (1890), 39, 40-өөс 2,596, 2,646 дугаартай үгийг үзнэ үү.
3. *Merriam-Webster's Collegiate Dictionary*, 11 дэх хэвлэл (2003), “caravansary,” “khan” гэсэн үгсийг үз.
4. “Greek Dictionary of the New Testament,” 66 дахь 4683 дугаартай үгийг үз.
5. *Teachings of Presidents of the Church: Joseph Smith* (2007), 98; онцлон тэмдэглэлт нэмэгдсэн.
6. “Амьд Христ: Төлөөлөгчдийн гэрчлэл *Луахона*, 2000 оны 4-р сар, 2–3-ыг үз.



Ариун сүмд ХҮРЭХ ЗАМ

*Сүмийн гишүүд олон янзын замыг сонгодог ч,
Украины Хожмын Үеийн Гэгээнтнүүд ариун сүм рүү
хөтөлдөг зөв замыг олжээ.*

Чад Э.Фарез

Сүмийн сэтгүүлүүд

Үүр цайхаас өмнө Украины Киевийн Килцева замаар машинаар явсан зорчигчдод Украины Киевийн ариун сүм рүү харьцангуй нам гүмхэн зам хөтөлнө. Замын жижигхэн хонхоруудыг тойрон гарах цөөхөн машины гэрэл өглөөний мананг нэвтлэн холоос сүүмэлзэнэ.

Ариун сүмийн бүдэг гэрэл гэрэлт цамхаг лугаа адил ариун сүм рүү очих замыг зорчигчдод зааж өгнө.

Тус ариун сүмийг 2010 оны наймдугаар сард онцгойлон адисалснаас хойш зарим хүмүүс ариун сүм рүү хөтлөх энэ намуухан замыг дагаснаараа адислагдсан бол, бусад нь ариун сүмд хүрэх тэдний зам тийм ч амар хялбар байгаагүйг нотлон хэлж чадна.

Өглөө болж, нар мандахад машин, автобуснууд Килцева замаар багтаж ядан цувна. Саяхан нам гүмхэн байсан зам машинаар пиг дүүрч, дуу шуугиан ихтэй машины зогсоол шиг болжээ.

Машинаар явахад замын хөдөлгөөн заавал нөлөөлнө гэдгийг мэддэг болохоор ариун сүмд явагч олон хүн зам дээр үлдэж, дараачийн зогсоолд хүрэхээс өмнө


тэвчээртэйгээр хэдхэн метр ахьдаг байлаа. Ариун сүм хүрэх яагаач үгүй байдаг, гэтэл машинаар явахад удаан байлаа.

Зарим хүмүүс өөр замыг сонгодог. Ариун сүмийн ар талд олон салаа шороон зам, бөглүү гудамжнууд байдаг. Замыг тодорхой тэмдэглээгүй учир жолооч нар амархан төөрч мэднэ. Гэвч жолооч дээшээ харвал, бүхнийг ариун сүмд ирэхийг урин, хөтчийн үүрэг гүйцэтгэж буй ариун сүмийн шовх ганжирыг олж харна.

Их Эзэний өргөөнд хүрэх Украины гишүүдийн сүнслэг зам ариун сүмийн эргэн тойрон дахь машин замуудтай адилгүй юм.

Зарим залуу гишүүд Сүмд өссөнөөрөө адислагдсан бөгөөд эдүгээ өөрсдийн ёслолын ажлыг хийлгэхийн тулд Украины Киевийн Ариун сүмд орох боломжтой байгаа бол бусад олон хүмүүс тэнд очихын тулд сүнсний хүнд хүчир замаар машинаар явж хүрчээ.

1998 онд Ерөнхийлөгч Гордон Б.Хинклийн (1910–2008) зарласан ариун сүм 2010 онд дууссан юм. Тэр 12 жилийн турш Украины Киев гадасны гишүүд хөдөлгөөн



Дээрээс: Асия Чимизова, Николай Чимизов хоёр Украины Киевийн Ариун сүмийг онцгойлон адисалснаас хойш гурав хоногийн дараа лацдан холбуулжээ. Петр Михайленко, Адалина Михайленко нар ач охин Машагаа эх орондоо ариун сүмд орохоор тэсч ядан хүлээж байгаад нь баяртай байна. Андрей Дудка, Валентина Дудка нар ариун сүмийг баригдаж байх үеэс газар дээр олон удаа очжээ.

нь удаан юм шиг санагдах нарийн зам дээр байж, ариун сүм дуусахыг тэвчээртэйгээр хүлээж байлаа. Зарим хүмүүс өөр замаар явж, ариун сүмийн зорилгоо түр зуур хараанаасаа алдаж байлаа.

Ариун сүмд хүрэхийн тулд гишүүдийн сонгодог сүнсний зам ялгаатай ч гэсэн Украины итгэлтэй гишүүд ариун сүм рүү хөтөлдөг бүх зөв замыг олж байна.

Шулуун зам

Зүүн Европын насанд хүрсэн олон залуу гишүүд бага насандаа сайн мэдээ рүү удирдагдсан билээ. Ийнхүү бага наснаасаа сайн мэдээний тухай мэдлэгтэй болсон нь гэрчлэлээ залуу наснаасаа эхлэн хөгжүүлэх төдийгүй мөн ариун сүмд гэрлэх шийдвэр төгс байдлыг төлөвшүүлэх боломжийг тэдэнд олгож байна.

Харьков тойргийн гишүүн Николай Чимизов түүний эхнэр Асия хоёр залуу насандаа сайн мэдээтэй танилцсан бөгөөд тэр үед Николай наймтай, Асия аравтай байжээ.

“Би баптисм хүртсэн цагаасаа эхлэн Тэнгэрлэг Эцэгийн төлөвлөгөө бол өргөмжлөлд хүрэх зам мөн гэдгийг мэдсэн” гэж Чимизов ах хэллээ. “Тэр бүлийн үүрэг зорилгын тухай Сүмийн сургаал надад үргэлж чухал байлаа.”

Чимизова эгч мөнхийн гэр бүлийн ач холбогдлыг мөн л бага насандаа ойлгожээ. “Намайг залуу эмэгтэйн хувьд сүмд явдаг байхад ариун сүмийн гэрээнүүд хийх нь хэчнээн чухал болохыг заадаг байсан. “Би ариун сүмд гэрлэхийг үргэлж мөрөөддөг байлаа. Иймээс ариун сүмд гэрлэхээр зохистой байхыг ямагт хичээдэг байсан.”

Хосууд 2009 онд анх танилцаж болзож эхэлсэн байна. Хайр сэтгэлтэй хоёрын яриа гэрлэх сэдэв рүү ороход дараагийн алхам нь юу байхыг тэр хоёр аль хэдийн мэдэж байлаа. “Киевийн Ариун сүмийг 2010 оны наймдугаар сард онцгойлон адисална гэж зарлахад бид хоёр тэнд лацдан холбуулахаар шийдсэн” гэж Чимизова эгч хэллээ.

“Бид хоёр удаан хүлээгээгүй нь сайхан хэрэг шүү” гэж Чимизов ах хэлэв.

Тэр хоёр 2010 оны есдүгээр сарын 1-нд гэрлэлтээ лацдан холбуулжээ.

“Энэ бол миний амьдралд хамгийн гайхамшигтай сайхан өдөр байлаа. Би хайртай Асиягаа сугадан, түүнийг Их Эзэний өргөөнд дагуулж орсноор адислагдсанаа мэдэрсэн. Тэр өдөр миний мөрөөдөл мөнхийн гэр бүлээ төвхнүүлэх мөрөөдөл минь биелсэн гэж хэлэхэд сайхан байна” гэж Чимизов ах яриув.

Урт зам

Мөнхийн гэрлэлт хийлгэх зам Виноградарский тойргийн гишүүн Петр Михайленко, Адалина Михайленко хоёрын хувьд шулуун атлаа их урт байжээ. Михайленкогийнхан Сүмд нэгдсэн Украины анхны гэр бүлүүдийн нэг бөгөөд тэд Киевт анхны салбар байгуулагдсанаас хойш хоёр жилийн дараа 1993 онд баптисм хүртсэн ажээ.

Хэдий тийм ч ариун сүмээс хол амьдардаг гэдгээс гадна зарим хүчин зүйлс гэр бүлийн энэ хосыг лацдан холбуулахад саад болж байлаа. Гэвч тэд үүнээс болж ухарсангүй, хоёр биендээ болон мөнхийн гэрлэлт хийлгэх мөрөөдөлдөө чин үнэнч байлаа.

“Би ариун сүмд лацдан холбуулахыг тэвчээртэй хүлээсэн шүү. Сүмийг орхих тухай бодол огт байгаагүй. ариун сүмд хүрэх зам үргэлж тодорхой байсан” гэж Михайленко ах хэллээ.

Ерөнхийлөгч Томас С.Монсон 2010 оны наймдугаар сард адисалснаас хойш энэ гэр бүлийн хосын лацдан холбуулах хүсэл нэн их болсон гэнэ. Бид хоёр лацдан холбуулах өдрөө ариун сүм нээгдэх яагаач үгүй байхад бүр эрт очиж билээ” гэж Михайленко эгч хэллээ.

Энэ гэр бүлийн хос ганцаархнаа байсангүй. Тойргийнх нь олон гишүүд тэр өдөр Михайленкогийнхны баярыг хуваалцахаар ариун сүм дээр ирсэн байв.

“Лацдан холболт үнэхээр сайхан байсан шүү. Хайртай хань ижлээ тэр өдрийнх шигээр хэзээ ч тийм ихээр хайрлаж байгаагүй юм шиг мэдрэмж төрж билээ” хэмээн Михайленко эгч ярилаа.

Хайрын мэдрэмж тэр өдрөөс хойш улам хүчтэй болсон гэнэ. “Бидний харилцаанд эрс өөрчлөлт гарсан. Бид хоёр гэрлээд удаж байгаа улс, гэвч хайрын мэдрэмж огт өөр болжээ. Бид хоёр бие биенийхээ төлөө улам ихийг хийхийг хүсч байна. Тэгэхдээ үүнийг илүү их хайраар хийх болно” гэж Михайленко ах ярилаа.

Эргээд зам дээрээ ирсэн нь

Виноградарский тойргийн гишүүн Андрей Дудка, Валентина Дудка нарыг хөршүүд нь 2003 онд сайн мэдээтэй танилцуулжээ. Гэр бүлийн энэ хос хэдэн долоо хоногийн турш номлогчидтой уулзсаны эцэст Сүмд нэгдэхээр шийдсэн гэнэ.

Дудкагийнхан хожмын үе дэх ариун сүмүүдийн хэрэгцээ, мөнхийн гэр бүлтэй байх боломж зэрэг сайн мэдээний үнэнүүдийг мэдсэндээ сэтгэл догдлон баяртай байсан ч, аажимдаа идэвхгүй болсон ажээ. “Бид сүмд явахгүй байх ямар нэг шалтаг олдог байлаа. “Их ядарчихлаа ч гэх юм уу, эсвэл телевизээр бидний үзэх дуртай нэвтрүүлэг гарах гэж байна шүү дээ гэхчлэн.

*Сүмийн үйл
ажиллагаа
явуулж байгаа
134 дэх ариун
сүм—Украины
Киевийн Ариун
сүм есөн орны
гишүүдэд үйл-
чилж байна.*

Дудка ах, эгч хоёр идэвх султай болсон нь тэдний аз жаргалд муу нөлөө үзүүлжээ. “Бид Сүмийг орхисныхоо дараа Сүмийн амьдрал, дэлхийн амьдрал хоёр үнэхээр ялгаатайг олж харсан. Бид аз жаргалгүй байлаа” гэж Дудка ах яриу.

Дудка эгч сүмд явалгүй дөрвөн сар орчим болсны дараа эргэлтийн цэгт хүрч очсон гэнэ. “Нэг ням гараг болоход ‘Хэрэв би өнөөдөр сүмд явахгүй бол, цаашид тэсэх аргагүй боллоо’ гэж би хэлж билээ. Чухамдаа олон өдөр усгүй явсан хүн шиг болчихсон байлаа. Надад ус хэрэгтэй байлаа” гэж Дудка эгч яриу.

Дудка эгч дахин идэвхтэй болсныхоо дараа нөхрийнхөө төлөө тэвчээртэйгээр залбирч, өөртэйгөө хамт сүмд эргэж очиход нь түүнийг дэмждэг байжээ. Түүнийг сүмд эргэж ирснээс хойш жил хагасын дараа нөхөр бас эргэж ирсэн гэнэ.

“Эхнэрийн минь залбирал надад нөлөөлсөн юм. Би Мелкизедек санваартны хувьд идэвхтэй гишүүн байх хариуцлагатайгаа ойлгосон. Бурхангүйгээр би юу ч хийж чадахгүйгээ ухаарсан” гэж Дудка ах ярилаа.

Дудка ах, эгч хоёрыг Сүмд эргэж ирсний дараа тэдний бодол санаа ариун сүмийн авралын ёслолуудад төвлөрөх болов. 2007 онд ариун сүмийн газар хөндөх ёслолыг харахаар энэ гэр бүлийн хос Украины бусад Хожмын Үеийн Гэгээнтнүүдтэй нэгдсэн ажээ.

“Ариун сүмийн барилгыг эхэлснээс хойш бид хоёр барилгын дэргэд олон удаа очиж, ажил хэрхэн хийгдэгийг хардаг байсан” гэж Дудка ахыг хэлэхэд,

“Барилгачид анхны чулууг тавихыг хараад би дээр үсэрсэн” гэж Дудка эгч хэллээ.

Тэнгэр элч Моронайн баримлыг ариун сүмийн орой дээр байрлуулахад олон Хожмын Үеийн Гэгээнтэн чанга тэврэлдэж, тэдний, ялангуяа Дудка, ах эгч хоёрын нулимс хацрыг нь даган урсаж байлаа.

“Ариун сүмийг барьж дуусахад бид тэнд орохоор зохистойгоо мэдээд санаа амарсан шүү” гэж Дудка ах хэллээ.

Ариун сүмд лацдан холбуулсан нь амьдралыг мөнхийн хэтийн төлөвийн үүднээс үзэх хүчтэй үзлийг тэдэнд төлөвшүүлсэн юм хэмээн Дудка ах, эгч хоёр ярилаа. “Танай гэр бүл одоо зөвхөн танай нөхөр, та хоёр биш, одоо Их Эзэн гэр бүлийн чинь хэсэг шүү дээ. Одоо бид хоёр бие биенээ мөнхийн мэлмийгээр хардаг болсон” гэж Дудка эгч хэллээ. ■

Боломжуудаа НЭЭХ ТҮЛХҮҮР

БОЛОВС- РОЛЫН ТАСРАЛТГҮЙ САНГИЙН 10 ЖИЛИЙН ОЙГ ТЭМДЭГЛЭВ



Ерөнхийлөгч Гордон Б.Хинкли Боловсролын Тасралтгүй Санг зарласнаас хойшхи арван жилд энэхүү санаачлага болон тус сангийн зээлд хамрагдагчид амжилттай байна.

Ребека Аткин
Сүмийн сэтгүүлүүд

Ерөнхийлөгч Бригам Янг (1801–77) Солт Лейкийн Хөндийд ирснээс хойш ердөө гуравхан жилийн дараа Хожмын үеийн Гэгээнтнүүдэд боловсрол олгохын тулд сургууль, их сургуулиудыг байгуулж эхэлсэн билээ. Энэ эрин үеийн бошиглогч бүр Сүмийн гишүүд боловсролтой болохыг урамшуулан дэмжсээр ирсэн юм.

Тэдний нэг нь Бригам Янгийн 19-р зууны өөр нэг санаачлага—Цагаачлалын Тасралтгүй Сангийн загвараар Боловсролын Тасралтгүй Санг (БТС) нэвтрүүлсэн Ерөнхийлөгч Гордон Б.Хинкли юм. Боловсролын энэ шинэ сан, Ерөнхийлөгч Томас С.Монсонгийн хэлснээр, Ерөнхийлөгч Хинклийн удирдлагын нэг ялгарах онцлог болсон юм.¹ Ядуу зүдүү амьдрал, боловсрол, сургалт дутмаг байдал нь чадавхиа бүрэн ашиглахад нь Сүм дэх олон залуу насанд хүрэгчдэд саад болж байсныг Ерөнхийлөгч Хинкли олж харсан юм. Тэрбээр үүний хариуг олохоор Их Эзэнд ханджээ.

2001 оны 3-р сарын 31-нд Ерөнхийлөгч Хинкли уг хөтөлбөрийн талаарх өөрийн үзэгдлийг зарласан юм. Тэрээр уг хөтөлбөр нь “зоримог санаачлага” гэдгийг хүлээн зөвшөөрсний сацуу “боловсрол бол боломжуудад нэвтрэх түлхүүр мөн” болохыг тэмдэглэн хэлсэн билээ.² Ерөнхийлөгч Хинкли энэ санд хандив өргөх хүсэлтэй бүхнийг урьснаар хөтөлбөр хэрэгжиж эхэлсэн билээ.

Эдүгээ 10 жилийн дараа, дэлхий даяарх ивээн тэтгэгчдээс ирсэн их, бага хандивууд уг хөтөлбөрийн зээлд хамрагдагчдад цэцэглэн хөгжих боломжийг олгоод байна. Гавьяат чөлөөндөө гарсан Далын гишүүн, ТБС-гийн Гүйцэтгэх захирал Ахлагч Жон Кармак, энэ сан “Гэгээнтнүүдийг ядуурлын зүхлээс аварч байна” гэж хэлжээ. Энэ сан мөнхийн зарчмууд дээр байгуулагдсан бөгөөд “бидний хэний нь ч ойгож чадахаас хавьгүй илүү үр дүнд хүрнэ” гэсэн бошиглолын амлалттай учраас ийм төрлийн авралд

Боловсролын
Тасралтгүй Сан
үйл ажиллагаагаа
эхэлснээс хойшхи
арван жилд 51 орны
50,000 орчим хам-
рагдагчийн, түүний
дотор Карибын
тэнгисийн арлуудын
Кевин Мооре болон
Перугийн (зүүн талд)
хамрагдагчдын амьд-
ралыг дээшлүүлжээ.



2001

НЭГДСЭН ХАМРАГДАГЧДЫН ТОО: ЖИЛЭЭР

2011



БТС-ГИЙН ЗЭЭЛД ХАМРАГДАГЧИД ТООГООР

Боловсролын Тасралтгүй Сан өнгөрсөн 10 жилд дэлхийн 51 орны 50,000 гаруй хамрагдагчдын амьдралыг адисалжээ. Эдгээр залуу насанд хүрэгчдийн тухай статистикийн зарим мэдээ баримтыг доор харуулав:

- Зээлд хамрагдагчдын 47 хувь нь эрэгтэйчүүд, 53 хувь нь эмэгтэйчүүд,
- 34 хувь нь гэрлэсэн хүмүүс байна.
- Эрэгтэйчүүдийн 80 хувь нь буцаж ирсэн номлогчид байна.
- 82 хувь нь ажиллахын хажуугаар суралцаж байна.
- Тэдний дундаж нас 24.5 байна.
- Суралцаж байгаа хугацаа нь дунджаар 2.6 жил байна.
- Сургалтын дараа тэдний орлого өмнөхөөсөө гурваас дөрөв дахин их байна.

амжилттай байгаа шүү гэж БТС-гийн сургалт, холбоо мэдээлэл хариуцсан сайн дурын захираал Рекс Аллен хэллээ.

Зоримог санаачлага

Уг сан үндсэн зээлээс бий болсон хүүгийн хандиваар бий болсон мөнгийг оюутнуудад зээлдгийг Ерөнхийлөгч Хинкли 2001 онд тайлбарласан билээ.

Сангийн зээлд хамрагдахыг сонирхсон залуу насанд хүрэгчид орон нутгийн санваартны удирдагчид, институтын захирлуудад хандаж болно. Тэднийг баталсан тохиолдолд “хүсэл эрмэлзэл бүхий залуу эрэгтэйчүүд, эмэгтэйчүүд,” тэдний дотроос буцаж ирсэн олон номлогч улс орныхоо сургуулиудад суралцахаар зээл авдаг.³ Тэд сургуульд сурч байх хугацаандаа зээлээ төлж эхэлдэг нь уг санг ашиглах боломжийг бусад оюутнуудад олгодог.

Энэ хөтөлбөр гараагаа эхэлснээс хойшхи арван жилд 50 илүү ороны 50,000 орчим хамрагдагчийн амьдралыг дээшлүүлж, Ерөнхийлөгч Хинклийн хэлсэнчлэн, “өөрсдөө болон өөрсдийнх нь өмнөх олон үеийнхний мэдэх ядуурлаас ангижрахад нь тэдэнд тусалсан ажээ.”⁴

Аллен ах БТС-г ийн дүрсэлжээ “Тэр үед бошиглогч үнэхээр гайхалтай зүйлийг хийсэн юм. Эрт үед Мосе таягаараа Улаан Тэнгисийг зангахад ус нь хуваагдсан билээ. Ерөнхийлөгч Хинкли мөн ийм итгэлээр бошиглогчийн нөмрөгөө ядуурлын хар тэнгис дээгүүр зангаж, БТС-г санаачилсан юм хэмээн зүйрлүүлж болно.”

Зарчмууд

Боловсролын Тасралтгүй Сан сайн мэдээний зарчмууд—Есүс Христэд итгэх итгэл найдвар, боловсрол, ажил хөдөлмөр, золиослол, бие даах чадвар, ёс суртахуун болон үйлчлэл дээр тулгуурладаг. БТС-гийн зээлд хамрагдагчид болон төгсөгчид дэлхий даяар эдгээр зарчмуудыг амьдралдаа хэрэгжүүлж байна.

БТС бол “найдварын гэрэл”, “[өөрийг нь] удирдан, дэвшил хөгжлийн замыг нээж өгсөн Тэнгэрлэг Эцэгийн тусламжийн

нотолгоо” байлаа гэж Колумбын төгсөгч Каролина Телло Варгас хэллээ.

Тэрээр боловсрол, ажил хөдөлмөр болон үүнд зориулан золиослол хийхийн ач холбогдлыг ойлгосон ажээ. Каролина БТС-гийн зээлд хамрагдахаасаа өмнө нэлээд хэдэн ажил хийж байсан гэнэ. Тэгээд хуулийн мэргэжлээр суралцахын тулд бүх үнэт эдлэлээ заржээ. Гэр бүл нь ч бас золиослол хийсэн аж.

“Суралцахын тулд золиослол хийх ёстойгоо би мэдсэн. Ирээдүйд илүү сайн ажлын боломж олдох учраас би золиослол хийх хүсэлтэй байсан” гэж Каролина ярилаа.

Гэвч сургуульд ороод нэг жил болж байтал гэр бүлд нь нэг асуудал гарч сургалтын төлбөрөө төлж чадахааргүй болжээ. Тэр БТС-гийн зээл авч, сургуулиа амжилттай төгссөн гэнэ.

Өмнөд Африкийн Шерли Мвелаэе мөн дээрх зарчмуудыг хэрэгжүүлж амжилт олсон ажээ. Тэрээр БТС-гийн зээлийг компьютерын программын курс төгсөхөд ашиглаж, даатгалын компанид ажилд орсны дараа зээлийнхээ үлдэгдлийг шуурхай төлснөөр “итгэл дааж” чадсанаа мэдэрсэн байна.

“Сайн цалинтай ажил гэдэг амьдрахад хэрэгтэй чухал нэгэн чадвар билээ. Энэ нь би эцэг эхдээ болон гэр бүлдээ тусалж чадлаа гэсэн үг. Ажлаасаа олж авсан ур чадварын өсөлт нь Сүмийн дуудлагуудаа илүү сайн хийхэд надад тусалсан юм” гэж Шерли яриу.

Компьютерын программчаар ажилласнаар тэр их амжилтанд хүрсэн гэнэ. “Хэрэв энэ курст суралцаагүй, сүмд байнга явдаггүй байсан бол, би ажилгүй байх байсан, энэ бүх сайхан зүйлсийн аль нь ч надад байхгүй байсан” гэж тэр ярилаа.

Амлалт ба адислал

Ерөнхийлөгч Хинкли Боловсролын Тасралтгүй Санг зарлахдаа уг сан хувь хүн, тэдний гэр бүл болон нийгмийг тэрчлэн ажил эрхлэлт, үйлчлэл, удирдлагын боломжуудаар дамжуулан Сүмийг бүхэлд нь



ЭХНИЙ 10 ЖИЛИЙН 10 ҮР ДҮН

БТС-гийн Гүйцэтгэх захирал Ахлагч Жон К.Кармак уг сан дараах үр дүнд хүрлээ гэж хэлжээ:

1. Бие даах чадвар, шударга зарчимч байдлыг төлөвшүүлж, хүлээсэн үүргээ биелүүлэн, гэр бүлээ тэтгэж байна.
2. Мөнхийн өсөлт дэвшилтэд дөхөм үзүүлэн, дараагийн амьдралд давуу тал болох оюун билгийг энэ амьдралд олж авч байна (С ба Г 130:18–19-ийг үз).
3. Чадварлаг удирдагчдыг төлөвшүүлэн, Сүмийн үйлчлэлд цаг заваа зориулах боломжтой илүү сайн ажилд орж байна.
4. Боловсролтой болсон хүнд ажлын олон боломж нээгдэж, тодорхой сургалт, ур чадвар хэрэгтэй ажилд тавигддаг шаардлагыг хангаж байна.
5. Амьдрал баялаг агуулгатай болж, мэдлэг өргөжин, оюун ухаан нээгдэж байна.
6. Өргөлийн хуулийн үзэл санаанд дэмжлэг үзүүлж, бүх хүмүүсийг хандив өргөж, нэг хүн шиг нэгдмэл байхад урьж байна (С ба Г 38:27-г үз).
7. Ядуусыг халамжлах болон Сүмийн үндсэн үүргийг биелүүлэхэд тусалж байна (С ба Г 81:5; 83:6-г үз).
8. Гэр бүлүүдийг бэхжүүлж, ядуурлын гинжийг эвдэж байна.
9. Дэвшилтэт уламжлалыг хөгжүүлэн, сайн мэдээний зарчмуудыг хэрэгжүүлж байна.
10. Золиослол хийх талаар Аврагчийн үлгэр жишээг даган, өөртөө байгаагаа бусдад туслахын тулд өгч байна.



адислах болно гэж амласан юм.

Зээлд хамрагдагчид “ядуурлын боолчлолоос өргөн гаргах сайн боловсролтой болох боломжтой болно гэдгийг . . . мөн тэд гэрлэж, ажлын ур чадвар эзэмшсэнээр сайн цалин авч, нийгэмд өөрийн байр суурийг олж, хувь нэмрээ оруулж чадна” гэдгийг Ерөнхийлөгч Хинкли амлажээ.⁵

БТС-гийн зээлд хамрагдсан мянга мянган залуус, түүний дотор Уругвайн Пабло Бенитезийн амьдралд энэ амлаалт биелэгдсэн юм. Пабло амьдралаа өөрчлөхөөр шийдсэн үед хүнсний дэлгүүрт өдөрт 12 цаг ажиллаж, амь зуулгаа дөнгөн данган залгуулдаг байсан гэнэ. Сургуульд орсон ч сургалтын төлбөр, татвар нэмэгдэж, зөвхөн сургалтын төлбөрөө ч төлж чадахгүй болжээ.

Тэр БТС-гийн зээлээр биеийн тамирын мэргэжлээр сургуулиа дүүргэх боломжтой болсон ажээ. Ингэснээр сүүлийн жилүүдэд хэдэн ч удаа ажлаа сольж чадсан бөгөөд, ингэх бүрд цалин нь нэмэгдэж байжээ. “Хэдийгээр надад бүрэн эсвэл хагас цагийн бусдыг орлон ажиллах ажлын санал олонтоо ирдэг ч цаг зав гардаггүйгээс хүлээж

Филиппиний буцаж ирсэн номлогч Мириам Эрквиза аялал жуулчлалын нэг компанид ажилд оржээ. Энэ ажил нь гэр бүлээ тэтгэхийн сацуу Залуу Эмэгтэйчүүдийн ерөнхийлөгч, институтын багшаар үйлчлэх боломжийг түүнд олгосон ажээ.



ХЭРХЭН ОРОЛЦОХ ВЭ?

БТС батлагдсан бүсүүдэд амьдардаг хүмүүст зориулан уг хөтөлбөрт хамрагдах таван алхамт хүсэлт гаргах явцыг боловсруулан гаргасан юм. Хүсэлт гаргах тухай нэмэлт мэдээлэл буюу тавигдах шаардлагуудыг ref.ids.org-аас үзнэ үү. Хүсэлт гаргахын тулд эхлээд орон нутгийнхаа санваартны удирдагч буюу институтийн захиралтай ярилц.

Алхам 1: Мөрөөд—БТС гийн тухай болон танай бүсэд уг хөтөлбөр батлагдсан эсэхийг мэдэж, гадасныхаа боловсролын галын дэргэдэх ярилцлагад оролц.

Алхам 2: Төлөвлөгөө гаргаж, тавигдах шаардлагуудыг ханга—Институт дээрх Амжилттай сургалтыг төлөвлөх нь сэдэвт хичээлд сууж, санваартны удирдагчдаасаа батламж авч, зөвлөгөө өгөхийг хүс.

Алхам 3: Хүсэлтээ гарга—Амжилттай сургалтыг төлөвлөх хичээлээр сурсан зүйл дээр чинь үндэслэгдсэн, онлайн дахь БТС-гийн өргөдлийн маягтыг бөглө.

Алхам 4: Зээлд хамрагд—Хэрэв батлагдсан бол, хүлээсэн үүргүүдээ биелүүлэхийг зөвшөөрөх БТС-гийн зээлийн ярилцлагад ор.

Алхам 5: Сургууль, курст суралцан, төгсөж, ажилд орох буюу илүү сайн ажил хийж, зээлээ эргүүлэн төл—Итгэлээ хөгжүүлж, идэвх санаачлага, зарчимч тууштай зан чанар, бие даах чадварыг харуулан, мөрөөдлөө биелүүлэхийн тулд шаргуу ажилла.



авж чаддаггүй. Энэ бүхэн бол БТС-гийн болон сургуульд суралцсаны улмаас надад нээгдсэн боломжийн ач юм” гэж тэр ярилаа.

Пабло боловсролтой болсны үр дүнд өөрт нь нээгдсэн боломжийн ачаар багш болж нийгэмдээ үйлчлэхийн зэрэгцээ гэр бүлээ тэжээж байна.

Өдөрт олон цагаар ажиллаж, амь зуулгаа дөнгөн данган залгуулж байсан үед аравны нэгээ төлөн, Сүмд үйлчлэх нь том сорилт юм хэмээн Аллен ах хэллээ. Энэ нь хэдийгээр дэлхий даяарх олон гишүүдийн хувьд үнэхээр том асуудал боловч БТС-гийн зээлд хамрагдагчдын талаар Ерөнхийлөгч Хинкли: “Тэд улс орондоо энэ агуу ажлын удирдагчид болно. Тэд аравны нэг болон өргөлүүдээ төлснөөр Сүмийн ажил дэлхий даяар тархах боломжтой болно” хэмээн амласан юм.⁶

БТС-гийн зээлээр боловсролтой болсон хүнд Сүмд үйлчлэх илүү их цагтай болох, илүү сайн ажил олж хийх үүд хаалга нээгддэгийг олон хамрагдагч ярьж байна. Филиппиний буцаж ирсэн номлогч Мириам Эрквица Вэб дизайны хоёр жилийн сургалт төгсөж, “хүчтэй залбирлаар”

Бразилын Лира Ван-дерли мэргэжлийн бус ажил хийж байхдаа зургаан жил салбарын ерөнхийлөгчөөр үйлчилжээ. Тэрээр БТС-гийн зээлийн ачаар мэргэжилтэй болсны дараа өндөр цалинтай шинэ ажилд оржээ. Гадасных нь ерөнхийлөгч түүнийг агуу удирдагч, эцэг “аз нь гийсэн аварга хүн” хэмээн дүрсэлж байна.

дамжуулан аялал жуулчлалын компанид ажилд оржээ. Энэ ажил нь гэр бүлээ тэтгэхийн сацуу Залуу Эмэгтэйчүүдийн ерөнхийлөгч, институтын багшаар үйлчлэх боломжийг түүнд олгосон ажээ.

Бразилын Лири Вандерли зургаан жил салбарын ерөнхийлөгчөөр үйлчлэн, идэвхтэй 18 гишүүнтэй байсан салбараа идэвхтэй 110 гишүүнтэй болтол нь өсч хөгжихөд тусалсны сацуу боловсролгүй учир хүнд хүчир ажил хийж байжээ. БТС зарладахад тэрээр ажлын байрны аюулгүй байдлаар суралцах боломжтой болсон бөгөөд шинэ ажил олж хийсэн гэнэ. Энэ ажил нь цалингаа нэмэгдүүлэн, зээлээ эргүүлж түргэн төлөхөд нь түүнд тусалжээ. Тэрээр өнөөдрийг хүртэл Сүмд үйлчилсээр байна. Гадасных нь ерөнхийлөгч түүнийг агуу удирдагч, эцэг “аз нь гийсэн аварга хүн” хэмээн дүрсэлж байна.

Амжилт олоход шаардлагатай “байгууллага . . . Их Эзэний чин үнэн үйлчлэгчид” Сүмд байдаг учраас энэ хөтөлбөр амжилттай хэрэгжих болно хэмээн Ерөнхийлөгч Хинкли Сүмийн гишүүдэд хэлсэн билээ.⁷ Зээлд хамрагдагчид болон орон нутгийн санваартны удирдагчид Тэргүүн Зөвлөл, Арванхоёр Төлөөлөгчийн Чуулга, тэрчлэн Сүмийн бусад ерөнхий удирдагчидтай хамтран ажилладаг учраас Боловсролын Тасралтгүй Сан амжилттай хэрэгжиж байна. Сүмийн ажил эрхлэлтэд дэмжлэг үзүүлэх төвүүд, семинар, институтууд бас энэ хөтөлбөрт идэвхтэй оролцож байна.

Сангийн үр өгөөж нь эргүүлж төлсөн мөнгийг бусад суралцагчдад зээлдүүлснээр зөвхөн санхүүгийн хувьд тасралтгүй



ГЭРЭЛТ ИРЭЭДҮЙ

Боловсролын Тасралтгүй Сан дэлхийн олон бүс нутагт манай гишүүдийг ядуурлын гинжнээс салгаж,

залуучуудад илүү сайн ажил олоход шаардлагатай ур чадварт сурган, мэргэшил олгож байна. Энэхүү үр өгөөжтэй төлөвлөгөө нь ядуу байдлаасаа болж итгэл найдвар нь суларсан хүмүүсийн нүдэнд найдварын гэрэлт очыг бадраасан юм. Тэд одоо илүү гэрэл гэгээтэй ирээдүйг харж байна.”

Ерөнхийлөгч Томас С.Монсон, “They Marked the Path to Follow,” *Лиахона*, 2007 оны 10-р сар, 6.

ХЭРХЭН ХАНДИВ ӨРГӨХ ВЭ?

Сангийн амжилттай ажиллагаа нь дэлхий даяарх гишүүд, сайн дурынхны өгөөмөр сэтгэл, тусламжаас ихээхэн хэмжээгээр хамаарна. Энэ хэрэгт таны тусалж болох хэдэн арга замын тухай доор өгүүлье:

- Орон нутгийнхаа БТС-гийн үйлчлэлийн төвд бүрэн бус цагаар сайн дураараа ажилла.
- Эхнэр буюу нөхөртэйгөө БТС-гийн хөтөлбөрт гэр бүлийн ахмад номлогчоор бүрэн цагаар үйлчил.
- Болосролын Тасралтгүй Санд хандив өргө.

байгаа төдийгүй, бас зээлд хамрагдагчид, ивээн тэтгэгчид, зохион байгуулагч удирдагчид болон бусад олон хүмүүс сүнслэг байдал болоод нийгмийн хувьд шууд бусаар адислагддаг билээ. “Боловсрол бол зөвхөн хувь хүмүүст төдийгүй, тэдний гэр бүл болон нийгмийн хувьд бат бөх хаалганд нэвтрэх түлхүүр мөн” гэж Аллен ах ярилаа.

Өнгөрсөн 10 жилд технологи болон ажлын туршлага нь зээлд хамрагдагчид, дэмжлэг үзүүлэгчдийн хувьд уг хөтөлбөрийг боловсронгуй болгоход тусалсан аж. Гэвч Боловсролын Тасралтгүй Сан өөрийг нь үндэслэн байгуулсан бошиглолын үзэгдлийг амьдралд хэрэгжүүлэхийг эрэлхийлж байна. Энэхүү “зоримог санаачлага” бошиглолын хүч чармайлт хэвээр байх болно. Ерөнхийлөгч Монсон сангийн ажлыг үргэлжлүүлж байгаа бөгөөд түүний хэлснээр энэ хөтөлбөр “алс холын ирээдүйд хүрэх” болно.⁸ ■

ЭШЛЭЛ

1. “16th President Fields Questions from Media,” *Church News*, 2008 оны 2-р сар, 15-ыг үз.
2. Гордон Б.Хинкли, “Боловсролын Тасралтгүй Сан,” *Лиахона*, 2001 оны 7-р сар, 62, 67.
3. Гордон Б.Хинкли, *Лиахона*, 2001 оны 7-р сар, 62.
4. Гордон Б.Хинкли, *Лиахона*, 2001 оны 7-р сар, 62.
5. Гордон Б.Хинкли, “Сүм урагш давшиж байна,” *Лиахона*, 2002 оны 7-р сар, 6.
6. Гордон Б.Хинкли, “Reaching Down to Lift Another,” *Лиахона*, 2002 оны 1-р сар, 62.
7. Гордон Б.Хинкли, *Лиахона*, 2001 оны 7-р сар, 67.
8. Томас С.Монсон, “16th President Fields Questions from Media,” *Church News*, 2008 оны 2-р сарын 9, 15.

БТС-гийн зээлд хамрагдагчдын тухай олон түүх уншиж, өөрөө үүнд хэрхэн хамрагдахыг мэдэхийн тулд pef.lds.org хаягаар орж үз.



*Хэрэв бидний өдөр
тутам гаргадаг шийд-
вэрүүд бидний мөнхийн
хувь тавилантай
холбоогүй бол бид
замаа амархан алддаг.*

АЛДАГДАГСАД БА ОЛДОГСОД



Адам К.Өүлсон

Сүмийн сэтгүүлүүд

Роберта Тюлиму 30 хүрэхийнхээ өмнөхөн аз жаргалгүй байгаагаа ойлгосон гэнэ. Тэр гурван хөөрхөн хүүхэдтэй, хүүхдүүдийнхээ аав Даниел Нипайд хайртай байсан ч Роберта, Даниел хоёр гэрлээгүй ажээ. Даниел Сүмийн гишүүн биш, харин Роберта сүмд тогтмол явдаг

байснаас хойш олон жил өнгөрчээ.

Тэрээр жаахан охин, Шинэ Зеландын Аукландад эцэг эхтэйгээ долоо хоног бүр сүмд явдаг байхдаа ариун сүмд гэрлэхийг үргэлж мөрөөддөг байсан ч ариун сүмийн гэрлэлт түүнээс даанч хол байлаа. Тэрээр мөнхийн зорилгоо ганцхан удаагийн

“Би гээгдсэнийг хайж, тараагдсаныг буцааж,
гэмтсэнийг боох бөгөөд өвчтэйг нь тэнхрүүлэх болно”
(Езекиел 34:16).

шийдвэрээр орхиогүй ажээ. Энэ нь түүний өдөр тутам гаргадаг жижигхэн шийдвэрүүдээр дамжин алгуураар гүйцэлдсэн урт удаан үйл явц байлаа.

Хоорондоо холбоогүй шийдвэрүүд

Робертагийн хувьд сайн мэдээний замаас анх удаа гажих үед гаргасан нэг шийдвэр бусдаас онцгой байдаг ажээ. Бусад нэлээд олон шийдвэр түүнийг мөн энэ замд оруулсан юм шиг санагдах хэдий ч тэр шүү. Роберта өсвөр насандаа гэрийн ажлаа хийх гэж нэг, хоёр долоо хоног сүмд явдаггүй байж. “Энэ тэр үед байж л болох өчүүхэн зүйл шиг санагдадаг байсан нь сонин шүү” гэж тэр хэллээ.

Хоёр долоо хоног сүмд явахгүй байсны дараа дараачийн долоо хоногт явахгүй байх нь түүнд бүр ч амар байсан гэнэ. Хэдэн долоо хоног болоод сүмд ирдэг байсан нь сүүлдээ хэдэн сар болоод нэг ирдэг болов. Түүнийг 18 хүрэхэд найз нар нь бямба гарагийн шөнө орой болтол шөнийн клубт явахыг ятгасан гэнэ. Энэ нь ням гарагт сүмд очиход нь бүр ч том саад болсон аж. Энэ бас түүнийг архи уудаг болгожээ.

“Энэ нь зөв биш гэдгийг би мэдэж байсан ч, хэрэв хүсэх л юм бол тэр дороо больж чадна гэж боддог байж билээ” гэж тэр ярилаа. Би гаргасан шийдвэрээ зөв гэж бодохыг хичээдэг байв.”

Тэрээр ариун сүмд ороход харшлах байдлаар амьдарч байсан ч Даниелтай танилцсаныхаа дараа түүнийг Шинэ Зеландын Хамилтон Ариун сүмийн газар дээр аваачиж, тэнд гэрлэх хүсэлтэй байгаагаа түүнд ярьсан гэнэ.

“Энэ бол миний очихыг хүсдэг газар гэдгийг би мэддэг байсан” гэж тэр хэллээ. Гэвч буруу шийдвэр гаргах бүрд дараагийн удаа буруу шийдвэр гаргах нь улам хялбар болсоор түүнийг хүссэн зорилгодоо хүрэхээс нь улам холдуулж байлаа. Удалгүй Роберта, Ханиел хоёр хамт амьдрах болов

“Миний хүсдэг зүйл, зөв гэдгийг нь мэддэг зүйл, миний гаргадаг шийдвэрүүд хоорондоо ямар ч холбоогүй болсон юм” хэмээн тэр ярилаа. “Би ирээдүйг огт бодолгүй зөвхөн өнөөдрөөр л амьдардаг байлаа. Шийдвэр гаргадаа энэ нь намайг юунд хүргэхийг боддоггүй байлаа.”

Их Эзэн алдагдагсдыг эрдэг

Роберта хүрэхийг зорьсон газраасаа хэчнээн ч холдлоо гэсэн тэрээр их Эзэний хувьд алдагдаагүй юм. Даниел, Роберта хоёр үүнийг тэр үед мэдээгүй ч, “алдагдсаныг хайж, аврахаар” (Лук 19:10) ирсэн Сайн Хоньчин тэднийг байнга хайсаар байсан юм.

Роберта түүнийг ариун сүмийн газар дээр аваачсан үеийнх шиг, бас Робертагийн аав хүүхдүүдийг нь адисалсан үеийнх шиг тийм байдлаар Сүнс Даниелд нөлөөлсөн ажээ. Тэд хэдэн удаа шилжин нүүсэн ч нүүх бүрдээ номлогчидтой тааралдаж, үе үе тэдэнтэй ярилцдаг байсан гэнэ.

Тэгээд 2006 онд дахин шилжсэний дараа тэд сургуулийнхаа хуучин найз нар, Сүмийн идэвхтэй гишүүд Дан Натан, Лиза Натан нартай тааралджээ. Даниел, Роберта хоёр Натаныхны тойргийн нутаг дэвсгэрт шилжин ирсэн байлаа.

Сүмд хамт очъё гэсэн Лизагийн урилгыг Роберта гурван долоо хоног хүлээн аваагүй аж. “Би өөрийнхөө байдлыг тайлбарлахыг хүсээгүй. “Харин хүүхдүүдээ Хүүхдийн Хэсэгт явуулахаар шийдсэн” гэж тэр ярилаа.

Даниел, Роберта хоёр удалгүй удалгүй номлогчидтой дахин уулзлаа. Даниел сүмд явж эхлэхэд Сайн мэдээний зарчмуудын нэг сайн багш өөрчлөлт гаргаж чадсан гэнэ. Айчлаагч багш нар сар бүр тэднийд ирдэг болов. Тэр ч байтугай гэр бүлийн энэ хос нэгэн онцгой цуглалалтын үеэр Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Ахлагч Давид А.Беднартай уулзсан гэнэ.

“Бидэнд тусалсан өдий төдий сайн хүмүүсийг” Бурхан бэлтгэсэнийг Роберта өөрсдийн туршлагаас харсан ажээ.

Зам мөрөө хянагтун

Тэнгэрлэг Эцэг хүмүүсээр дамжуулан олон янзын арга замаар Даниел, Роберта хоёрт “[өөрсдийн] зам мөрөө хянах” (Хаггаи 1:7) боломжийг олгосон ажээ. Харин тэд аливаа ахиц дэвшил гаргахаасаа өмнө “[өөрийн] замыг Эзэнд даатгах” (Дуулал 37:5) ёстой байлаа.

“Миний зам мөр Түүнийх биш (Исаиа 55:8–9-ийг үз) гэдгийг би мэдэж байсан ч, энэ хоёр замыг хэрхэн холбохоо мэдэж чадаагүй юм” гэж Роберта ярих.



Хаашаа явахыг, эсвээс сүнслэг утгаараа бол очих газартаа хүрэхийн тулд юу хийх хэрэгтэйгээ шийдэхийг номлогчид Даниел, Роберта хоёроос хүссэн үед эргэлт гарсан ажээ.

Эцэстээ бидний хүсч байгаа зүйл бол Түүний зам биднийг удирдах тэр газарт байх явдал гэдгийг шийдээд Түүний замыг дагахад юу хийх ёстойгоо хайж эхэлсэн” гэж тэр ярилаа.

Роберта өнгөрсөн үед гаргадаг байсан буруу шийдвэрүүдээ дараагийн саруудад гаргахгүйн төлөө ажиллаж, арав гаруй жилийн өмнө орхисон тэр замдаа эргэн оржээ. Роберта өсвөр насандаа жижиг шийдвэрүүдээр сайн мэдээний замаас эргэсэн шигээ өчүүхэн жижиг юм шиг санагдах зүйлсийг өдөр бүр хийснээр мөнөөх замдаа эргэн орсон юм.

“Хувийн болон гэр бүлийн залбирал, судар унших, хүүхдүүдээ сүмд дагуулж очих, чадах чинээгээрээ бусдад туслах зэрэг энгийн зүйлсийг өдөр бүр хийдэг болсноор Тэнгэрлэг Эцэг бидний төлөө санаа тавьж, бидний залбирлыг сонсдогийг би мэдэрч чадсан. “Манай гэр бүл одоо аз жаргалтай болсон” гэж Роберта ярилаа.

Эдгээр жижиг шийдвэрүүд нь том шийдвэр гаргах болсон үед нь Даниел, Роберта хоёрыг хүчирхэгжүүлж, тэдэнд тусалсан ажээ. Тэд гэрлэхээр шийдсэн гэнэ. Тэгээд бараг жилийн дараа Даниел, Роберта хоёр номлогчидтой уулздаг болж, гэр бүлтэйгээ үүрд хамт байх хүсэл нь Даниелыг баптисм хийлгэхэд хөтөлжээ.

Эцэст нь, тэд өдөр тутам хийдэг зүйлсээ ирээдүйд болох зүйлстэй нийцүүлэхийн төлөө хоёр жил хичээн чармайсны эцэст

Даниел, ариун сүмд лацдан холбуулж, Робертагийн хүүхэд ахуй үеийн мөрөөдөл биелжээ.

Одооноос мөнхийн ирээдүйгээ бодож амьдар

Даниел, Роберта хоёр өөрсдийн замаар явах уу, эсвэл Түүний замаар явах уу гэдгийг өдөр бүр шийдэх боломжтой байсан нь Тэнгэрлэг Эцэгийн төлөвлөгөөний хэсэг юм. Эдүгээ гэр бүлийн энэ хос өдөр тутмын сонголтууд нь тэднийг хааш нь хөтлөхийг сайн мэддэг болжээ.

Өдөр тутмын шийдвэрүүдийг мөнхийн хувь тавиланд нь хэрхэн нөлөөлөхийг бодолгүйгээр гаргавал замаа алдах нь хэчнээн амархан болохыг тэд өөрсдийн туршлагаас ойлгосон ажээ. Гэвч нэгэн цагт эргэсэн замдаа буцаж орж болдгийг мэдсэндээ мөн талархалтай байдаг гэнэ.

“Эргэж ирэхэд бидэнд тусалсан хүмүүстэй аяллынхаа туршид бид хоёр тааралдаж байлаа. Энэ хүмүүсээр Их Эзэн бидний амьдралыг адисалсан юм. Тэрбээр надад хайртай, намайг эргэж ирээсэй хэмээн хүсдэгийг би мэднэ. Их Эзэн намайг Сүмээс холдон хөндийрсөн бүхий л хутацаанд мартаагүй” гэж Роберта ярив.

Сайн хоньчны хайр, цагаатгагч золиослолын ачаар “хилэнцтэн нь өөрийн замаа орхиод . . . Эзэн уруу эргэхэд, түүнийг Тэр өрөвдөнө . . . Учир нь Тэр өгөөмрөөр уучилна” (Исаиа 55:7).

Эдүгээ Нифайнхан байхыг хүсдэг тэр газар дээр анхаарлаа төвлөрүүлэхийг хичээн чармайж байна. “Энэ амьдралд зөвхөн одоо гэдгээс илүү чухал байдгийг ойлгосон үед энэ зүйл сонголтуудыг чинь өөрчилнө” гэж Даниел хэллээ. ■



ШИЙДВЭР ХУВЬ ЗАЯАГ ТОДОРХОЙЛНО

“Олон жилийн тэртээ нэг хүн, түүх олон жижиг нугаснууд дээр эргэлддэг, хүмүүсийн амьдрал ч мөн ийм байдаг. Бидний амьдрал мөнхийн ирээдүйг бодож гаргасан шийдвэрүүдээс хамааралтай байх болно” хэмээн хэлжээ.

Ерөнхийлөгч Томас С.Монсон, “Decisions Determine Destiny,” *New Era*, 1979 оны 11-р сар, 4.

ХРИСТ БИДНИЙГ ТАЙТГАРУУЛДАГ ШИГ

Сэтгэл сэргээж, нүд булаам сайхан нутаг Шинэ Зеландын Хойд Арал дээр бид анхны Христийн Мэндэлсний Баяраа тэмдэглэж билээ. Нар шарж, Сүмийн гишүүд найрсаг сайхан хандаж байсан ч би аав ээж, ах дүүсээ санан ихэд ганцаардаж байлаа. Бид тэр жилийн эхээр Нэгдсэн Улсаас шилжиж ирсэн бөгөөд гэрээ учиргүй их санаж байсан юм.

Нөхөр бид хоёр шилжиж ирсэн шинэ газартаа, Христийн өөр сүмд явдаг Ирландын нэгэн залуу гэр бүл Вилсоныхонтой найзалдаг байлаа. Тэд бас саяхан Шинэ Зеландад ирсэн ажээ. Нолин Вилсон миний хамтран ажиллагч бөгөөд бид удалгүй сайн найзууд болж, шинэ нутаг, шинэ гэр орноо хайрладаг туршлагаа хуваалцдаг болов. Бидний нөхөрлөл гүнзгийрэх тутам тэднийхэн ч мөн ганцаардлын уй гунигтай тэмцэлдэн, санаа сэтгэл төвшингүй

байдгийг нь би мэдэж билээ. Вилсоных бага насны гурван хүүхэдтэй, дөрөв дэх нь гарах гэж байлаа.

Нэг орой би бүр ч их ганцаардаж, гуниглан сууж байтал, ганцаардлаа даван туулах хамгийн сайн арга зам бол бусдад, тэр тусмаа Вилсоныхонд үйлчлэх явдал гэсэн бодол толгойд орж ирлээ. Тэр орой нөхөр бид хоёр тэдний үүдэн дээр нэргүй зурвас, жижиг жижиг бэлэг тавих замаар Христийн Мэндэлсний Баярыг 12 өдөр тэмдэглэхээр шийдэв. Орой бүр миний ганцаардал сэтгэл хөдлөл, баяр хөөрөөр солигдож, тэдний үүд рүү сэмхэн очиж захиас, бэлэг тавихаар тэсч ядан хүлээдэг боллоо. Тэгээд хаалгыг нь түргэн тогшчихоод мушилзан инээмсэглэж, холдон гүйнэ.

Нолин ажил дээрээ ирээд, урьд шөнө нь “Христийн Мэндэлсний Баярын мэндийг” нууцаар илгээгч хэн нэгэн тэднийд ирсэн тухай

надад өдөр бүр ярина. Гэр бүлийн Христийн Мэндэлсний Баярыг нь илүү жаргалтай болгож байгаа зочдыг ирэхийг тэсч ядан хүлээж байгаа хүүхдүүдээ тэрээр сонин түүхүүдийг ярьж өгдөг ажээ. Нэлээд хэдэн орой манай тойргийн залуучууд бидний хөгжилтэй үйл ажиллагаанд нэгдэв.

Христийн Мэндэлсний Баярын өмнөх үдэш Вилсоныхон үүдэн дээрээ зурвас, бялуу тавьж, нууц зочидтойгоо уулзахыг хүсчээ. Биднийг тойргийн залуучуудтай хамт сүүлчийнхээ бэлэг болох Христийн Мэндэлсний магтуу дуулахаар очиход хүүхдүүд нь ёстой л хөл нь газарт хүрэхгүй баярлаж, найз нар маань биднийг чанга тэврэн, баярын нулимс унагаж байлаа. Зүрх сэтгэлд минь байсан ганцаардал хайр, баяр баясгалангаар солигдож, манай гэр бүлүүдийн хоорондох нөхөрлөлийн хэлхээ холбоо улам бэхэжсэн юм.

Хожим нь бид Вилсоныхны сүмийн нэг хүнээс и-мэйл хүлээн авлаа. Тэр хүн Вилсоныхонд зориулж бидний хийсэн зүйлд сэтгэл нь их хөдөлсөн тухайгаа өгүүлж, манай Сүмийн тухай, бусдад бидний үзүүлдэг үйлчлэлийн тухай асуусан байлаа. Сүм дээр цугларагсад Христийн Мэндэлсний Баярын 12 өдөр тэмдэглэдэг тухай огт сонсоогүй ажээ. Эдүгээ тэд энэхүү уламжлалт заншлыг Хожмын Үеийн Гэгээнтнүүдтэй хамтран хэрэгжүүлж байна.

Есүс Христ биднийг тусламж хэрэгтэй болсон үед түүнчлэн биднийг ганцаардсан үед тайтгаруулдаг шиг, би өөрийгөө умартан, ажиллахаар явж, “тайтгарал хэрэгтэй тэднийг тайтгаруулах” (Мозая 18:9) санаанд оромгүй арга замыг сэдсэн Шинэ Зеланд дахь Христийн Мэндэлсний анхны Баярыг хэзээ ч мартахгүй. ■ Анжела Фоллентайн, Шинэ Зеланд

Биднийг тойргийн залуучуудтай хамт сүүлчийнхээ бэлэг болох Христийн Мэндэлсний магтуу дуулахаар очиход хүүхдүүд нь ёстой л хөл нь газарт хүрэхгүй баярлаж, найз нар маань биднийг чанга тэврэлээ.



ОБРЕГОНООС НАДАД ИРСЭН ХРИСТИЙН МЭНДЭЛСНИЙ БАЯРЫН ИЛ ЗАХИДАЛ

Намайг Мексикт номлолд үйлчилж байх үеэр хамтрагч бид хоёр Калифорний Булангийн ойролцоо баруун хойд Мексик дэх Обрегон хотын нэг хүнтэй танилцаж билээ. Тэр хүн сайн мэдээний Сэргээлтийн тухай бидний захиасыг сонирхсон ч, галт тэргэнд амжиж суухын тулд ердөө 10 минут л ярилцсан юм. Бид тийм богинохон хугацаанд амжуулж чадах бүхнээ заагаад нэг Мормоны Ном, байсан бүх тэмдэглэлээ түүнд өгч явууллаа. Тэр үед манай номлол Обрегонд номлогчидгүй байлаа.

Хэдэн сарын дараа би Обрегоны нэг хүнээс Христийн Мэндэлсний Баярын ил захидал авлаа. Ил захидлыг хараад хэн үүнийг илгээсэн байж таарах вэ гэж гайхан бодов. Тэгтэл ил захидлыг нөгөөх 10 минут ярилцсан хүн илгээсэн байв. Би ил захидлыг бусад ахлагчид болон өөрийн хүлээн авсан Христийн Мэндэлсний Баярын өөр ил захидалуудтай хамт сууцныхаа хананд хадлаа.

Христийн Мэндэлсний Баярын дараа нөгөөх ил захидлыг хаях гэтэл үүнийг хадгалъя гэсэн бодол төрөв. Энэ мэдрэмж чихэнд сонсогдох биш харин зүрх сэтгэлд мэдрэгдэн байлаа. Тэгээд ил захидлыг хаясангүй, чөмөдандаа хийчихэв.

Хэдэн сарын дараа би номлолын гэрээс сар бүр ирдэг захидлыг уншиж байгаад Обрегонд номлолын ажил нээгдэх тухай зарлалыг олж үзэв. “Энэ хот надтай ямар холбоотой билээ?” гэж би дахин бодлоо. Тэгээд бид тэндэхийн нэг хүнтэй



Христийн Мэндэлсний Баярын дараа нөгөөх ил захидлыг хаях гэтэл үүнийг хадгалъя гэсэн бодол төрөв.

уулзсанаа дахин саналаа. Би чөмөданаа уудалж, Христийн Мэндэлсний Баярын нөгөөх ил захидлыг гаргаж ирлээ. “Эдгээр ахлагч нар бол миний найзууд. Тиймээс би сайн мэдээний тухай танд бүр их зүйлийг заахын тулд тэднийг илгээж байна” гэж би ил захидал дээр бичив. Тэгээд ил захидлыг Обрегонд үйлчлэхээр томилогдсон ахлагч нарт үүнийг авч яван, тэр хүнтэй уулзахын тулд явуулав.

Обрегонд үйлчилж байсан ахлагч нараас удаагүй захидал ирлээ. Уг захидалд: “Эрхэм хүндэт Ахлагч Рамос, энд ажил маш хүнд байсан учир номлолын ерөнхийлөгч биднийг өөрийн чинь захидлыг

хүлээн авахаас өмнө биднийг нааш нь явуулахаар төлөвлөсөн байжээ. Биднийг энэ ахтай уулзахаар очиход тэр бидний захиаст сэтгэл нь ихэд хөдлөн гэр бүлийнхээ бүх гишүүд, найз нартайгаа биднийг уулзууллаа. Энэ ахын ачаар бид салбар нээгээд байна” гэж бичжээ.

Тэр үеэс хойш олон жил улиран одож эдүгээ Обрегонд гурван гадад зохион байгуулагдаад байгаа ажээ. Би Сүнсний өдөөлтүүдийг сонссоныхоо ачаар, Есүс Христийн сайн мэдээг хүлээн авахад нь Обрегон дахь ах, эгч нартаа өчүүхэн тус хүргэснээр адислагдсанаа мэдэж даруусгагдсан билээ. ■
Роберт Рамос, Обрегон, АНУ

БИДЭНД ИДЭХ ЮМ ЮУ Ч БАЙСАНГҮЙ

Би Христийн Мэндэлсний Баярын өмнөх өглөө эрт сэрээд санаа ихэд зовов. Учир нь бидэнд баярын оройн хоол хийх хүнсний зүйл юу ч байсангүй. Бас хүнсний зүйл худалдаж авах мөнгө ч байсангүй. Би тэр үед Венесуэлийн Маракай-бод эгч Эдиктатайгаа хамт амьдарч байсан юм.

Би орноосоо босоод өвдөг сөгдөн залбирч эхэллээ. Биднийг санаач хэмээн би Тэнгэрлэг Эцэгээсээ гуйв. Би Түүнээс энэхүү онцгой өдөр *la Noche Buena* (Христийн Мэндэлсний Баярын өмнөх үдэш) бидэнд ядаж жаахан хоол хүнс өгөөч гэж гуйлаа.

Залбирч дуусахад миний бие амар амгалангаар дүүрсэн байлаа. Нэгэн намуухан дуу хоолой надад, “Бүх юм сайн сайхан болно. Бүү санаа зов” гэж хэлэх шиг санагдаж билээ. Би залбирч дуусаад тэр өдөр ямар нэг сайн зүйл болно гэдгийг мэдэж байлаа.

Эгчийг сэрсний дараа би үүдний довжоо шүүрдэхээр гарлаа. Гудамжны нөгөө талд суудаг хөрш эмэгтэй намайг харснаа Христийн Мэндэлсний Баярын ширээний бүтээлэг, миний хатгамал хийсэн чимэглэлийн үнэнд 1000 боливарыг өгөхөөр ирлээ. Тэр надад мөнгө өгөх ёстойг санасангүй учир би их гайхаж билээ.

Эгчийнхээ өрөөнд гүйж ороод мөнгөтэй болсноо түүнд үзүүлээ. Эгч маань гайхаж, хаанаас мөнгөтэй болчихоо вэ гэж асуулаа. “Бурханд бүх зүйл боломжтой” (Матай 19:26) шүү дээ гэж би хариулав.

Хэдэн минутын дараа нэг хүн гаднаас эгчийг дуудахыг бид хоёр сонслоо. Нөгөөх хөрш маань ирсэн байхыг бид мэдээд түүнтэй ярилцахаар гарсан юм. Хөрш маань эгчид юм оёж өгсний хөлсөнд өгөх ёстой байсан 1000 боливарыг түүнд

өгөв. Одоо эгч бид хоёр өглөөний хоол, үдийн хоол, *бас* оройн хоол худалдаж авах мөнгөтэй болсондоо туйлын баяртай байлаа.

Бид хоёр хүнсний дэлгүүрээс юм худалдаж аваад иртэл нэг найз маань биднийг хүлээж байх нь тэр. *la Noche Buena* буюу Христийн Мэндэлсний Баярын өмнөх үдшийг ганцаараа өнгөрүүлэхийг хүсээгүй учир бидэнтэй хамт энэ үдшийг өнгөрүүлж болох уу гэж асуулаа. Бид хоёр гэртээ даруухан оройн хоол идэх болно гэдгээ, мөн түүнийг бидэнтэй нэгдсэнд баяртай байгаагаа хэллээ. Тэр хоолны үнэнд 2000 боливар нэмэрлэв. Бурхан биднийг хэчнээн их адисалсанд бид гайхаж ядан байлаа.

Дараахан нь миний зээ дүү утасдаж, сүмсэнд дарсан 15 кг махаа аван манайд ирэх гэж байгаагаа хэллээ. Бас үд гэхэд миний ач дүү

эхнэр, хүүхдүүдтэйгээ ирлээ. Тэд орой нь хоол хүнс авчран, Христийн Мэндэлсний Баярыг бидэнтэй хамт тэмдэглэж болох уу гэж хүсээд,

“Бид их хоол хийхгүй ээ, гэхдээ хүн бүрд хангалттай юм бий” гэж тэд хэлэв.

Тэр орой Эдикта бид хоёр тахианы мах жигнэж, төмсний салат, лемонтой чихэрлэг амттан, *majarete* буюу уламжлалт наргилын самартай царцмаг хийж, бүх зочидтойгоо амтархан идэж билээ. Гэвч бид эхлээд Тэнгэрлэг Эцэгтээ бидэнд өгсөн агуу адислалуудынх нь төлөө талархал өргөсөн. Хэрэв бид итгэлтэй байж, эргэлзэхгүй бол Түүний тусламжийг гуйсан үед Тэрбээр биднийг адислах болно гэдгийг тэр орой бидэнд сануулсан юм. ■

Эстилита Часин Харт, Юта, АНУ

Би орноосоо босоод өвдөг сөгдөн залбирч эхэллээ. Биднийг санаач хэмээн би Тэнгэрлэг Эцэгээсээ гуйв.



ЛИНДАГИЙН СҮҮЛЧИЙН ХРИСТИЙН МЭНДЭЛСНИЙ БАЯР

Намайг Бригам Янгийн Их Сургуулийн хоёрдугаар курсийн оюутан байхад манай тойргийн бишопын зөвлөл Өвлийн өвгөнийг орон тоглох тойргийн хөтөлбөрт гарын үсэг зурав. Бид энэ хөтөлбөрөөр дамжуулан тусламж хэрэгтэй нэг гэр бүлд Христийн Мэндэлсний Баярын бэлэг өгөх ёстой байв.

Гэвч манай тойргийн нэр сайн дурынхны жагсаалтаас гарч ирсэнгүй. Христийн Мэндэлсний Баяр ойртсон ч бид туслах ёстой гэр бүлээ олоогүй байлаа. Тэгтэл бишопын туслахуудын нэг нь бидний тусламжийг ашиглаж болох өөр нэг гэр бүл байгаа шүү гэж бидэнд ярилаа. Бид энэ гэр бүлийн тухай мэдээд тэдэн дээр анхаарал төвлөрүүлэх ёстойгоо тодорхой мэдэрч билээ.

9-15 насны хэдэн хүүгийн эх Линда (нэрийг өөрчлөв) хөхний хавдартай хүнд тэмцэл хийж байгаа ажээ. Хүнд өвчний улмаас бий болсон сэтгэл санааны дарамтаас болж нөхөр нь хаяад явчихсан гэнэ. Тэр эмэгтэй ажил олж хийхээр нэгэн мужаас Ютагийн Провод саяхан шилжиж ирсэн ч ажил олдсонгүй, амь зуулгагүй байгаа ажээ.

Бид Линдатай уулзангуут түүнийг бүх зүрх сэтгэлээрээ энэрэн хайрласан юм. Олон хүнд сорилтыг ялж гарсан, Аврагчийн бүтээсэн энэхүү агуу, уужуу сэтгэлт сүнсийг харснаараа бид адислагдсан юм. Тэр бидний хувьд *ёс төдий гүйцэтгэх ажил үүрэг* байсангүй харин үүрдийн найз болсон юм. Тойргийн гишүүн бүр түүнд болон хөвгүүдэд нь туслахын тулд ямар нэг зүйл хандивласан. Коллежийн залуу оюутнууд бид өөрсдөө бас л ядуу



Линдаг манай тойргийн Христийн Мэндэлсний Баярын үдэшлэг дээр байх үеэр тойргийн нэлээд хэдэн гишүүн түүний гэрт очиж шүүгээ, хөргөгчийг нь хоол хүнсээр дүүргэлээ.

байсан ч, түүнийг хайрласан сэтгэлээр өгч чадах бүхнээ өгсөндөө баяртай байна.

Линда манай тойргийн Христийн Мэндэлсний Баярын үдэшлэгт ирлээ. Энэ үеэр тойргийн нэлээд хэдэн гишүүн түүний гэрт очиж шүүтээ, хөргөгчийг нь хоол хүнсээр дүүргэлээ. Тэд Христийн Мэндэлсний Баярын сүлд модыг чимэглэн, эднийхэнд бүгдэд нь өгсөн бэлгүүдийг сүлд мод тойруулан тавьсан байлаа. Тэд бас машины дөрвөн шинэ дугуй орхиж, хэдэн сарынх нь түрээсийг төлжээ. Бидний даруухан хандив энэ бүхнийг хийхэд хэрхэн хүргэснийг мэдээгүй ч, Тэнгэрлэг Эцэг бидний хийсэн золиослолыг түүнийг адислахын тулд

ашигласныг л мэдэж байлаа.

Жилийн дараа би оюутны өөр тойрогт байсан ч Христийн Мэндэлсний Баярын өмнө бишопын зөвлөлтэй уулзахаар эргэж очлоо. Линдагийн нөхөр гэртээ эргэн ирж, тэдний санхүүгийн байдал тогтвортой болсныг би мэдэж билээ. Гэвч Линдагийн хавдар дахин идэвхжиж, амийг нь аван оджээ. Бид Линдад Христийн Мэндэлсний Баярын сүүлчийн бэлгийг нь өгснөө мэдлээ.

Энэ туршлагаас би “Христийн цэвэр хайр” (Моронай 7:47)-ыг хүчтэй мэдэрч, жинхэнэ энэрэл гэдэг бол биднийг Аврагчийн оронд үйлдэхэд хүргэдэг үнэлж баршгүй сүнсний бэлэг мөн гэдгийг мэдэж билээ. ■ Ж.Аудри Хаммер, Юта, АНУ

Далын Ахлагч

Патрик Кеарон



Ирцгээ, ТҮҮНИЙГ ШҮТЭН БИШИРЦГЭЭЭ

Христийн Мэндэлсний өнгөрсөн Баяраар би АНУ-ын Юта мужийн Солт Лейк хот дахь Сүмийн Удирдах байгууллагад үйлчилж байхдаа урвуу цаг агаар хэмээн нэрлэгддэг цаг агаарын нэг үзэгдэлтэй таарсан юм. Урвуу цаг агаар гэдэг нь агаар газарт ойрхон бууж ирээд дээр байдгаасаа илүү хүйтэн буюу ердийнхөөсөө урвуу байдалтай болохыг хэлдэг ажээ. Энэ цаг агаар нь зөвхөн Солт Лейк хотын онцлог биш, эргэн тойрон өндөр уулсаар хүрээлэгдсэн хөндийд оршдогийнх гэнэ. Үүний улмаас хот мананд хучигдаж, манан нь хөндийн адагт хуралдан хот болон орчны газар нь өтгөн, бараан, хүйтэн үүлэн дунд ордог. Утаа тортог нь амьсгалын хүндрэлтэй хүмүүст хортойгоос гадна олон олон хүмүүсийн сэтгэл санааны байдалд нөлөөлж, агаар нь бохир, нар олон өдөр, бүр олон долоо хоногоор харагдахгүй болдог ажээ.

Гэвч машинаар уул өөд багахан өгсөхөд утаа тортог нь ердөө зуугаадхан метр зузаан болох нь мэдэгдэнэ. Хэдхэн минутын дараа та нарны гэрэлд гялбан, цэнгэг агаараар амьсгалж, цэвэрхэн цасан цагаан дуулгат уулсыг гайхан харах болно. Доор хөндийд цаг агаар тийм тааруухан байсан гэж үү хэмээн бодож мэднэ. Уулс өөд цааш арай дээр гараад утаа тортгийг харвал тэртээ доор номин цэнхэр тэнгэрт бохир хөнжил нөмөргөсөн юм шиг харагдана.

Бид зарим үед хар бараан утаа униартай хөндийд хашигдсан мэт байх нь амьдралд

Өөрсдийгөө тэр хөндийн бузар агаараас гаргаж, гагцхүү Аврагчийн ирэлтээр бий болох амар амгалан хийгээд итгэл найдварын хурц гэрэлрүү аваачих хүч болон чадал бидэнд бий гэдгийг бид ойлгох ёстой.



харагддаг. Хийсэн буруу сонголтынхоо улмаас, Сүнсний гомдоох зүйл хийснээс, эсвэл уршигтай буруу шийдвэр гаргаснаас мөнх бус амьдралд нийтлэг тохиолддог сорилт бэрхшээлийн улмаас бид өтгөн утаа тортогтой манан дунд орчихсон байдаг. Ингэсэн тохиолдолд бид юмсыг тодорхой харж чадахгүй, бодол санаа самууран, Тэнгэрлэг Эцэгийнхээ элгэн халуун хайрын гэрэл гэгээнээс өөрийгөө холдуулснаа мэдэрдэг. Их Эзэний цэвэр гэрэл биднийг хүлээж байдгийг, хэрэв бид итгэлээсээ хэдхэн алхам хазайвал энэ гэрэл биднийг урин дууддагийг бид мартдаг. Өөрсдийгөө тэр хөндийн бохир агаараас гаргаж, гагцхүү Аврагчийн ирэлтээр бий болох амар амгалан хийгээд итгэл найдварын хурц гэрэл рүү аваачих хүч, чадвар өөрсөддөө бий гэдгийг бид ойлгох ёстой.

Христийн Мэндэлсний Баярын энэ үеэр биднийг бүгдийг нь Өөртөө болон гэрэлд ирэхийг урьдаг Дэлхийн Гэрэл, Есүс Христийн төрөлтөд бид баярлан цэнгэдэг билээ. Есүсийн төрөлтийн үеэр Түүн рүү шууд ирэхээр адислагдсан эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн тухай бид судруудаас уншиж болно. Тэдний зарим нь алс холоос ирсэн бол зарим дэргэд нь байлаа. Тэдний зарим дээр нь тэнгэр элчүүд ирсэн бол бусад нь хувийн илчлэлт хүлээн авснаар ирсэн юм. Гэвч хүн бүр Түүнд ирэх урилгыг хүлээн авсан юм.

Бид хоньчид, Симеон, Анна болон Мэргэн хүмүүсээс юу сурч болох вэ? Тэд



бүгдээрээ нялх хүүхэд Христийг өөрийн нүдээр харах хүсэлдээ хөтлөгдөн ирсэн юм. Христэд ирэх урилгад тэд итгэл бишрэлээрээ хариулсныг бид тунгаан бодсоноор өөрсдийгөө уйтгар гуниг, төөрөгдлөөс гаргаж, Дэлхийн гэрлийн санал болгодог

Бид шавь болсон тохиолдолд хонин сүргээ билчээрт нь хариулах юм уу цөлийг туулахыг биднээс шаардахгүй.

Аврагч руу очих бидний аялал бол явганаар юм уу хөсгөөр хийх аялал биш; энэ бол сүнсний болон зан төлөвийн аялал юм. Энэ аялалд Түүний Цагаатгалыг хүлээн зөвшөөрч, баяртайгаар хүлээн авах нь орно.

цэвэр итгэл найдварт хүргэх илүү үр өгөөжтэй арга замыг мэдэж чадна. Бид Түүнтэй хамт байснаар өөрсдийгөө хэн болохыг, Бурханы мөнхийн төлөвлөгөөнд хэрхэн тохирохоо мэдэх болно. Бидний хэвийн бус хандлагууд эргэн, зөв байдлаараа сэргэх болно.

Хоньчид

Бидний мэдэх Лук 2-ын шүлгүүдээс бид Христийн төрөлтийн анхны гэрчүүд, Бетлехемийн ойролцоох хээр талд хонио хариулж явсан хоньчдын тухай чухал баримтуудыг мэддэг билээ. “Эзэний тэнгэр элч тэдний өмнө зогсоход, . . .

тэд үлэмжийн айдаст

автжээ” (шүлэг 9). Гэвч тэд эрт үеэс зөгнөсөн Аврагч, Мессиа, Христ төрсөн тухай “үлэмж баярлуулах сайн мэдээг” сонссон юм (шүлэг 10). Тэд Аврагчийг таньж болох тэрхүү тэмдгээр, Түүнийг “гэжээлийн тэвшинд, даавуунд өлгийдсөн” (шүлэг 12)-өөр нь таньж болно гэдгийг сонссон ажээ. Тэнгэрийн элчүүд баярт мэдээгээ хэлж дуусахад хоньчид тэр даруй, “Одоо шууд Бетлехемд очъё Эзэний бидэнд мэдүүлсэн зүйл бүтсэнийг үзэцгээе” (шүлэг 15) гэжээ. Тэд “яаран” (шүлэг 16) ирж, тэнгэр элчийн саяхан хэлснээр Христ хүүт олж, “Бурханыг

магтан алдаршуулсаар буцлаа” (шүлэг 20). “Тэд үүнийг хараад” (шүлэг 17) Аврагчийн төрөлтийн тухай агуу мэдээг хуваалцахыг хүсч байлаа.

Бид эдгээр хоньчдын нэгэн адил Сүнс бидэнд хандан ярьсан хэдийд ч яаран, тэр даруй хариулах ёстой. Бид Ерөнхийлөгч Томас С.Монсонгийн хэлснээр “сүнсний өдөөлтийг дагахаа хэзээ ч, хэзээ ч, хэзээ ч хойшлуулах” ёсгүй.¹ Бид заримдаа сүнсний өдөөлтийг анхааран сонссоны дараа яагаад аль нэг тодорхой арга замаар Сүнсээр удирдуулах болсноо тод томруунаар харж чаддаггүй. Харин бид дээрх хоньчид шиг гайхамшиг тохиохыг харж, сүнсний өдөөлтөнд бидний итгэлээр үзүүлэх хариу батлагдахыг харах нь олонтоо тохиолддог. Тэгэхэд бид баяр баясал болоод гэрчлэлээ бусадтай хуваалцах боломжийг ашигладаг. Ингэснээр бусдын итгэл, найдвар хүчтэй болж, бидний өөрсдийн гэрчлэл батлагдаж, биднийг Аврагч болон Түүний арга замуудад ойртуулна.

Симеон

Нялх хүүхэд Христийн өөр нэгэн хүндэт гэрч бол Симеон байлаа. Тэр бол Ариун Сүнснээс тогтмол илэрхийлэлт хүлээн авдаг, “зөв шударга агаад сүсэгт” (Лук 2:25) хүн байв. “Эзэний Христийг үзэхээс нааш өөрийг нь үхэхгүй” (шүлэг 26) хэмээн түүнд илчилсэн бөгөөд тэрээр итгэл найдвараар амьдарч, тэрхүү агуу үйл явдлыг хүсэн хүлээж байжээ. Мариа, Иосеф хоёр нялх Есүсийг “Эзэнд өргөхөөр” (шүлэг 22) Иерусалимд авчирсан өдөр түүнийг ариун сүм рүү очиход Сүнс өдөөсөн ажээ. Симеон нялх хүүхэд нь амлагдсан Мессиа болохыг таньж, “Хүүг гар дээрээ авч, Бурханыг магтаад” (шүлэг 28) “харь үндэстэнд илчлэлийн гэрэл, Таны ард түмэн болох Израилын алдар нь болой” (шүлэг 32) хэмээн ариун хүүгийн хувь тавиланг бошигложээ.

Симеоны зөв шударга, итгэл бишрэлтэй амьдрал нь ариун сүмд очиж, сая нэг юм

хүлээн авсан Гэрлийнхээ тухай гэрчлэх боломжийг түүнд олгосон ажээ. Бид Симеоны нэгэн адил Тэнгэрлэг Эцэг оюун бодолдоо бидэнд бэлтгэсэн тэр замаар бидний амьдрал замнахын тулд Ариун Сүнсний шивнээнд үлэмж мэдрэмтгий байж, түүнийг дуулгавартай дагахыг хичээн чармайх хэрэгтэй. Симеон Сүнсийг сонсож, түүнд хариулах чадварыг өөртөө бий болгосон учраас зөв газарт, зөв цагт байснаас түүнд өгсөн Их Эзэний амлалтууд хамгийн эрхэм сайхан арга замаар биелэгдсэн юм.

Мөн ийм боломжууд бидэнд бүгдэд нь олдож болох бөгөөд мөн үүн лүгээ адил Их Эзэний төлөвлөгөө бидний амьдралд хэрэгжиж болно. Бид мөнхийн ач холбогдолтой шийдвэр гаргах болсон үед, амьдралдаа салаа замтай тулгарсан үед санаа бодлоо тодорхой болгож, хэтийн төлөвөө тодорхойлох хэрэгтэй. Заримдаа эдгээр чухал шийдвэрүүдийг гаргах мөчид итгэл алдран гуйвж, бүр шийдвэр гаргах чадваргүй болж, урвуу цаг агаартай, бараан баргар хөндий рүү орох тохиолдол байдаг. Гэвч бид итгэлтэйгээр алхам хийж, зөв зарчмуудын дагуу үйлдвэл Бурханы төлөвлөгөө бидний амьдралд алгуураар хэрэгжиж буйг харж, Бурханы хайрын хурц гэрэлд буцаан ирэх болно.

Анна

Анна бол “нас өндөр,” “эш үзүүлэгч” (Лук 2:36), бэлэвсэн эмэгтэй байв. Түүний урт удаан, итгэл бишрэлээр дүүрэн амьдрал байнгын мацаг барилт, залбирлаар тодорхойлогддог байсан бөгөөд “сүмийг хэзээ ч орхисонгүй” (шүлэг 37). Тэрээр сүмд Есүс хүүт гар дээрээ өргөсний дараа “Христ хүүхдийн төлөө” талархал өргөөд Иерусалимын гэтэлгэлийг хүлээж байсан бүхэнд Түүний тухай үргэлжлүүлэн ярих” (шүлэг 38).

Хэрэв бид тогтмол мацаг барин залбирч байх юм бол, зүрх сэтгэлээрээ ариун сүмийг орхихгүй байх юм бол ямар ч нөхцөлд итгэлтэйгээр амьдарч



ХОНЬЧДОД ЗАЛГАН МЭДЭГДСЭН НЬ ДЭЛ ПАРСОН; СИМЕОНЫ ТАЛАРХАЛЫН ЗАЛБИРАЛ; РОБЕРТ ТЬАРЕТТ; ОНЦГОЙ НАЙДВАР, ЭЛСЭТЭЙ ЯНГ, ХУЛБАРТАХ БОЛОХҮЙ; ИРЭЛТ, МАЙКЛ ОЛБРЕХТСОН, ХУЛБАРТАХ БОЛОХҮЙ



чадна гэдгийг бид Аннагийн туршлагаас мэдлээ. Хэрэв ариун сүмд явж, адислалуудыг нь авах боломж одоохондоо бидэнд олдоогүй бол, ариун сүмийн зөвшөөрлийн бичигтэй байхаар зохистой байхад л бидний амьдралд олон адислал ирэх болно. Бидний нөхцөл байдал ариун сүмд орох боломж олгохгүй байлаа ч гэсэн ариун сүмийн зөвшөөрлийн бичигтэй байхыг бошиглогчид дахин давтан урьсаар байна.² Бид ариун сүмийн шүтлэгээр дамжуулан, амар амгалан, итгэл найдварыг эрэлхийлэгч бүх хүмүүст Есүс Христийн тухай



Бид итгэлтэй хоньчид, Симеон, Анна болон Мэргэн хүмүүсийн итгэлтэй хариултуудыг тунгаан бодсоноор өөрсдийгөө уйтгар гуниг, төөрөгдлөөсөө гаргаж, Дэлхийн гэрэл өөд аваах илүү үр өгөөжтэй арга замыг мэдэж чадна.

гэрчлэх замаар өөрсдийгөө харанхуй үеэс талархлын гэрэлд өргөн гаргаж чадна.

Мэргэн хүмүүс

Эцэст нь, алс холоос аялан ирж “зүүнтэйд Түүний одыг хараад” (шүлэг 2), тэмдгийг ойлгосон Мэргэн хүмүүсийн тухай бид Матай 2-оос уншдаг. Тэд өндөр хүндэтгэл, гүн бишрэлийн бэлгэдлийг илэрхийлсэн бэлгүүдийг бэлтгэн Түүнийг хайсаар ирж, “Саяхан мэндэлсэн иудейчүүдийн Хаан хаана байна вэ?” гэж асуусан юм. (шүлэг 2). Тэдний эрэл сая дуусч, Христ хүүхдийг олоод, “сөгдөн Түүнд мөргөж, эрдэнэсийн хайрцгаа нээгээд, алт, гүгэл, мирийг бэлэг болгон барив (шүлэг 11). Тэд Херодын залиг мэдсэнээс гадна “Херод уруу бүү буцаж оч гэж Бурхан зүүдэнд нь анхааруулсанд ондоо замаар нутгийн зүг оджээ” (шүлэг 12). Мэргэн хүмүүс Бурханаас ирсэн илчлэлтийн дагуу

үйлдэж, энэ ариун гэр бүлийг Херодын хорон санаанаас хамгаалсан юм.

Мэргэн хүмүүсээс сурах зүйл бидэнд их бий. Бид тэдний нэгэн адил судруудыг судалж, дэлхийг Аврагчийн Хоёр дахь Ирэлтэд бэлтгэхийн тулд тэмдгүүдийг харж мэддэг байх ёстой. Хэрэв бид судруудыг судалж, тунгаан бодох юм бол өдөр тутмын амьдралдаа Их Эзэнийг эрэлхийлэх илүү их хүсэлтэй болж, Түүнд бэлэг болгон аминч үзэл, бардамнал, эсэргүүцэгч санаа бодлоо орхих болно. Бидний хийсэн төлөвлөгөөг өөрчлөх тухай хувийн илчлэлт ирсэн үед энэ нь бидний хувьд дээр гэдгийг Бурхан мэдэж байгаа гэдэгт итгэлтэй байж, дуулгавартай дагах хэрэгтэй. Бид жинхэнэ шавийн амьдралаар амьдарч, Аврагчийг хайраар, даруу төлөв байдлаар, өвдөг сөгдөн шүтэн бишрэх ёстой.

Бид шавь болсон тохиолдолд хонин сүргээ билчээрт нь хариулах юм уу гандмал цөлийг туулахыг биднээс шаардахгүй. Аврагч руу очих бидний аялал бол явганаар юм уу хөсгөөр хийх аялал биш; энэ бол сүнсний болон зан төлөвийн аялал. Түүний Цагаатгал хязгааргүй бөгөөд бидний амьдралын бүх тал—нүгэл хилэнц, сул дорой байдал, өвчин эмгэг, зовлон зүдгүүр бүгдийг хамардаг тэрхүү үнэнийг хүлээн зөвшөөрч чин сэтгэлээсээ хүлээн авах явдал энэ аялалд багтана (Алма 7:11–13-ыг үз). Энэ бол биднийг харанхуй манан руу чирч гулдардаг зүйлсээс бид ангижрч, Дэлхийн Гэрлийн халуун бүлээн хайран дотор амьдарч чадна гэсэн үг юм. Тэргүүн Зөвлөлийн Нэгдүгээр зөвлөх, Ерөнхийлөгч Хенри Б.Айрингийн сургаснаар: “‘Христэд ирэгтүн’ гэдэг үгс бол урилга юм. Энэ бол та өөр хүнд санал болгож чадах хамгийн чухал бэлэг мөн. Энэ бол хүмүүний олж авч чадах хамгийн чухал урилга юм.”³ ■

Эшлэл

1. Томас С.Монсон, “The Spirit Giveth Life,” *Ensign*, 1985 оны 5-р сар, 70.
2. Жишээ нь, Ховард В.Хантер, “The Great Symbol of Our Membership,” *Tambuli*, Nov. 1994 оны 11-р сар, 6-г үз.
3. Хенри Б.Айринг, “Come unto Christ,” *Ауахона*, 2008 оны 3-р сар, 49.



“Ирээдүйн талаар би хэрхэн өөдрөг үзэлтэй байх вэ?”

Урам хугарч, сэтгэлээр унан, муу мэдээ сонсох нь хувь хүнд ч, бүр дэлхийн төвшинд ч байнга тохиолддог юм шиг санагдах үе бид бүгдэд байдаг. Гэвч Их Эзэн Есүс Христэд итгэх итгэлийнхээ учир найдвартай байх учир шалтгаан бидэнд бий гэдгийг бид санах ёстой.

Ерөнхийлөгч Томас С.Монсон, “зоригтой байх тухай” (С ба Г 68:6) Их Эзэний зарлигийг 2009 оны дөрөвдүгээр сарын ерөнхий чуулган дээр бидэнд сануулж, дараах урам хайрласан үгсийг хэлсэн юм: “Аянгын бараан үүлс хуралдаж, аадар бороо бидэн дээр цутгаж мэдэх ч, хэрэв бид зөв шударга амьдарч, зарлигуудыг сахьвал сайн мэдээний тухай бидний мэдлэг, Тэнгэрлэг Эцгээ болон Аврагчийг хайрлах бидний хайр тайтгарлыг авчирч, биднийг дэмжих болно. Биднийг ялах юу ч энэ дэлхийд байхгүй.”

Бүх зүйл туйлын бараан баргар, тэнгэрийн хаяан дахь айсуй шуурга өчүүхэн төдий ч намдах янзгүй байлаа ч сайн мэдээний тухай бидний мэдлэг ирээдүйн талаар байнга өөдрөг үзэлтэй байхад бидэнд тусалж чадна. Ерөнхийлөгч Монсон мөн тэр хэлсэн үгэндээ: “Ирээдүй та нарын итгэл лүгээ адил гэрэл гэгээтэй байна” гэсэн юм (“Be of Good Cheer,” *Лиахона*, 2009 оны 5-р сар, 92).

Унш, залбир, инээмсэглэ



Хэдэн жилийн өмнө Залуу Эмэгтэйчүүдийн ерөнхий ерөнхийлөгчийн зөвлөл Мормоны Номыг өдөр бүр уншиж, өдөр бүр залбирч, инээмсэглэж байх онцгой даалгаврыг бидэнд өгсөн юм. Энэ даалгаврыг чадах чинээгээрээ сайн биелүүлэхийг хичээх юм шүү гэж би дотроо бодож билээ. Гайхалтай нь энэ даалгавар миний амьдралд үлэмж өөрчлөлт авчирсан юм. Би өмнөхөөсөө илүү аз жаргалтай болж, Сүнс надтай хамт байж, өөдрөг бодол санаатай байх болов. Бэрхшээл тохиолдсоор байсан ч, Сүнсний хүч чадал үүнийг даван туулахад надад тусалж байлаа.

Ариана Г., нас 16, Виржини, АНУ

Итгэл найдвартай бай

Өөдрөг санаа бодолтой байхын төлөө бидний хийж чадах хамгийн сайн зүйл бол ямагт инээмсэглэж, итгэл найдвартай байх явдал мөн! Итгэл найдвар нь миний амьдралын туршид тоо томшгүй олон арга замаар надад тусалсан. Бид бас хэчнээн их адислагдсанаа, Тэнгэрлэг Эцэг маань бидэнд хэчнээн их хайртайг мэдэж, энэ тухай боддог байх ёстой. Бид ямар ч нөхцөлд Түүнд хандан амар амгаланг хүсч болно. Түүний Хүү бидний төлөө зовлон эдэлсэн болохоор бидний зовлон зүдгүүрийг тэр мэднэ. Түүний ачаар бид итгэл найдвартай байж, эдгэрэн, ингэснээр мэдээж аз жаргалтай байж чадна.

Кори Д., нас 18, юта, АНУ

Итгэлтэй хэвээр үлд



Ороо бусгаа энэ цаг үе бол Их Эзэний төлөвлөгөөний нэг хэсэг бөгөөд Хуучин Гэрээний үеэс энэ үеийн тухай угтан хэлсээр ирсэн юм. Зөв шударга хүмүүс хамгаалагдан, адислагдах болно гэдгийг Их Эзэн бүх судруудад амласан юм. Чи итгэлтэй хэвээр байвал энэхүү ороо бусгаа цаг үед Ариун Сүнс чамайг удирдан, тайтгаруулж, өөрт чинь зориулсан төлөвлөгөө Их Эзэнд байгааг чамд сануулах болно. Хэрэв чи патриархын адислалаа авсан бол Их Эзэн чамд зориулж юу бэлтгэснийг мэдэхийн тулд үүнийг уншиж бай.

Рae Б., нас 17, Колумб дүүргийн Вашингтон, АНУ

Цагаатгалын тухай бод

Аврагчийнхаа Цагаатгалын тухай бодох нь итгэл найдварыг үргэлж төрүүлж, өөдрөг үзэлтэй байхад бидэнд тусална. Бид бүгд энэ амьдралд хүнд сорилтуудтай тулгардаг.

Хариултууд нь туслах болон ирээдүйг харахад зориулагдсан бөгөөд Сүмийн сургаалын албан ёсны мэдэгдэл биш юм.

Гэвч Цагаатгалаар дамжуулан материаллаг болон сүнсний аливаа хүнд сорилтууд болоод асуудлуудыг шийдэж болно. Эдгээр шийдлүүдийг олж харах боломжийг Цагаатгал бидэнд олгодог. Цагаатгал бол хүүхдүүдээ: хайрлах Бурханы агуу хайрын илрэл мөн. Энэ хайр хязгааргүй бөгөөд Тэрбээр бид бүгдэд хайртай. Энэ нь ирээдүйг айдасгүйгээр утгахад бидэнд урам зориг, хүч чадал өгдөг.

Дари А., нас 18, Лагуна, Филиппин

Адислалуудынхаа тухай бод



Энэхүү зовлонтой цаг үед надад баяр баясал, итгэл найдварыг өгдөг зүйлсийн нэг бол адислалуудынхаа тухай, сайн мэдээний мэдлэгийнхээ тухай тунгаан бодоход цаг гаргадаг явдал мөн. Сайн анд найзтай байх юм уу, эсвэл авралын төлөвлөгөө мэтийн ямар нэг агуу зүйл намайг баяр баясгалантай байж, энэхүү баяр баясгалангаа хуваалцах хүсэлтэй болгодог. Чухамдаа энэ нь намайг өөдрөг санаа бодолтой байлгадаг. Аннет М., нас 15, Мичиган, АНУ

Ариан сүмийг сана



Би санаагаар унасан үедээ Залуу Эмэгтэйчүүдийн эрхэмлэх зүйлсийн төгсгөл дэх дараах үгсийг тунгаан боддог: “Бид эдгээр эрхэмлэх зүйлсэд итгэн хүлээн авсан бөгөөд энэ дагуу үйлдвэл, гэр орон, гэр бүлээ бэхжүүлэн ариун гэрээнүүд хийж, ариун сүмийн ёслолуудыг хүлээн авч, өргөмжлөлийн адислалуудыг эдлэхэд бэлтгэгдэх болно.” Би эдгээр үгсээс тайтгарлыг олдог. Мөн эдгээр үгс миний амьдралд бас ариун журамт бүх залуу эмэгтэйчүүдийн амьдралд биелэгдэх болно гэдгийг мэднэ. Ариун сүмийн эрхэм нандин адислалуудад би ямар ч эргэлзээгүйгээр

итгэдэг. Зөв шударга амьдралын адислалууд эцэс төгсгөлгүй юм. Эдгээр зүйлсийг санасан үед зүрх сэтгэл минь баяр баясал, итгэл найдвар, хайр энэрэл, урам зоригоор дүүрдэг билээ.

Наталия М., нас 18, Мерида, Венесуэл

Ялагч багт бай



Чи зөв санаа бодолтой байхын тулд: Их Эзэний баг бол эцэст ялагч мөн гэдэг энгийн үнэнийг мэдэх хэрэгтэй. Энэ бол амархан.

Бурханыг ялах хүч Сатанд байхгүй. Бид ялагчийг мэдэх учраас Их Эзэний багт байнга байхад анхаарал төвлөрүүлэх хэрэгтэй. Бид ариун сүмд орохоор зохистой амьдарснаар Их Эзэний багт байгаагаа Түүнд харуулах дүрэмт хувцсаа өмсдөг билээ. Бид судруудаа уншиж, залбиран, ах, эгч нартаа үйлчилснээр жинхэнэ аз жаргалыг олох бөгөөд ингэснээр зөв бодол санаатай болох нь амар хялбар юм. Брейдент Ф., нас 17 Юта, АНУ

Талархалтай зан төлөвийг өөртөө бий болго

Төвөгтэй цаг үед бүү анхаарал төвлөрүүл. Би “Талархлын тэмдэглэл” хөтөлж, тухайн өдөр талархлаа илэрхийлэх ёстой, хамгийн наад тал

нь нэг зүйлийн тухай өдөр бүр бичдэг. Тухайн өдөр хэчнээн бараан баргар байсан ч, баярлан талархах зүйлийг би ямагт олдог. Адислалуудаа тоол. Талархлыг хөгжүүлэх нь амьдралынхаа гэрэл гэгээтэй, сайн сайхан зүйлс дээр анхаарал төвлөрүүлэхэд тань туслах болно.

Ашли Х., нас 18, Оклахома, АНУ



ТА НАРЫН ГАЙХАМШИГТАЙ ИРЭЭДҮЙ

Миний залуу найз нар аа, эдгээр жишгүүдийг бүх зүрх сэтгэлээрээ сахьж,

судруудад байдаг сайн мэдээний үнэнүүдээр амьдрах хүсэлтэй байхыг Их Эзэн та нараас хүсэн хүлээдэг юм шүү. Хэрэв та нар ийм байх юм бол, одоогийн байгаагаасаа бүр илүү гарч, агуу боломжууд хийгээд үүрэг хариуцлага бүхий гайхалтай, гэрэл гэгээтэй ирээдүйгээ үзэх болно. Та нар шаргуу ажиллах хүсэлтэй, урт удаан хугацаанд тэвчих чадвартай байж, амьдралыг үзэх өөдрөг үзэлтэй байх болно.”

Ерөнхийлөгч Диетер Ф.Угдорф, Тэргүүн Зөвлөлийн хоёрдугаар зөвлөх, “See the End from the Beginning,” *Лиакхона ба Ensign*, 2006 оны 5-р сар, 44.

ДАРААГИЙН АСУУЛТ

“Найз нарыгаа Ариун сүмийн тухай асуухад өөрөө ч мэдэхгүй байж би юу гэж хариулах вэ?”


Хариугаа 2012 оны 1-р сарын 15 гэхэд дараах хаягаар ирүүлнэ үү:

Liahona, Questions & Answers 1/12
50 E. North Temple St., Rm. 2420
Salt Lake City, UT 84150-0024, USA
хаягаар шуудангаар явуулж болно.
Эсвэл и-мэйл: liahona@ldschurch.org

Хариултын хэмжээг тохируулах болон тодорхой болгохын тулд хянан засварлаж болно.

И-мэйл буюу захидалдаа дараах мэдээлэл болон зөвшөөрлийг оруулна уу: (1) бүтэн нэр, (2) төрсөн он сар өдөр, (3) тойрог буюу салбар, (4) гадас буюу дүүрэг, (5) таны хариулт болон гэрэл зургийг нийтлэхийг зөвшөөрсөн өөрийн чинь бичгээр гаргасан зөвшөөрөл, 18 нас хүрээгүй бол, эцэг эхийн бичгээр гаргасан зөвшөөрөл (и-мэйл байж болно).

ЧИ ХЭЗЭЭ Ч ГАНЦААРАА БИШ



“Би та нарыг өнчрүүлж орхихгүй.
Би та нар уруу ирнэ”
(Иохан 14:18).

Их Эзэн олон адислалыг юүлсэн юм

“Бурхан гэж хэн юм бол?” хэмээн би гайхдаг байлаа. Будда юу, Есүс Христ үү? Эсвэл өөр бурхан байна уу?”

Ким Коунг

Би ихэнх хүмүүс нь Буддын шашинтнууд байдаг Камбожид төрсөн хүн. Кхмер Раужийн дэглэм үй олон хүний амийг хөнөөсний дараа, хэрэв Бурхан байдаг юм бол яагаад манай хүмүүст ийм юм тохиолдохыг тэрээр хүлцэн тэвчсэнийг амьд мэнд үлдэгсдээс олон нь ойлгоогүй юм. Тэр үед 14-тэй байсан би ч гэсэн үүнд гайхдаг байлаа.

Тус дэглэм нуран унасны дараа Камбожид нэлээд хэдэн шашныг хүлээн зөвшөөрсөн юм. Сүмүүд маш их ялгаатай зүйлсийг заадаг болохоор би учраа олохгүй явлаа. Манай гэрийнхэн Буддын шүтлэгтэй хэвээр үдлээ. Харин би: бид хаанаас ирсэн юм бол, яагаад энд байгаа юм бол, энэ амьдралын дараа бид хаашаа явах бол? гэсэн сэтгэлийг минь эзэмдсэн асуултуудын хариуг мэдэхийг хүсдэг байлаа.

Нэг өдөр намайг хичээлээсээ ирэхэд цагаан цамц, зангиатай хоёр залуу гэрт ирж, Есүс Христийн тухай ярилаа гэж авга эгч маань надад хэллээ. Тэд Камбож хэлээр сайн ярьж байсанд авга эгч гайхсан гэнэ. Би

Христийн тухай, бас биднийг хэн бүтээснийг мэдэхийг хүсч байлаа. “Бурхан гэж хэн юм бол?” хэмээн би гайхдаг байлаа. Будда юу, Есүс Христ үү, эсвэл өөр бурхан байна уу?”

Авга эгч бид хоёр номлогчдыг хүлээн авлаа. Бид эхний ярилцлагын үеэр тэдний ярьсан зүйл үнэн шүү хэмээн Ариун Сүнс хэлэхийг мэдэрсэн. Тэд бидэнд нэг Мормоны Ном өгөөд, хэрэв бид үүнийг уншиж, тунгаан бодоод Бурханд итгэх

итгэлтэйгээр Түүнээс чин сэтгэлээсээ асуух юм бол Тэрээр бидэнд үнэнийг үзүүлэх болно хэмээн амлав. Энэ ном намайг олон юмны талаар тунгаан бодоход хүргэсэн юм. Би авга эгч болон түүний хүүхдүүдийн хамт сайн мэдээг хүлээн авлаа. Бид сар орчмын дараа баптисм хүртэж, гишүүнээр батлагдлаа.

Би семинарт 4 жил, институтэд нэг жил явсны дараа семинарын багшаар үйлчлэв. 19-тэйдөө номлолд үйлчлэх ёстойгоо мэдэрлээ. Аав, ээж хоёртойгоо ярилцахад тэр хоёр намайг дэмжсэн болохоор би өргөдлөө өглөө. Сарын дараа би англи, камбожоор ярьдаг Калифорнийн Сакраменто номлолд үйлчлэх дуудлага хүлээн авлаа.

Би дуудлага хүлээн авсан учраас Бурхан надад олон адислал өгсөн юм. Миний эрэгтэй дүү зөвшилдвэр гаргаж чаддаггүй байлаа. Би дүүгийнхээ төлөө мацаг барин, залбирсны ачаар намайг номлолдоо явахаас өмнө нэгэн гайхамшиг тохиосон юм. Би дүүдээ баптисм хүртээлээ. Одоо тэр Сүмд идэвхтэй төдийгүй семинарт ч мөн явж байна. Миний гэр бүл өөр олон адислал хүлээн авсан. Мөн Их Эзэн миний номлолын үед надад олон адислал юүлсэн билээ.

Есүс бол Христ. Тэр амьд. Тэр бидний хүн нэг бүрд хайртай, биднийг нэрээр мэддэг. Тэр бидэнд тохиолддог сорилт бэрхшээлүүдийг мэддэг. Бид Түүний зарлигуудыг сахих юм бол Тэр биднийг адислах болно. ■



Далын Ахлагч

Карл Б.Прат



БАТ БӨХ ГЭРЧЛЭЛ

Би идэвхтэй Хожмын Үеийн Гэгээнтэн гэр бүлд төрж өссөн болохоор багаасаа бат бөх гэрчлэлтэй байсан гэж боддог. Би хэзээ ч сайн мэдээ үнэн эсэхэд эргэлзэж байгаагүй. Би олон өсвөр үеийнхний нэгэн адил, заримдаа юмсын талаар эргэлздэг ч, Сүм үнэн биш гэж огт бодож байсангүй.

Чухам ийм итгэл л намайг номлолд үйлчлэхэд сүнслэгээр нөлөөлсөн юм. Би үйлчлэх хэрэгтэйгээ мэдэж байлаа. Сүмийн талаар аливаа ноцтой эргэлзээ надад байдаггүй ч, өөрөө гэрчлэлтэй болох хэрэгтэй гэдгийг би мэдсэн юм.

Би 1961 оны хоёрдугаар сард өвлийн хүйтнээр Солт Лейк хо-тоос зуны халуун төөнөж байсан Аргентиныг зорьж билээ. Тэр үед номлогчдоод зориулан хэлний сургалт хийдэггүй байсан ч, Мормоны Номыг бүгдийг нь чангаар уншсаны дараа испаниар чөлөөтэй ярьдаг болно гэж манай номлолын ерөнхийлөгч бидэнд амлаж билээ. Би испани хэлийг бүр бага байхдаа сурсан учир эхний хэдхэн долоо хоногийн дараа чөлөөтэй ярьдаг

болсон ч номлолын ерөнхийлөгчийнхөө зааврыг дагадаг байлаа.

Хамтрагч бид хоёр анхны томилогдсон хотдоо хуучин дэлгүүрийн ар тал дахь жижигхэн сууцанд орлоо. Бид Аргентины үдийн унталтын үеэр үдээс хойш номлолын ажил хийж болдоггүй байсан учир би тэр цагийг хуучин дэлгүүрийн орох хаалганы дэргэд залбирах болон Мормоны номыг уншихад ашигладаг байв.

Нэг өдөр би гэрээсээ хэдэн мянган километр алс хол орших тэр дэлгүүрийн өмнө зогсоод уншсан зүйлийнхээ талаар бодлоо. Таныг залбирч, Мормоны Номын тухай тунгаан бодоход Сүнс танд нөлөөлнө. Мормоны Ном юу заадаг тухай, Иосеф Смит ялтсуудыг орчуулсан тухай тунгаан бодтол нэг бодол толгойд зүрсхийн орж ирлээ. Амьдралын минь туршид надад заасан юм бүхэн үнэн гэдгийг би тэр үед мэдэж билээ. Иосеф Смит бошиглогч мөн гэдэг нь бас би Бурханы үгийг уншиж байгаа гэдэг нь гэнэт надад маш тодорхой мэдэргдэв. Энэ бүгд үнэн байлаа.

Тэрхүү гэнэтийн мэдрэмж үнэхээр сэтгэл догдлом байлаа. Энэ нь толгойноос хөлийн хуруу хүртэл бүх биенд минь цахилгаан цахих лугаа адил мэдрэгдсэн бөгөөд хүйт оргисон ч үгүй, халуу шатсан ч үгүй. Харин энэ бол бат бөх гэрчлэл байлаа.

Би тэр өдрийг хэзээ ч мартахгүй. Тэр цагаас хойш Ариун Сүнсийг тун ч олон удаа мэдэрсэн дээ. Тэрхүү туршлагынхаа ачаар би Ариун Сүнс надад гэрчилж буйг мэддэг болсон. Тэрхүү мэдрэмж үргэлж адилхан байдаггүй ч үргэлж бүлээн дулаан, амар тайван байдаг билээ.

Сүнс бидний хүн тус бүрд хандан ярьдаг ч, Моронайн амлалт хүн бүрд хамаатай юм (Моронай 10:3–5-ыг үз). Мормоны Номон дахь Моронайн амлалт бол хэрэв та Мормоны Номыг уншиж, судлан, тунгаан бодож, үнэн санаа бодолтойгоор залбирах юм бол энэ ном үнэн гэдгийг Ариун Сүнс танд гэрчлэх болно гэсэн амлалт юм. Энэхүү амлалт надад, танд бас дэлхий дэх хүн бүрд хамаатай юм. Бат бөх гэрчлэлтэй болохыг эрэлхийлсэн хүмүүс ийм гэрчлэлтэй болно. ■

БУРХАНД ИЛҮҮ ОЙРТОГТУН

“Би ах нарт хэлсэнчлэн Мормоны Ном бол энэ дэлхий дээрх бусад бүх номноос хамгийн зөв нь, мөн манай шашны тулгуур чулуу, түүнчлэн бусад ямар ч номноос илүүтэйгээр, түүний зааврыг мөрдсөнөөр л хүмүүн Бурханд илүү ойртох болой.”

Иосеф Смит, *Сүмийн ерөнхийлөгчдийн сургаалаас: Иосеф Смит (2007)*, 64.



ЭНЭ НЬ

ТА НАРТ ТЭМДЭГ

БОЛНО

“Дэлхий эхэлснээс хойш бошиглож асан бүр бүх бошиглогчид—тэд эдгээр зүйлийн талаар их бага боловч ярьсан бус уу?” (Мозая 13:33).

Витни Хинкли

Христийн Мэндэлсний Баярыг бэлэг өгч авах, сайн хоолоор дайлах, хүндтэй баяр болгон тэмдэглэхийг хэн хүнгүй хүсэн хүлээдэг билээ. Зарим үед арванхоёрдугаар сарын эхний 24 өдөр хэтэрхий урт юм шиг санагдах нь ч бий. Хэрэв та 1000 жил хүлээх хэрэгтэй болвол яах вэ!

Аврагчийн төрөлт буюу Христийн Мэндэлсний анхны Баярыг Хуучин Гэрээний Исаагаас Мормоны Номны лемен хүн Самуэлыг хүртэл хэдэн зуун жилийн турш бошиглосоор ирсэн билээ. Эрт үеийн бошиглогчид Есүс Христийн ирэлтийн тэмдгүүдийг мэдэж, Түүний ирэлтийг хүсэн хүлээдэг байсан бөгөөд тэдгээр тэмдгүүдийг тэвчээртэйгээр хүлээдэг байжээ. Бусад хүмүүс эдгээр тэмдгүүдийг мэддэг байхын төлөө тэд Түүний ирэлтийг бошиглон, Түүний ирэлтийн баяр хөөрийг хуваалцдаг байлаа! Эдгээр бошиглоуудын биелэлт нь Аврагч бөгөөд Гэтэлгэгч болох түүний бурханлиг дуудлагыг гэрчилсэн юм.

Есүс Христийн төрөлт болон үүний эргэн тойронд болж өнгөрсөн гайхамшигтай нөхцөл байдлын тухай дараах бошиглоуудыг уншиж, эдгээр бошиглоууд хэрхэн биелэгдсэнийг мэдэж ав.

Онгон бүсгүй Мариагаас төрсөн нь

Бошиглолуд: Мариаг төрөхөөс долоон зуун жилийн өмнө түүнийг Христийн эх байх болно хэмээн бошигложээ. Исааа бичсэн нь, “Эзэн өөрөө чамд нэгэн тэмдэг өгнө. Үзэгтүн! Нэгэн онгон бүсгүй хүүхэдтэй болж, хүү төрүүлээд, Түүнийгээ “Иммануел” гэж нэрлэнэ” (Исааа 7:14).

Бага Алма бас Мариаг Аврагчийн эх байна гэдгийг Есүсийн төрөлтөөс 80 орчим жилийн өмнө Исаагийн

амьдарч байсан газраас дэлхийн нөгөө талд ийн бошиглосон юм: “Тэр Мариагаас төрөх болно, . . . тэр нь онгон бүсгүй, Ариун Сүнсний хүчээр бүрхэгдэж, мөн хөл хүнд болгогдон, мөн хүү төрүүлнэ, тийм ээ, бүр Бурханы Хүүг тээгч болж, сонгогдсон, хонгорхон нэгэн байх болно” (Алма 7:10).

Биелэлт: Наян жилийн дараа тэнгэр элч Габриел . . . “Иосеф гэдэг хүнтэй сүй тавьсан онгон бүсгүйн гэрт хүрч ирлээ. Түүнийг Мариа гэдэг байв (Лук 1:27). Мариа Бурханы Хүү Есүсийн эх болов.

Бидний төлөө хүүхэд төрөв

Бошиглол: Мессиагийн төрөлтийн тухай Исааа ийн бошигложээ: “Учир нь бидний төлөө хүүхэд төрж, бидэнд хүү өгөгдөнө. Засаглал Түүний мөрөн дээр байх болно. Түүний нэрийг Гайхамшигт Зөвлөгч, Хүчит Бурхан, Мөнхийн Эцэг, Энхийн Жонон гэж дуудна” (Исааа 9:6).

Биелэлт: Аврагчийн үйлчлэл Исаагийн бошиглосон бүхнийг гүйцэлдүүлсэн юм. Учир нь Христ туйлын даруу байдалд төрсөн юм. “Өнөөдөр Давидын хотод Аврагч, Эзэн Христ та нарын төлөө мэндэллээ. . . . Тэжээлийн тэвшинд байх даавуунд өлгийдсөн нялх хүүхдийг та нар олж харна” (Лук 2:11–12).

Бетлехемд төрсөн нь

Бошиглол: бошиглогч Мика Исаатай нэгэн үед амьдарч байжээ. Тэрбээр Их Эзэнийг Бетлехем тосгонд төрнө хэмээн бошиглосон юм: “Харин чиний хувьд, Бетлехем Ефрата аа, хэдийгээр чи Иудагийн бүлүүдийн дунд өчүүхэн авч, Миний төлөө Израилыг захирах Нэгэн нь чамаас гарах болно. Түүний гарч ирэх нь эртнээс, мөнхийн өдрүүдээс байсан юм” (Мика 5:2).



Биелэлт: Долоон зуун жилийн дараа Херод шинэ захирагчийг хаанаас олж болохыг өөртөө хэлэхийг хуулийн багш нартаа зарлиг болгож, “Христ хаана төрөх ёстойг лавлаж эхлэв.” Тэд түүнд, “Иудейн Бетлехемд гэж хэлэв” (Матай 2:4–5).

Давидын үр сад болох тухайд

Бошиглол: Их Эзэн Христийг төрөхөөс зургаан зууны өмнө Тэрбээр Давидын үр удмаас гарах болно хэмээн Иеремиад хэлжээ: “Тэр өдрүүдэд болон тэр цагт, Би Давидын зөв шударга Мөчрийг гаргана. Тэрээр газар дэлхий дээр шударга ёс болон зөв шударгыг гүйцэтгэнэ” (Иеремиа 33:15).

Биелэлт: Их Эзэн хэрхэн эртний сурвалжит хааны үр сад болохыг Матай бидэнд Христийн уг удмаар бидэнд харуулсан юм: “Абрахамын удам, Давидын удам, Есүс Христийн угийн бичиг.” Есүс Христ . . . Ийнхүү Абрахамаас Давидыг хүртэл бүгд арван дөрвөн үе, Давидаас Вавилон уруу цөлөгдөх хүртэл арван дөрвөн үе, Вавилон уруу цөлөгдсөнөөс Христийн үеийг хүртэл арван дөрвөн үе байв” (Матай 1:1, 17).

Хаад түүнийг үзэхээр ирнэ


Бошиглолууд: Христ даруухан нөхцөлд төрсөн ч Түүнийг үзэхээр хаад ирэх болно гэдгийг бошиглогчид мэдэгдсэн юм: “Үндэстнүүд чиний гэрэл уруу, хаад нь чиний мандах туяа уруу ирнэ” (Исаиа 60:3).


Лемен хүн Самуел Христийн төрөлтөөс таван жилийн өмнө Түүний ирэлтийн тэмдгүүдийг нифайчуудад зарлан тунхагласан юм. Тэдгээр тэмдгүүдийн нэг нь Мэргэн хүмүүсийн дагаж явсан од юм: “Та нарын хэзээ ч тийм нэгнийг болгоогоогүй тэрхүү нэгэн шинэ од гарах болно, мөн энэ нь түүнчлэн та нарт тэмдэг байх болно” (Хиламан 14:5).

Биелэлт: Мэргэн хүмүүс бошиглолуудын биелэлтийг хайж байсан учраас тэд ямар тэмдгийг эрэхээ мэдэж байсан ажээ. “Саяхан мэндэлсэн иудейчүүдийн Хаан хаана байна вэ? Бид зүүнтэйд Түүний одыг хараад Түүнд мөргөхөөр ирлээ” (Матай 2:1–2) гэж хэлэх ёстой үгээ хэллээ.

Шинэ Дэлхийд (Америк тив) нифайчууд бас тэмдгүүдийг таньж, бошиглолууд биелэгдсэнийг мэджээ: “Мөнхүү энэ нь, тийм ээ, бошиглогчдын үгсийн дагуу, нэгбүрчлэн улиран тохиожээ.” “Мөнхүү улиран тохиох дор түүнчлэн нэгэн шинэ од үгийн дагуу үзэгдэв” (3 Нифай 1:20, 21).

Удаан хүлээсэн Христийн Мэндэлсний Баярын бэлгээ нээж үзээд хэчнээн их баярладгаа бод л доо. Та энэ бэлгийг Христийн төрөлтийн тэмдгүүдийг удаан хүлээсний эцэст тэдгээр нь биелэгдсэнийг харсантай харьцуулбал ямар санагдах вэ? Бидний Тэнгэрлэг Эцэг дэлхий дахины итгэлтнүүд Түүний Хүүгийн төрөлтөд хамтдаа баярлахын төлөө төдийгүй бас Христийн бурханлиг дуудлагыг гэрчлэхийн төлөө эдгээр тэмдгүүдийг урьдчилан өгсөн юм. ■





Утга учиртайгаар сонгосон бэлэг

Мэргэн хүмүүс Иосеф, Мариа хоёрт яагаад алт, гүгэл, мирр бэлэглэсэн бэ?

Олон хүмүүс үүнийг бэлэг өгөхдөө бодолцож үзэх санаа гэж үздэг. Энэ нь бэлгийн утга санаа нь зөвхөн хэрэгтэй буюу сонирхолтой юм байх төдийгүй бас бэлэг хүлээн авагчийг бэлэг өгөгч нь хайрлан, хүндэтгэдгийн бэлгэдэл болдог учраас ийм байж магадгүй. Зарим бэлэг нь зөвхөн бэлгийн утга санааг илэрхийлээд зогсохгүй бас энэхүү утга санаан дээр илүү чухал санааг нэмсэн бэлгэдлийн өргөн хүрээтэй утга санааг агуулсан байдаг. Бэлэг нь дараах гурван шинж чанартай—бэлэг авагчид хэрэгтэй байх, бэлэг өгөгч нь түүнийг хайрлан хүндэтгэдгээ илэрхийлсэн байх болон бэлгэдлийн утга санаатай байх нь түүнийг хамгийн ухаарлгаар сонгосон,

бүхнээс илүү үнэ цэнэтэй бэлэг болгодог.

Мэргэн хүмүүс Христ хүүд алт, гүгэл, мирр бэлэглэсний цаад утга санааг бод (Матай 2:11-ийг үз). Мэргэн хүмүүс яагаад ийм бэлэг авчирсныг Библид өгүүлдэггүй ч гурван бэлэг нь бүгдээрээ чухал хэрэгтэй зүйл бөгөөд Бурханы Хүү болон Түүний дэлхийн эцэг эхийн хувьд бэлгэдлийн утгатай байсан биз ээ.

Алт

Ашиг тус: Херодын уур хилэнгээс зугтаахын тулд удахгүй Египет уруу явах залуу хост холын аяны зардалд нь алт үнэлж баршгүй бэлэг болох байв.

Бэлгэдлийн утга: Алт бол чухамдаа хаадад өгдөг бэлэг юм (Хаадын Дээд 9:14, 28-ыг үз) учир нь энэ түүний хаан язгуурын бэлгэдэл бөгөөд “Хаадын Хаанд” (1 Тимот 6:15) өргөн барихад тохирох бэлэг юм.

Гүгэл

Ашиг тус: Гүгэл нь мөнгөөр үнэлбэл их үнэтэйгээс гадна тансаг үнэртэн болон үнэртэй ус болгон хэрэглэдэг байжээ.

Бэлгэдлийн утга: Гүглийг чихэрлэг модны давирхайнаас гаргаж авдаг бөгөөд санваарын ёслолууд, шатаалт тахил (Левит 2:1-ийг үз) болон санваартнуудыг тослоход хэрэглэдэг байжээ. Тийнхүү гүгэл нь Их Эзэний санваар болон бидний төлөө амиа золиосолсон Бурханы Хурга болж золиослогдсон Түүний үүргийг төлөөлж болно (Иохан 1:29-ийг үз).

Мирр

Ашиг тус: Модны давирхайнаас гаргаж авдаг гашуун амттай тос, мир нь мөнгөөр үнэлбэл мөн их үнэтэй ч, Мариа, Иосеф хоёрын хувьд эм болгон хэрэглэхэд илүү чухал байсан бололтой.

Бэлгэдлийн утга: Шинэ Гэрээний үед миррийг анхилуун үнэртэн болгон, юмыг муутгахгүй удаан хадгалах болон оршуулганд ихэвчлэн хэрэглэдэг байжээ (Иохан 19:39–40-ийг үз). Миррийг анагаах ухааны зорилгоор ашигладаг нь Христийн Эзэн Эдгээгчийн үүргийг бэлгэдсэн байж болох юм. Түүнчлэн миррийг оршуулганд ашигладаг байсан нь Тэрээр бидний нүглийн төлөө зовлон эдэлж, “гашуун аяганаас” (С ба Г 19:18–19-ийг үз) уухыг бэлгэдсэн байж болох юм. ■



Тэг ӨӨРЧЛӨГДӨХ ЁСТОЙ

Намайг баптисм хүртэхэд манай гэрийнхэн Сүмийг эсэргүүцдэг байлаа. Иймээс манай гэрийнхний амьдралын хэв маяг сайн мэдээний зарчмуудад харшилж байгаад хэрхэн хариулахаа сайтар бодох хэрэгтэй байлаа.

Франциско Хавиер Лара Хернандес

Би баптисм хүртсэн үедээ сайн мэдээг хүлээн авсан гэр бүлийнхээ цорын ганц гишүүн байлаа. Тэгэхэд би 19-тэй байв. Баптисм хүртсэндээ баяртай байлаа. Мексикийн Веракруз дахь Панюкогийн Нэгдүгээр салбарын ах, эгч нар надад баяр хүргэн халуун дотноор хүлээж авлаа. Түүнээс гадна би Сүмийн гишүүн болоод нэг жил болмогцоо бүрэн цагийн номлолд үйлчлэхээр бэлтгэж эхлэв. Үнэн Сүмийг мэдсэн нь миний хувьд гайхалтай байсан болохоор би сайн мэдээг бусадтай хуваалцахыг хүсч байлаа.

Манай аав, хойд ээж (ээж минь намайг 12-той байхад өөд болсон юм), гурван эрэгтэй дүү мааь намайг баптисм хүртэхэд Сүмийг эсэргүүцдэг байлаа. Харамсалтай нь, би тэдэнд сайн хариултыг өгч чаддаггүй байв. Тэд намайг хүндэтгэдэггүй байв. Би ч гэсэн аавыг эсвэл түүний санаа бодлыг тоодоггүй байв. Номлолд үйлчлэх гэж байгаагаа аавд хэлэхэд тэр баяртай байсангүй. Учир нь би ажил хийхээ больж, бас тэгээд гэрээсээ алс хол явах байв. Манай гэр бүлийн амьдралын хэв маяг

миний баримталдаг зарчмуудтай зөрчилддөг, жишээ нь ням гарагт миний хувьд тохиромжгүй телевизийн хөтөлбөр үздэг, зохисгүй хөгжим сонсдог нь эсвэл мацгийн ням гарагт аав намайг хоолонд урих бүрд миний сэтгэл зовдог байлаа.

Би Сүмийн гишүүний хувьд ямар ч буруу зүйл хийдэггүй гэдгээр өөрийгөө гэр бүлтэйгээ тааламжгүй харилцаатай байснаа зөвтгөдөг байв. Тэд надад таагүй ханддаг байсан ч би сайн мэдээний зарчмуудаар амьдрах ёстой байлаа. Тэд өөрчлөгдөх ёстой гэж би өөртөө хэлдэг байсан. Ийм ч учраас аавтай харьцах харьцаа маань тийм ч сайн байгаагүй юм. Энэ байдал миний зан авир болон бардамналын улмаас улам муудсаар байлаа. Би аавынхаа сүнслэг, сайн сайхан байдлыг харгалзалгүйгээр энэ байдлаа үргэлжлүүлсээр байлаа.

Нэг өдөр институтийнхээ хичээлд сууж байгаад Нифай нумаа хугалснаас ан хийж хүнстэй залгах боломжгүй болсон 1 Нифай 16 дээр хүрч ирлээ. Хүн болгон, тэр тусмаа Лемең, Лемүел хоёр сурсан зангаараа бошиглогч эцэг Лихайн хамт дургүйцэн үглэж эхэлжээ. Нифай хариуд нь модоор нум, сум хийж, хүнстэй залгахын тулд анд хаашаа явбал зохихыг ааваасаа асуув. Аав нь удирдамж хүсэн залбирсанд Их Эзэн түүнийг дургүйцэн үглэсэнд нь зэмлэжээ. Лихай зэмлэлийг дуртай хүлээн авч гэр бүлийн тэргүүнийхээ болон Их Эзэний бошиглогчийн үүргийг өөртөө дахин авсан юм. Нифай аавыгаа сул дорой байсных нь төлөө шүүмжилсэнгүй, Нифай бүр Их Эзэнтэй ярьж, үзэгдэл хүлээн авсан үедээ ч эцэг нь үүнээс хойш бошиглогч байх ёсгүй гэж боддоогүй юм.

Би энэ шастирыг уншиж, ойлгоод гэр бүлтэйгээ хэчнээн тусгүй харьцаж байсан юм бэ дээ гэж бодлоо. Би гэрийнхнээсээ илүү сайн хүн гэж боддог байснаасаа, ялангуяа аавыгаа хүндэтгэдэггүй байснаасаа ичлээ. Сайн мэдээг гэрийнхэнтэйгээ хуваалцахыг эн тэргүүний зорилгоо болгоогүйдээ харамсав.

Гэрийнхэн маань хэрхэн өөрчлөгдөж болохыг би



Миний харьцаа хандлага аажмаар өөрчлөгдөв. Би аавтайгаа олонтоо санал зөрдөг ч, түүний санаа бодолд хүндэтгэлтэй хандахыг үргэлж хичээдэг байлаа.

харж чадаагүй байлаа. Зөвхөн тэдний сул тал дээр л анхаарал төвлөрүүлсэн байлаа. Тэр өдрөөс хойш миний харьцаа хандлага аажмаар өөрчлөгдсөн юм. Аавтайгаа олон юман дээр санал зөрдөг байсан ч санал бодлыг нь үргэлж хүндэтгэхийг хичээдэг болов. Намайг мацаг барьж байхад аав хоолонд урьвал, түүнтэй хамт хооллох боломжгүй байгаадаа уучлал гуйдаг болов. Ням гарагт тэдний үздэг телевизийн хөтөлбөр юм уу сонсдог хөгжимд би санаа зовохоо болилоо. Учир нь тэд надтай адил Тэнгэрлэг Эцэгтэй гэрээ хийгээгүй шүү дээ.

Нэг өглөө би аавд хоол хийхэд нь тусалж байхдаа түүнд хэчнээн их хайртайгаа хэлж, бүдүүлэг авир гаргадаг байсныхаа төлөө уучлал гуйв. Би бардам зантай байснаа мөн аавтайгаа эелдэг, дөлгөөн харилцаатай байхыг хүсдэгээ түүнд хэллээ.

Түүнээс хойш юм бүхэн өөрчлөгдөж эхэллээ. Санал зөрөлдөх нь багасч, бүр алга болов. Манай гэрийнхэн Сүмд нэгдэх хүртэл удаан хугацаа өнгөрнө дөө гэж би боддог байлаа. Гэтэл Сүмд хандах тэдний хандлага сайжрав. Хэрэв би эхлээд өөрчлөгдөөгүй бол ийм өөрчлөлт гарахгүй байсан юм.

Би Сүмийн гишүүн болсноос хойш нэг жилийн дараа Мексикийн Тихуана Номлолд бүрэн цагийн номлогчоор үйлчлэв. Номлолоос эргэж ирэхээсээ гурван сарын өмнө би манай гэрийнхэн сайн мэдээг хүлээж аваад байгааг мөн баптисм хүртэх тухай бичсэн захидал хүлээж авлаа. Намайг номлолоос эргэж ирэхэд тэд Сүмд нэгдчихсэн байсан юм.

Сүмийн гишүүн болсноос хойшхи 15 жилд Мормоны Номыг судалснаар болон Бурханы хүүхдүүдээс миний хүлээн авсан хамгийн агуу сургамжуудын нэг нь гэр бүлтэйгээ маш ойртон нягтарсан явдал мөн. ■



Иосеф Ахтай танилц

Иосеф Смит бол хожмын өдрүүдийн анхны бошиглогч байсныг та нар мэдэх ч тэрбээр инээх дуртай, бас хүмүүсийг инээлгэх дуртай байсныг, бас эхнэр Эммагийнхаа хамт ихэр хүүхэд өргөж авсныг мэдэх үү? Бошиглогч Иосефын тухай та нарын мэдэхгүй байж болох бусад зарим зүйлийн тухай доор өгүүлье:

- Бага Иосеф Смит 1805 оны арванхоёрдугаар сарын 23-нд АНУ-ын Вермонтын Шаронд төржээ. Аавынх нь нэрийг түүнд өгсөн аж. Иосефын ах, дүү нарыг насных нь дарааллаар нэрлэвэл: Альвин, Хайрум, Софрония, Самуел Харрисон, Эфраим, Виллям,

Катерин, Дон Карлос, Люси нар болно.

- Иосеф долоотой байхдаа гэдэсний хижгээр өвчилжээ. Тэр гэдэсний хижгээсээ эдгэрсэн ч, зүүн хөлөндөө халдвартай үлдсэн гэнэ. Мэдээ алдуулах ямар ч ямар ч эм хэрэглэлгүйгээр түүний биенээс есөн ширхэг ясыг авсан гэнэ. Тэрээр амьдралынхаа үлдсэн хутаганд үл мэдэг доголж явдаг байжээ.¹
- Иосеф анх удаа чангаар залбирч, Тэнгэрлэг Эцэг, Есүс Христ хоёрыг харахдаа 14-тэй байлаа (Иосеф Смит—Түүх 1:17-г үз).
- Ах Альвин нь Иосефыг 17-той байхад нас баржээ. Бараг 13 жилийн дараа Иосеф Альвиныг селестиел хаант улсын тухай үзэгдэлд харсан ажээ (С ба Г 137:5–7-г үз).
- Эммагийн аав Айзик Хейл Иосефт дургүй байсан бөгөөд тэдний гэрлэлтийг дэмждэггүй байжээ. Иосеф, Эмма хоёр оргохоор шийдэж, тэгээд 1827 оны 1-р сарын 18-нд гэрлэсэн гэнэ.²
- Эмма, Иосеф хоёр гэрлээд 17 жил болж, 11 хүүхэдтэй болсны 6 нь бага насандаа энджээ.
- 1832 онд танхайрагч бүлгийнхэн түүнийг зодох үеэр нэг шүд нь булгарч унасан учир Иосеф тультарч ярьдаг болов.³
- Иосеф тоглох дуртай байв. Тэр бөмбөг, бөх, цасан бөмбөлгөөр шидэлцэх, загасчлах, саваа татах зэрэг тоглоомуудад дуртай байжээ.⁴
- Эхэн үеийн нэгэн Хожмын Үеийн Гэгээнтэн Иосефын дуу “Тэнгэрийн аянгатай” адилхан байсан хэмээн дүрсэлжээ.⁵
- Иосеф хүч чадал ихтэй, 190 см орчим өндөр, 91 кг жинтэй байлаа.⁶
- Иосеф зөвхөн Сүмийн

Ерөнхийлөгч байсан төдийгүй, Нэгдсэн Улсын ерөнхийлөгчид нэр дэвшиж байжээ.⁷

- Иосефыг алагдсаны дараа тэр үед Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Ахлагч байсан Жон Тейлор (1808–87) түүний тухай, “Их Эзэний Бошиглогч хийгээд Үзмэрч Иосеф Смит энэ дэлхийд хүмүүний авралын тулд, зөвхөн Есүс Христийг эс тооцвол, үүн дээр амьдарч асан аль ч бусад хүнээс илүү ихийг хийсэн юм” (С ба Г 135:3) гэж бичжээ. ■

Эшлэл

1. *Presidents of the Church* (Church Educational System student manual, 2003), 3–4-ийг үз.
2. JosephSmith.net-ээс “Life of the Prophet: Joseph and Emma”-г үзнэ үү.
3. JosephSmith.net-ээс “Life of the Prophet: Friend of Man”-ыг үз.
4. Александр Л.Боф, “Joseph Smith’s Athletic Nature,” *Joseph Smith: The Prophet, the Man*-ыг үз, хянан тохиолдуулсан Сюзан Ийстон Блак, Бага Чарльз А. Тейт. (1993), 137.
5. Жозеф А.Робинзон, “Life of the Prophet: Teacher of God’s Truth,” JosephSmith.net.
6. Боф, “Joseph Smith’s Athletic Nature,” 138–39-ийг үз.
7. JosephSmith.net-ээс “Life of the Prophet: Leading with Love”-ыг үз.





Би АВРАГЧИЙГ хэрхэн ДАГАХ ВЭ?



Энэ сэдвээр
Арванхоёр Төлөөлөг-
чийн Чуулгын
Ахлагч Нийл
Л.Андерсен бодлоо
хуваалцаж
байна.



Бид Түүний зарлигуудыг
сахьж, Түүний хүүхдүүдэд үйл-
чилснээр Бурханыг хайрлах
хайраа харуулдаг.



Ариун ёслол нь бид Түүний
Хүүг санаж, Түүний зарлигуу-
дыг сахидгаа Бурханд гэрчлэн
баптисмын гэрээгээ шинэчлэх
боломжийг бидэнд олгодог
билээ.



Манай амьд бошиглогч, Ерөнхийлөгч
Томас С.Монсонг дагагтун. Тэр бол
Аврагчийг дагадаг хүний онцгой үлгэр
жишээ мөн.



Хэрэв бид бие биенээ
хайрлавал Түүний шавь нар
гэгдэх болно гэдгийг Аврагч
мэдэгдсэн юм.

Бид Есүс Христийг дахин ирэхэд Түүн-
тэй илүү адилхан болсон байхын тулд
Түүний нэрийг өөр дээрээ авч, Түүний
дүр төрхийг өөрийн дүр төрхөнд бий
болгох ёстой.

Бүдүүлэг үгс

Анги Бергстром Миллер

Бодит түүхээс сэдэвлэв.

*“Миний нэрээр хуурамчаар тангарагласнаараа өөрийн Бурханы нэрийг бүү гутаа”
(Левит 19:12).*

Шелбай бүдүүлэг үг хэллэг төдийгүй сургуулийнх нь найз нар Их Эзний нэрийг дэмий хоосноор хэрэглэж байгааг сонсох дургүй байлаа.

“Бүдүүлэг үгсийг миний дэргэд битгий хэлж байгаач” гэж тэр найз нартаа хэлдэг байв.

Гэвч тэд заримдаа мартчихна, тэгэхэд нь Шелбай дахиад сануулна.

Нэг өдөр түүний найз Бет нүдээ том болгон хараад, “Өө, золиг, би мартчихаж” гэв. Хэн ч Шелбайгийн дэргэд бүдүүлэг үг хэлдэггүй байв. Тэр биднийг өөртөйгөө адилхан *сайн* хүн болгохыг хичээж байна шүү дээ.”

Бусад охид инээлдэхэд.

Шелбай ичингүйрэв. Тэр өөрийнхөө дэргэд бүдүүлэг үгс хэлэхгүй байхыг найз нараасаа дандаа хүсдэгтээ, ялангуяа тэд бүдүүлэг үгс хэлэх нь муу зүйл гэж боддогтүйд санаа нь зовлоо.

Шелбай сургуулиасаа ирээд орон дээрээ хэвтээд өгөв. Хэдэн минутын дараа ээжийгээ ирэхэд Шелбай юу болсон тухайгаа ярилаа.

“Энэ тухай санаа зовохгүй байхыг хичээ” гэж ээж нь хэлэв. “Үргэлж зөв зүйлийг хийж бай, тэгвэл найз нар чинь яваандаа бүдүүлэг үг хэлэхгүй болно шүү дээ.”

“Найз нар маань бүдүүлэг үг хэлэхэд яагаад энэ нь надад асуудал болдог билээ?” гэж Шелбай өөрөөсөө асуув. “Би ямар өөрөө ингэж байгаа биш.”

“Бүх цаг үед Сүнсийг мэдрэхийн тулд бид өөрийгөө зохистой байлгах ёстой гэж бошиглогчид сургадаг шүү дээ. Бүдүүлэг үгс Сүнсийг гомдоодог” гэж ээж нь хэлэв.

Шелбай гэр бүлийн үдэш дээр гэрчлэлээ хэлсэн үед Сүнсийг мэдэрсэн үеүдийнхээ тухай, ааваасаа адислал авсан тухайгаа саналаа. Шелбай Сүнсийг мэдрэх дуртай ажээ. Тиймээс элэгсэг дотно харьцаа, амар амгалан байдалд харшлах ямар ч зүйлийг хийхийг хүсдэггүй байлаа.



Тэрээр найз нартаа үлгэр дууриал үзүүлэхийг үргэлж санан, бүдүүлэг үг хэллэг сонсох дургүйг нь ойлгоход тэдэнд туслахыг боддог байлаа.

Маргааш нь дахиад л сургууль дээрээ бүдүүлэг үг сонслоо.

“Бүдүүлэг үг миний дэргэд битгий хэлж байгаач” гэж Шелбай Беккагаас хүсэв.

Бекка Шелбайг ширтэн харснаа юу ч хэлсэнгүй. Шелбай хэлсэн үгэндээ хангалуун байсан ч найз нь дургүйцсэнд гунигтай болов.

Шелбай дахин хэн нэгэн нь бүдүүлэг үг хэлэхийг завсарлагаанар сонсов. Энэ удаад бүдүүлэг үгийг Бет хэлсэн аж.

“Ийм үгийг миний дэргэд битгий хэлээч” гэж Шелбай гуйлаа.

Бет “уучлаарай” гэж хэлээд нүдээ эргэлдүүлэн тохуурхсан байдалтай харав.

Шелбайд дахиад эвгүй санагдав.

Шелбай хичээлийн дараа софтбол тоглон бөмбөг цохив. Бөмбөг нь эхний нүхийг чиглэн өнхөрсөн ч Шелбайг тэнд очихоос өмнө нүх рүү орчихов. Багийн шинэ охин Бонни Их Эзэний нэрийг дэмий хоосноор хэлэхийг Шелбай сонсоод эргэлзэн бодлогоширлоо. Тэр өөрийнхөө дэргэд бүдүүлэг үг хэлэхгүй байхыг хүмүүсээс гуйсаар бүр залхжээ. Бусад охид өөрөөр нь доог тохуу хийхийг тэр хүссэнгүй.

“Бүдүүлэг үгийг түүний дэргэд битгий хэлж байгаач.”

Хэн ингэж хэлснийг мэдэхийн тулд Шелбай эргэж харлаа.

Шелбай бол Хожмын Үеийн Гэгээнтэн бөгөөд бүдүүлэг үг хэлдэггүй, тийм үг сонсох нь түүнд эвгүй байдгийг Бет Боннид хэлжээ.

Бонни эргэж Шелбайг хараад “Уучлаарай, Шелбай. Би мэдсэнгүй” гэв.

Бет Шелбайруу эргэж харан малилзан инээв. “Бид бүгдээрээ чамтай улам адилхан болж байгаа гэж би боддог шүү” гэж Бет хэллээ.

Шелбай инээмсэглэв. Тэр найз нартаа сайн үлгэр дууриал үзүүлж байх Сүнсийг өөртэйгөө хамт байлгах тухай бошиглогчийн зөвлөгөөг дагахаар шийдсэндээ баяртай байлаа. ■

“Би Тэнгэрлэг Эцэг, Есүс Христ хоёрын нэрийг хүндэтгэлтэйгээр хэрэглэх болно. Би хараалын болон бүдүүлэг үг хэлэхгүй.”

Миний сайн мэдээний жишгүүд

Бидний хуудас



Анги Д., нас 11, Перу



Ариана А., нас 9, Бразил



Есүсийн төрөлт, Анжелес Р.,
нас 10, Боливи



Ребека А., нас 7, Венесуэл

Христийн Мэндэлсний нэг Баяраар би сургуулийнхаа найзууд, багш нарт сүмийн танилцуулах карт нэлээд олныг өгсөн. Миний карт өгсөн нэг багш картан дээрх дугаараар утасдаж, Христийн Мэндэлсний Баярын DVD хүлээн авсан гэж нэгдүгээр сард надад ярьсан. Тэр DVD багшид их таалагдсан гэнэ. Сүмийн танилцуулах карт онцгой чухал зүйл гэж би боддог. Би картуудыг тарааж байхдаа Сүнсийг мэдэрсэн. Сайн мэдээг хуваалцах нь надад баяр баясгаланг авчирдаг. Есүс Христ амьд бөгөөд бид бүгдэд хайртайг би мэднэ.

Райане Р., нас 11, Бразил




Бидний хуудсанд зориулсан гар болон гэрэл зураг, туршлагаа сэдвийн шугаман дээр "Our Page" гэж бичин liahona@ldschurch.org хаягаар и-мэйлээр ирүүлнэ үү. Эсвэл:

Liahona, Our Page
50 E. North Temple St., Rm. 2420
Salt Lake City, UT 84150-0024,
USA хаягаар шуудангаар явуулж болно.

Ирүүлэх материалдаа хүүхдийн бүрэн нэр, нас, эцэг эх, тойрог буюу салбар, гадас буюу дүүргийн нэр, хүүхдийн гэрэл зураг, ирүүлсэн материалыг ашиглахыг зөвшөөрсөн эцэг эхийн зөвшөөрлийн бичиг (е-мэйлээр ирүүлж болно) байх ёстой. Ирүүлсэн материалуудыг тодорхой байдал, хэмжээнд тохируулан хянан засварлаж болно.

Ариун сүмийн карт

Та эдгээр картуудыг 2003 оны бүх дугаар, 2005 оны 4-р сарын болон 2007 оны 9-р сарын дугааруудад нийтлэгдсэн картууд дээр нэмж болно. Ариун сүмийн картыг liahona.lds.org-аас бүр олноор хэвлэн авч болно.



**Айдахогийн Рексбург
Ариун сүмийг**

2008 оны 2-р сарын 10-нд онцгойлон
адисалсан. Ерөнхийлөгч Томас С.Монсон



**Бразилын Куритиба
Ариун сүмийг**

2008 оны 6-р сарын 1-нд онцгойлон
адисалжээ. Ерөнхийлөгч Томас С.Монсон



**Панамын Панам хотын
Ариун сүмийг**

2008 оны 8-р сарын 10-нд онцгойлон
адисалсан байна. Ерөнхийлөгч Томас С.Монсон



**Айдахогийн Твин Фоллс
Ариун сүмийг**

2008 оны 8-р сарын 24-нд онцгойлон
адисалжээ. Ерөнхийлөгч Томас С.Монсон




**Ютагийн Дрейпер
Ариун сүмийг**

2009 оны 3-р сарын 20-нд онцгойлон
адисалсан. Ерөнхийлөгч Томас С.Монсон




**Ютагийн Оквиер Маунтейн
Ариун сүмийг**

2009 оны 8-р сарын 21-нд онцгойлон
адисалсан байна. Ерөнхийлөгч Томас С.Монсон




**Британий Колумбын Ванкувер
Ариун сүмийг**

2010 оны 5-р сарын 2-нд онцгойлон
адисалжээ. Ерөнхийлөгч Томас С.Монсон



**Аризоны Гила Валли
Ариун сүмийг**

2010 оны 5-р сарын 23-нд онцгойлон
адисалжээ. Ерөнхийлөгч Томас С.Монсон



**Филиппиний Себу
Ариун сүмийг**

2010 оны 6-р сарын 13-нд онцгойлон
адисалжээ. Ерөнхийлөгч Томас С.Монсон

Чи Хүүхдийн Хэсгийн энэ сарын сэдвийн тухай илүү ихийг мэдэхийн тулд энэ хичээл болон үйл ажиллагааг ашиглаж болно.

Судрууд

Аврагчийн төрөлт ба Хоёр дахь Ирэлтийн тухай надад заадаг

Женнифер Мадди

Сүмийн сэтгүүлүүд

“Хүний Хүү тэнгэр элч нарын хамт Эцэгийнхээ алдрын дотор ирж, хүн бүрд үйлсийнх нь дагуу хариуг өгнө” (Матай 16:27).

Бурханы Хүү Есүс Христ дэлхийд төрнө гэдгийг бошиглогчид мянга мянган жилийн туршид гэрчилж байв. Эдгээр бошиглогчид юу гэж хэлж байсныг бид судруудаас уншиж болно. Хуучин Гэрээнд Исаиа Есүс бол Энхийн Жонон байх бөгөөд Тэрээр үнэн Сүмийн тэргүүн байх болно хэмээн хэлжээ. Мормоны Номонд Нифай Есүсийн эх Мариаг үзэгдлээр харж, мөн дэлхий дээр хүмүүст зааж байгааг харжээ. Хаан Бенжамин Христ дэлхийд ирсэн үедээ үйлдэх гайхамшгуудын тухай өөрийн хүмүүст заасан байдаг.

Аврагчийг төрөхөөс хэдхэн жилийн өмнө бошиглогч Самуел



хотын хэрмэн дээр ирээдүйд тохиох тэмдгүүдийн тухай нифайчуудад ярьжээ. Аврагчийг төрөхөд тэнгэрт шинэ од гарч ирнэ хэмээн тэр хэлжээ. Мэргэн хүмүүс Христ хүүг олохын тулд дагаж явсан одны тухай бид Шинэ Гэрээнээс уншдаг билээ.

Есүс Христ дэлхийд хоёр дахь удаагаа ирэх тухай бошиглогчид мөн судруудад заадаг. Моронай Мормоны Номонд Аврагч эргэж ирэхийг гэрчилсэн байдаг.

Хуучин Гэрээнд Малахи Хоёр дахь Ирэлтийн өмнө эцсийн өдрүүдэд юу тохиох тухай өгүүлсэн байдаг.

Есүс Христийн тухай бошиглогчдын гэрчлэлийг судрууд түүхийн янз бүрийн үед агуулж ирсэн юм. Бид Есүсийн үлгэр жишээний тухай бас судруудаас уншдаг. Түүнийг дэлхий дээр амьдрахаар эргэж ирэх үед бэлтгэхийн тулд бид Түүний үлгэр жишээг дагах хэрэгтэй.

ҮЙЛ АЖИЛЛАГАА

Та нар Есүс Христийн амьдралын тухай өөрийн зурагт номыг хийж болно. 65-р хуудсан дээрх зургуудыг хайчилж ав. Хуудас бүрийг заасан газраар нүхэлж, хуудсуудыг дугаараар нь үд. Хуудсуудыг нүхээр нь сүвлэн үдэхийн тулд утас ашигла. Гэр бүлийн үдшийн үеэр энэ номыг гэрийнхэндээ үзүүлж, Аврагчийн амьдралын тухай ярилцаж болно. ■

1



2



3



4



5



6



7



8



9





ХРИСТИЙН МЭНДЭЛСНИЙ БАЯРЫН СҮЛД МОД

Харриет Р.Угдорф

Дэлхийн II Дайн дөнгөж дуусаад байсан тэр үед Германы олонх хүмүүст хоол хүнс, мөнгө гэдэг нүдний гэм болоод байв. Миний төрсөн өдөр Христийн Мэндэлсний Баяраас хэдхэн долоо хоногийн өмнө болох байлаа. Би хэдийгээр жаахан охин байсан ч аав ээж хоёр минь амь зуулгаа залгуулах гэж арга чаргаа барж байсныг сайн мэдэж байсан болохоор Христийн Мэндэлсний Баяр эсвэл төрсөн өдрийн бэлэг авна гэж бодсонгүй. Манай том хотод чухамдаа өлсгөлөн нүүрлээд байв. Тэр үе баргар, уйтгар гунигтай байлаа.

Миний төрсөн өдөр гал тогооны өрөөний ширээн дээр надад гоё сайхан бэлэг тавьсныг хараад гайхахын ихээр гайхаж,

баярласан гэдэг нь. Энэ бол *Weihnachtsbaum* буюу ердөө 30 см өндөр, гараар чамин хээ гаргаж урласан мөнгөн цаасар бүрсэн, Христийн Мэндэлсний Баярын жижигхэн сүлд мод байлаа. Ийм гоё бэлэг авна гэж би үнэндээ төсөөлөө ч үгүй. Зочны өрөөний гэрэл сүлд модны мөнгөн цаасан дээр тусахад хэчнээн гоё харагдаж байсан гээч. Мөнгөн цаасан дээр гаргасан хээг ажиглавал элсэн чихрийг хатуу чихэр болгон цаасан хээнүүдийг дүүргэсэн нь үнэхээр гайхалтай байлаа. Энэ бэлэг чухамдаа гайхамшиг байлаа. Ээж энэ жижигхэн мод, мөнгөн цаас, ховор нандин зүйл болох элсэн чихрийг хаанаас олсон юм бол?

Эдгээр ховор зүйлс нүдний гэм болсон тэр үед ээж ийм гайхамшигийг хэрхэн бий болгосныг би

өнөөдрийг хүртэл мэддэггүй. Энэ бэлэг намайг хайрладаг эх эцгийн минь эгнэшгүй хайрын бэлгэдэл, итгэл найдвар, хайр энэрлийн болон Христийн Мэндэлсний Баярын жинхэнэ утга учрын бэлгэдэл болон зүрх сэтгэлд минь оршсоор байдаг билээ.

Бид Христийн Мэндэлсний Баярын үеэр энэ баярын сүлд модыг цахилгаан гэрэл болон элдэв янзын хээнүүдээр чимэн гэртээ тавьдаг. Бид хүүхдүүд, ач зээ нартайгаа хамт байгаа үед гоё сайхан сүлд мод, гялалзсан гэрлүүд нь зүрх сэтгэлийг минь бүлээцүүлж, гялалзсан мөнгөн цаасаар чимсэн тэрхүү жижигхэн сүлд мод гэр оронд минь авчирсан баярт дурсамжийг эргэн санагдуулдаг. ■



Харриет Р. Угдорф нь Тэргүүн Зөвлөлийн 2-р Зөвлөх, Ерөнхийлөгч Угдорфтой гэрэлсэн.

Гар хийцийн чимэглэл

Сүлд модны гар хийцийн чимэглэл хийж гэрийнхнээ баярлуулаарай! Юу хэрэгтэйг дор жагсаав:

Бялуу зүсдэг хутга, жижигхэн шилэн аяга
Картын зузаан цаас буюу үзүүлэнгийн самбар
харандаа
хайч
мөнгөн (тугалган) цаас
шингэн цагаан цавуу
самбарын үзэг (эсвэл өнгийн харандаанууд)
мяндсан утас, тууз эсвэл нарийхан уяа

1. Бялуу зүсэгч болон шилэн аягыг хатуу цаасан дээр тогтоо.
2. Дүрсийг хайчлахад аав, ээж хоёрынхоо нэгнээр туслуул.
3. Хэсэг мөнгөн цаас хайчилж аваад цаасан дүрсийг бүр. Мөнгөн цаасны ирмэгийг чимэглэлийн ар талд наа. (Хэрэв чи мөнгөн цаас ашиглаагүй бол энэ үйлдлийг орхиж, үлдсэн үйлдлүүдийг хий.)
4. Чимэглэлийн дундуур шугамууд гарган нимгэхэн цавуу түрх. Цавууг хаттал нь байлга.
5. Цавуу түрхсэн шугамуудын хоорондох зайг будахын тулд самбарын үзэг ашигла. (Хэрэв чи мөнгөн цаас ашиглаагүй бол будгийн харандаа хэрэглэж болно.)
6. Чимэглэлийн оройд нүх гаргахад аав ээжийнхээ аль нэгээр туслуул. Гаргасан нүхээрээ мяндсан утас, тууз буюу уяаг сүвлэж, оройд нь уя.
7. Чимэглэлээ гэр бүлийнхээ *Weihnachtsbaum* дээр тавих буюу бэлэг болгон өг.





Миний НОМЛОЛЫН сан

Спенсер С.

Энэ нь хачирхалтай сонсогдож мэдэх ч гэсэн, би номлолынхоо зардалд зориулж, төрөхөөсөө өмнө мөнгө хадгалсаар ирсэн юм. Ээж минь хөл хүндтэй болсноо мэдээд сүүний хоосон лааз авч, нүх гаргаад “Номлолын сан” гэсэн хоёр үгтэй хаяг наасан гэдэг. Тэр цагаас хойш манай гэр бүл бас би өөрөө номлолдоо зориулж мөнгө хадгалсаар байгаа.

Миний номлолд зориулж мөнгө хадгалах нь манай гэрийнхний нэгэн ажил болсон юм. Намайг төрсний дараа манайд ирсэн авга, нагац нар маань миний номлолын сангийн лаазанд Филиппиний песо хийдэг болжээ. Христийн Мэндэлсний Баяраар эсвэл Шинэ Жил мэтийн баяраар манай гэр бүлийн гишүүд номлолын сандаа нэмэрлээрэй гэж надад мөнгө өгдөг байлаа.

Заримдаа өвөө, эмээ хоёр намайг хичээлдээ сайн дүн авах юм уу тэмцээнд амжилт гаргасны төлөө надад мөнгө өгдөг байв. Ийм бэлгүүдийг ч бас номлолын сандаа

нэмэрлэнэ. Нэг удаа би хэдэн медаль авахад нагац эгч маань миний авсан бүх медалийг тоолж, медалийн тоогоор надад мөнгө өгч билээ.

Аравны нэгээ төлсний дараа энэ мөнгийг бас л номлолын сандаа нэмэрлэсэн.

Баптисм хүртсэний дараа номлолд үйлчлэх хүсэл минь улам ч өсөв. Манайхан миний номлолын зардлыг бүрэн төлөхөд хүрэлцэх мөнгө хуримтлуулах зорилго тавилаа. Би одоо дүү нартай болсон учир бидний хадгалсан мөнгөнөөс тэдний номлолын санд бас нэмэрлэх болов.

Би одоо естэй. Ингэхлээр номлолд үйлчлэх насныхаа бараг талд нь ороод байна. Миний номлолын санд ийм олон хүмүүс хандив өгдгийг мэдэх учир номлолд үйлчлэх хүсэл минь улам өсөн нэмэгдлээ.

Би номлолдоо зориулж мөнгө хуримтлуулахаа үргэлжлүүлэх болно. Нэгэн өдөр номлогч болж түүнд үйлчлэхээр Тэнгэрлэг Эцэг минь намайг адисална гэдгийг би мэднэ. ■



ИТГЭЛИЙН ТУНХАГ

БИД БУРХАН, Мөнхийн Эцэг, Түүний Хүү Есүс Христ болон Ариун Сүнсэнд итгэдэг” (Итгэлийн Тунхаг 1:1).

2 Хүмүүн Адамын зөрчлийн улмаас бус өөрсдийн нүглүүдийн улмаас шийтгэгдэх болно гэдэгт бид итгэдэг.

3 “Христийн Цагаатгалаар дамжин Сайн мэдээний хуулиуд хийгээд ёслолуудад дуулгавартай байснаар бүх хүн төрөлхтөн аврагдана гэдэгт бид итгэдэг” (Итгэлийн Тунхаг 1:3).

4 Бид Сайн мэдээний анхдагч зарчим болон ёслол нь, нэгдүгээрт: Их Эзэн Есүс Христэд итгэх итгэл, хоёрдугаарт: Наманчлал, гуравдугаарт: Нүглээс ангижрахын тулд усанд умбуулан хийгдэх баптисм, дөрөвдүгээрт: Толгой дээр гар тавиулан хүртэх Ариун Сүнсний бэлэг гэдэгт итгэдэг.

5 Сайн мэдээг номлох хийгээд үүний ёслолуудыг гүйцэтгэхийн тулд хүн бошиглолоор мөн эрх мэдэл бүхий тэдний гар тавилтаар Бурханаас дуудагдах ёстой гэдэгт бид итгэдэг.

6 Анхны Сүмд байсан тэрхүү зохион байгуулалтад, тухайлбал төлөөлөгчид, бошиглогчид, пасторууд, багш нар, евангелистууд болон бусдад бид итгэдэг.

7 Хэлний, бошиглолын, илчлэлтийн, үзэгдлийн, эдгээхийн, хэлнүүдийн хөрвүүлгийн болон бусад бэлэгт бид итгэдэг.

8 Библи зөв орчуулагдсан байхын хэрээр Бурханы үг мөн гэдэгт бид итгэдэг; тэрчлэн Мормоны Ном бол Бурханы үг мөн гэдэгт бид итгэдэг.

9 Бурханы илчилсэн бүгдэд, эдүгээ түүний илчилж буй бүгдэд бид итгэдэг, мөн Бурханы хаант улсад хамаарах олон агуу хийгээд чухал зүйлийг Тэрээр цаашид илчлэх болно гэдэгт бид итгэдэг.

10 Израил жинхэнэ ёсоор нэгдэж, мөн Арван овог дахин сэргэж, Сион (Шинэ Иерусалим) Америк тивд байгуулагдах болно гэдэгт; мөн дэлхий шинэчлэгдэж, мөн диваажингийн алдар суугаа хүлээн авах болно гэдэгт бид итгэдэг.

11 Ухамсрынхаа шаардлагын дагуу Бүхнийг Чадагч Бурханыг шүтэн бишрэх онцгой боломжийг бид шаардаж байна, мөн энэхүү онцгой боломжийг бүх хүмүүст зөвшөөрч, хэрхэн, хаана, эсвээс юуг шүтэн бишрэх нь тэдний хэрэг гэдгийг хүлээн зөвшөөрдөг.

12 Бид хаад, ерөнхийлөгчид, удирдагчид, мөн шүүгчдэд захирагдаж, хуулийг дуулгавартай даган, хүндлэн дээдэлж, дэмжих ёстой гэдэгт итгэдэг.

13 Шударга, үнэнч, ариун явдалтай, нинжин сэтгэлтэй, ач буянтай байхад мөн бүх хүмүүст сайн сайхныг үйлдэхэд бид итгэдэг; чухамдаа – бид бүх зүйлд итгэдэг, бид бүх зүйлд найддаг, бид олон зүйлийг хүлцэн тэвчлээ, мөн бүх зүйлийг хүлцэн тэвчих болно гэдэгт найддаг гэсэн Паулын зөвлөгөөг бид дагадаг хэмээн хэлж болно. Хэрэв ариун журамтай, сайхан эсвээс сайн гэгддэг буюу сайшаалтай ямар нэгэн зүйл байдаг бол, бид эдгээр зүйлсийг эрэлхийлдэг.

Иосеф Смит.

Христийн Мэндэлсний Баярын өөр нэгэн сүлд мод

Элиана Осборн

Бодит түүхээс сэдэвлэв.

*“Буулгыг минь өөр дээрээ авч, Надаас сурали,”
(Матай 11:29).*

1. Христийн Мэндэлсний Баяр болох гээд Карлосын хөл нь газарт хүрэхгүй баярлана. Энэ жил гэр орон нь нэг л өөр байлаа. Том сүлд модыг гялалзсан ногоон цаасаар хийж хаалганд бэхэлсэн байлаа.

Ээж ээ,
сүлд модыг яагаад хаалганд
бэхэлсэн юм бэ?

Энэ жилийн
Христийн Мэндэлсний Баярыг
арай өөр хийх гэсэн юм.

2. Тэр өөр юм нь юу байх юм бол гэж Карлос боджээ. Эгч Арасели, бяцхан эрэгтэй дүү Диего нь бас гайхсан гэнэ.

4. Карлост энэ санаа тун их таалагдав. Арасели цаасан чимэглэлүүдэрүү очиж, улаан өнгийн харандаа шүүрэн авлаа.

Есүс
баптисм хүртэв.

Эдгээр цаасан чимэглэлүүдийг би сүлд модондоо зориулж хийсэн юм. Бид Есүс Христийн тухай ямар нэг зүйлийг өдөр бүр цаасан чимэглэл дээр бичиж, сүлд модон дээр тавьдаг байлаа. Христийн Мэндэлсний Баярын өмнөх үдэш сүлд модыг цаасан чимэглэл бүхэлд нь бүрхсэн байх болно!

Энэ цаасан чимэглэл тун догь болжээ. Есүс олон гайхамшиг үйлдсэн тухай би бичиж болох уу?

Тэгвэл ч ёстой мундаг болно доо. Та хоёр үнэхээр хосгүй санаа сэджээ!

5.



6. Орой бүр хоолны дараа Арасели, Карлос хоёр өөр нэг цаасан чимэглэл хийж, сүлд модон дээрээ тавилаа. Диего Есүст хайртай гэдгээ хэлж тэдэнд туслав.



7. Өөр санаануудын тухай бодох нь хэцүү байсан болохоор тэд судраас харав. Есүсийн тухай маш олон шүлэг байдгийг Карлос мэддэггүй байжээ!



8. Христийн Мэндэлсний Баярын өмнөх үдэш тэднийхэн гэрээрээ олон дуу дуулж, сүлд модон дээрх цаасан чимэглэлүүдийг уншив. Карлос Есүсийн тухай өдий их зүйлийг мэдсэндээ баяртай байлаа. Тэрээр энэ жилийн Христийн Мэндэлсний Баярт бэлэн болсноо мэдлээ.




ЯЛГААГ ОЛ

Энэ хүүхдүүд Есүсийг төрөхөд болсон
үйл явдлуудыг жүжигчлэн тоглож, Есүс


Христийн тухай олон зүйлийг мэддэг болжээ.
Доорх хоёр зураг дахь есөн ялгааг ол.



БУДАХ ХУУДАС



ХРИСТИЙН МЭНДЭЛСНИЙ БАЯРЫН ТҮҮХ



Эцэг эхчүүдэд зориулсан зөвлөмж

Анхны Христийн Мэндэлсний Баярын тухай түүхийг Лук 2-оос уншина уу. Хоёр зурган дээр дүрслэгдсэн үйл явдлуудыг хүүхдүүдээ уншиж өгөхдөө зургийг өөрсдөөр нь будуулах цаг гаргаж өгөөрэй.

Номлолын шинэ ерөнхийлөгчид итгэлийнхээ ачаар адислагдав

Хеатл Витл Ригли

Сүмийн сэтгүүлүүд

Зургадугаар сард номлолын 128 шинэ ерөнхийлөгч болон тэдний эхнэр үүрэгт ажлаа эхлэхээр мордохынхоо өмнө заавар хүлээн авахаар АНУ-ын Ютагийн Провод уригдлаа.

2011 оны зургадугаар сарын 22-26-ны өдрүүдэд болсон дөрвөн өдрийн семинарыг Ерөнхийлөгч Томас С.Монсон нээж үг хэлэхдээ, “Та бүхэн Сүмийн хамгийн итгэлтэй гишүүдийн дундаас шилэн сонгогдсон бөгөөд эдүгээ Их Эзэний ургацын талбай уруу явах боломж та бүхэнд нээгдээд байна. . . . Та бүхний дуудагдсан номлолын талбараас илүү анхилуун сайхан үнэртэй, арвин их сарнай цэцэг ургуулдаг ямар ч талбайг би мэдэхгүй” гэжээ.

Дэлхийн 22 орноос ирсэн гэр бүлийн эдгээр хосууд 18 оронд үйлчлэх болно. Тэдний боловсролын төвшин өөр өөр ч адил нийтлэг зүйл бас тэдэнд бий.

Шинээр дуудагдсан номлолын ерөнхийлөгчид болон тэдний эхнэрүүд үйлчлэлдээ бэлтгэхийн тулд эд материалын болон сүнсний хувьд золиослол хийсэн ч итгэлийнхээ адислалуудыг бараг л тэр дороо харжээ.

Ямар золиослол хийдэг вэ?

Номлолын ерөнхийлөгчөөр үйлчлэх гурван жилд сорилт бэрхшээл, сэтгэл хөдөлгөм сүнслэг үйл явдал аль аль нь тохиолддог. Гэр бүлийн олон хос энэхүү дуудлагад бие сэтгэлээ бүрэн зориулдаг учраас гэр орны өмнөх амьдрал, ажил төрлөө цаашид хэвээр үргэлжлүүлдэг билээ.

Мэргэжлийн ажлаа орхих нь зарим тохиолдолд санхүүгийн хохиролд хүргэдэг. Сүм номлолын ерөнхийлөгчдөд багаахан хэмжээний тэтгэлэг олгодог ч, номлолын ерөнхийлөгч эхнэрийнхээ хамт ихэвчлэн уг тэтгэлэг дээр өөрсдийнхөө мөнгийг нэмж хэрэглэдэг.

АНУ-ын Хавай дахь Лайед оршин сууж байсан Маркус Мартинс, түүний эхнэр Мириан

Мартинс хоёрыг Бразилын Сан Пауло Хойд Номлолд үйлчлэх дуудлага хүлээн авахад нь Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Ахлагч Жеффри Р.Холланд, зохих хэмжээгээр золиослол хийх хэрэгтэй ч, хэтэрхий их золиослол хийхгүй байхыг тэдэнд зөвлөжээ.

Мартинсынхан гэртээ харьж, энэхүү саналыг хүлээн авахад хүрэлцэхүйц мөнгийг хэрхэн олж болохыг мэдэхийн тулд залбирсан гэнэ. Тэд байгаа бүхнээ зарав. “Бид байгаа юм бүхнээ ганцхан өдөр зарж чадсан нь адислал мөн. Энэ бол бидэнд тохиолдсон гайхамшиг” гэж Мартин эгч хэллээ.

Хүн бүхэн санхүүгийн золиослол хийх шаардлагагүй байж болох ч, номлолын ерөнхийлөгч бүр эхнэрийнхээ хамт ямар нэг байдлаар санхүүгийн золиослол хийх итгэлийн сорилттой тулгарах болно.

АНУ-ын Аризон мужийн Таксоны Гари, Рамела Расмуссен нар Японы Сендай Номлолд үйлчлэх дуудлага хүлээн авснаар зургаан хүүхэд, 23 ач зээ нараа орхин явах болсон ажээ.

“Тэнгэрлэг Эцэг хүүхдүүдэд маань надаас илүү сайн анхаарал халамж тавина гэдгийг би мэдэж байна. Бид үйлчлэхээр дуудагдсандаа баяртай байна. Бас энэ нь хүүхдүүдэд маань агуу адислал болно гэж бодож байна” гэж Расмуссен эгч хэллээ.

Номлолын ерөнхийлөгч болон түүний хамтрагчаар үйлчлэх дуудлага хүлээн авсан олон хүн золиослол хийх хүсэл эрмэлзэлтэй байдаг.

Аль нэг зүйл нь нэг хүнд маш хэцүү байхад нөгөө хүнд хэцүү биш байдаг учраас золиослол гэж чухам юу юм бэ гэдгийг би заримдаа эргэцүүлэн боддог” гэж ерөнхийлөгч Мартинс ярилаа. “Бид амьдралдаа Их Эзэнийг нэгдүгээрт тавих ёстой, Их Эзэний төлөө бүхнийг хийж, хаашаа ч гэсэн явах ёстой гэж . . . олон удаа заалгасан шүү дээ. Иймээс бид золиослол хийхдээ нөхцөл байдлынхаа тухай бодох ёсгүй. . . .



Золиослол бол онцгой боломж; байгаа бүхнээ золиосолно гэдэг нэр төрийн хэрэг юм.”

Бэлтгэлтэй байх нь

Номлолын ерөнхийлөгчид эхнэрийнхээ хамт номлолын үүрэгт ажлаа эхлэхээс өмнө материаллаг болон сүнслэг байдлын олон бэлтгэлийг хангадаг. Номлолын ерөнхийлөгчид ихэвчлэн зургаан сарын өмнө дуудагддаг ч, зарим үед бэлтгэл хангах цаг богинохон байдаг. АНУ-ын Ютагийн Эдений Брент Скотт, Анн Скотт нар номлолын ерөнхийлөгчдийн семинараас ердөө долоохон хоногийн өмнө, үйлчлэлээ эхлэхээс хоёрхон сарын өмнө Канадын Торонто Номлолыг тэргүүлэхээр дуудагдсан ажээ.

Тэд найз нөхөд, гэрийнхэндээ энэ тухай хэлж, гэр орноо зохицуулан, гарын авлагуудыг судалж, CD сонсон, сүнслэг байдлын бусад бэлтгэлүүдийг хангажээ. Гэвч тэд хамгийн үр өгөөжтэй бэлтгэлээ Номлогчийн Бэлтгэлийн Төв дэх семинараас хангасан гэнэ.

“Энд бид чухамдаа сүнслэг мэдлэгийн эх булгаас шимтэн хүртсэн юм. Их Эзэнд үйлчлэхээр золиослол хийсэн хүмүүстэй хамт байж, бошиглогчид, үзмэрчид, илчлэгчдээр заалгана гэдэг . . . бидний амьдралд тохиолдох хамгийн агуу үйл явдлуудын нэг үнэхээр мөн” хэмээн ерөнхийлөгч Скотт ярих.

Мэргэн ухаанд суралцсан нь

Зургадугаар сард болсон дөрвөн өдрийн семинарын төгсгөлд номлолын ерөнхийлөгчид болон тэдний гэргий нар Тэргүүн Зөвлөлийн болон Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын нэлээд хэдэн гишүүний захиасыг сонсож, сүнслэг байдлын тэжээл хүлээн авлаа.

“Бид тэдний заахыг сонсоод Их Эзэн бидэнтэй хамт байж, бидний төлөө санаа тавьж байсныг, энэ ажил бол Түүнийх гэдгийг, эдгээр хүмүүс бол Түүний үйлчлэгчид гэдгийг, Аврагчаа төлөөлөн номлол хийх онцгой боломж бидэнд тохиосныг мэдэрч байлаа” гэж Скотт эгч өгүүлэв.

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Ахлагч Рассел М.Нелсон номлолын ерөнхийлөгчид болон тэдний эхнэрүүд үүрэгт ажлаа амжилттай биелүүлнэ гэдэгт найдаж байгаагаа илэрхийлэв.

“Та бүхэн бие бялдар, оюун санаа, сүнслэг байдлаараа эрүүл саруул байж, Есүс Христийн сургаалаас суралцаж, заан, амьдралд хэрэгжүүлэх үйлсдээ амжилт олох болтугай. Та бүхэн гишүүдийн хүч чадлыг ашиглах чадвартай байж, ёслолуудад анхаарал төвлөрүүлэн, Их Эзэн болон Сүмийн гишүүд, түүнчлэн та нарт итгэмжлэл хүлээлгэн даатгасан гайхамшигт номлогчидтой нэг байна гэдэгт би итгэлтэй байна” хэмээн тэрбээр хэлжээ. ■

Шинээр дуудагдсан номлолын ерөнхийлөгчид номлолын талбарыг зорихоосоо өмнөхөн АНУ-ын Ютагийн Прово дахь Номлогчийн Бэлтгэлийн Төв дөрвөн өдрийн сургалтанд суулаа.

Долоон систер номлолын талбарт гэрлээ цацруулсан нь

Монголоор Шанага Долоо гэж нэрлэгддэг Эгч Дүү Долоо хэмээх алс хол оршигч одны ордын гэрэл дэлхийд иртлээ 350 жил болдог гэдэг.

Насныхаа дарааллаар хорь гарангаас эхлэн дөч дөхөж яваа энэ долоон эгч дүүс гэр бүлдээ болон таван орон дахь үйлчилж байгаа номлолын талбартаа сайн мэдээг хуваалцан гэрлээ цацруулж явна.

Марисол (Чилийн Осорно), Антони (Аргентины Ресистенси), Даниела (Коста Рикагийн Сан Хосе), Флоренси (Гондурасын Комягуела), Вероника (Чилийн Зүүн Сантьяго), Анаи (Гватемала Хойд Сити), Балбина Нава Агвилар (Аргентины Бахиа Бланка) нар Мексикээс эдүгээ Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн номлогчоор нэгэн зэрэг үйлчилж байна.

Эдгээр эгч нар орон нутгийн цуглааны байруудад явагддаг байсан төлбөргүй англи хэлний

хичээлд явдаг байх үедээ Хожмын Үеийн Гэгээнтэн номлогчидтой анх тааралдсан ажээ. Тэд 2006 онд аль өөрийнхөө нэг эгч, эрэгтэй дүүтэй хамт баптисм хүртсэн ажээ. Гучин жилийн өмнө Сүмд элссэн тэдний эцэг эх Албино Нава, Исайдра Агвилар хоёр тэр үед сүмд эргэн ирж бүрэн идэвхтэй болсон гэнэ.

“Долоон охиноо номлолд явуулсны ач буяныг би үзэж чадна.

Охид маань Их Эзэний мутарт ажиллан, улам олон хүмүүсийг Түүнд авчрахын тулд Түүний сайн мэдээг номлож байна” хэмээн Агвилар эгч хэллээ.

“Би сайн мэдээнд дуртай. Их Эзэний ажил хүмүүсийн амьдралыг өөрчилдгийг би мэднэ. Энэ ажил миний амьдралыг өөрчилсөн, бас миний зааж байгаа хүмүүсийн амьдралыг өөрчлөх болно” гэж Флоренси хэлэв.

Эгч дүү долоо 2011 оны сүүлчээр номлолоосоо эргэж ирнэ. ■

Ерөнхий эрх мэдэлтнүүд дэлхий даяарх Сүмийн гишүүдтэй тогтмол очиж уулздаг билээ. Тэдний үйлчлэлийн тухай мэдээллийг news.lds.org-аас түүнчлэн prophets.lds.org дахь Prophets and Apostles Speak Today сайтаас англи, франц, герман, итали, португаль, испани хэлээр үзэж болно. Ойрмогхоны аяллуудын тухай товч мэдээг дор өгүүлэв.

- 2011 оны тавдугаар сарын 26-нд Тэргүүн Зөвлөлийн Хоёрдугаар зөвлөх, Ерөнхийлөгч Диетер Угдорф дэлхий дахины хүмүүсийн харилцан ойлголцолд дэмжлэг үзүүлэх зорилготой, улс төрийн намаас хараат бус байгууллага—Лос Анжелес дахь Дэлхийн Ажил Хэргийн Зөвлөлдөх Уулзалтад оролцсон нийгэм, бизнесийн болон шашны удирдагчид 800 хүнд хандан үг хэлжээ. Ерөнхийлөгч Угдорф 1830 оноос өнөөг хүртэлх Сүмийн өсөлт хөгжилтийн тухай ярьсан байна. lds.org-аас “Uchtdorf, Los Angeles” хаягаар мэдээг үзнэ үү.

- 2011 оны 6-р сарын 5-нд Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Ахлагч Рассел М.Нелсон Орос дахь анхны гадас Оросын Москвагийн гадсыг зохион байгуулав. Энэ бол хуучин Зөвлөлт Холбоот Улсын нутаг байсан бүс дэх хоёр дахь гадас юм. Гадсыг зохион байгуулах ажиллагаанд 1,100 гаруй хүмүүс оролцжээ. lds.org-т “Nelson, Moscow” хаягаар орж мэдээг үзнэ үү.

- Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Ахлагч Жеффри Р.Холланд Энэтхэг, Хонг Конг (Хонг Конгд Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Ахлагч Давид А.Беднар түүнтэй нэгдсэн байна), Монголд айлчилжээ. lds.org-т “Holland, India” хаягаар орж мэдээг үзнэ үү.

- 2011 оны 6-р сарын 15-нд Тэргүүлэх бишоп Х.Давид Бертон гуравдугаар сарын 11-нд болсон газар хөдлөлт, цунамиын дараах тус орны байдлыг тодорхойлж, тэнд үзүүлж буй Сүмийн тусламжинд хяналт тавихаар Японы Хигаши Мацушимад зочилжээ. lds.org-т “Burton, Japan” хаягаар орж мэдээг үзнэ үү. ■

ГЭРЭЛ ЗҮРГИЙГ АНАИ НАВАГИЙН ЗӨВШӨӨРТӨӨР НИЙТЛЭВ



Мехико хотын энэхүү эгч дүү долоон номлогч дэлхийн өөр өөр хэсэгт бүрэн цагийн номлолд нэгэн зэрэг үйлчилж байна.

Ахмад номлогчдын үйлчлэлийн журамд өөрчлөлт оров

Хосуудыг бүрэн цагийн номлолд үйлчлэхийг дэмжих мөн тэдний номлолын туршлагыг сайжруулах зорилгоор саяхан Тэргүүн Зөвлөл ба Арванхоёрын Чуулгаас номлогч гэр бүлийн хосуудын номлолд үйлчлэх бодлогод өөрчлөлт оруулан батлав.

2011 оны есдүгээр сарын 1-нээс эхлэн гэр бүлийн хос номлогчид 6, 12, 18, 23 сараар үйлчилж болно. Түүнээс гадна, орон сууцны сарын хөлсний дээд хязгаар 1400 ам. доллар байхаар тогтоов. Хосууд хоол хүнс болон хувийн бусад зардалаа өөрсдөө гаргана.

Өнгөрсөн үед хосууд гадаад оронд доод тал нь 18 сарын хугацаатай үйлчилдэг байсан бол одоо гадаад оронд 18 сараас доошгүй хугацаагаар үйлчлэхийг хүсч буй хүмүүс номлол хийх газартаа очих болон тэндээс эргэж ирэх тээврийн зардлаа өөрсдөө төлнө.

Ахмад гэр бүлийн хосын номлолын талаарх асуултаа seniormissionaryservices@ldschurch.org хаягаар ирүүлж болно. ■

Иерусалим цогцолбор кино-театр онцгойлон адислагдав

Сайн мэдээний сэдэвтэй кинонуудыг үзүүлж байх Иерусалим цогцолбор



Ютагийн Гошен дахь шинэ цогцолбор кинотеатрыг Шинэ Гэрээнд цэдэглэгдсэн Есүс Христийн амьдралын үйл явдлуудыг дэлгэцнээ харуулахад ашиглах болно.

кинотеатрыг Сүм барьж, онцгойлон адисалжээ. Эдүгээ уг цогцолбор кинотеатрыг кино тавьж үзүүлэхэд ашиглаж байна. Есүс Христ болон Төлөөлөгчдийн амьдралаас чухал хэсгүүдийг дүрсэлсэн цуврал видео—Шинэ Гэрээний Судрын Номын Сан төслийг хэрэгжүүлэхэд уг кинотеатрыг анх удаа ашигласан ажээ.

Энэхүү цогцолбор АНУ-ын Юта дахь Кино Зургийн Өмнөд Студийн Гошенд, Солт Лейк хот дахь Сүмийн удирдах газраас өмнө зүгт 97 км-т

оршдог. Энэ бол Иерусалимын хуулбар биш, харин тус хот дахь чухал газруудыг дахин бүтээсэн юм.

Эргэн тойрны газар нь Иерусалимын газарзүйтэй төстэй толгод, хээр тал, хуш модтой төгөл, элсэн манхан, горхиудтай учраас жижигхэн хот Гошеныг сонгосон ажээ. Ойролцоох Юта нуур Галилын тэнгисийг төлөөлөх болно.

Зарим тохиолдолд, кинотеатрт багтах боломжгүй зүйлийг компьютерт оруулж, графикаар дүрслэн үзүүлэх болно. ■

Сүм онлайн аа олон хэлээр өргөжүүлэв

LDS.org олон хэлээр өргөжив. Саяхан 48 шинэ хэлний хуудас (home pages) Сүмийн албан ёсны вэбсайтад нэмэгдлээ. “Languages” хаяг доорх аль нэг хэлэн дээр дарж, LDS.org-ийн аль ч хуудасны баруун дээд өнцөгт холболт хийснээр вэбсайтад орогч нь тухайн хэлээр онлайнд байгаа Сүмийн материалуудыг үзэж болно.

LDS.org-ийн өөр өөр хэсгүүд эцэстээ 10-15 хэлээр тавигдана. Тэр үед хэлнүүдийн хуудсыг цаашид ашиглахгүй болно. (Жишээ нь, англи, франц, герман, итали, португаль, испани хэлээр LDS.org-т маш их материал байгаа учраас эдгээр хэлний хуудас байхгүй болно.)

Сэтгүүлүүд болон LDS.org-аас орчуулсан материал дээр ажилладаг Сүмийн ажилтнууд бас зөөврийн төхөөрөмжүүдийг ашиглаж болно. ■

Квоецалтенанго Ариун сүмийн нээлтийн ажиллагаа болон онцгойлдон адислалтыг зарлав

Гватемалын Квоецалтенанго Ариун сүмийн онцгойлон адислалтыг тэмдэглэхийн тулд тус орон дахь Сүмийн залуучууд 2011 оны 12-р сарын 10-нд дуу, хөгжим, бүжгийн тоглолтод оролцох болно.

Дараа нь 2011 оны 12-р сарын 11-ний ням гарагт ариун сүмийг гурван цуглаанаар онцгойлон адислах бөгөөд онцгойлон адислах үйл ажиллагааг Гватемал дахь Сүмийн бүх нэгжүүдэд телевизийн нэвтрүүлгээр үзүүлнэ.

Онцгойлон адисалсны дараа 2011 оны 12-р сарын 13-ны мягмар гарагт ёслолууд хийхээр нээх болно.

Сүм Францад ариун сүм барина гэдэгт итгэлтэй байна

Сүм Парисын зах дахь газар дээр Францын анхны ариун сүмийг барина гэдэгт итгэлтэй байгаагаа Ерөнхийлөгч Томас

С.Монсон долдугаар сард зарлав.

Сүм тус улсын албаны хүмүүстэй олон сарын турш хамтран ажиллаж байна.

Францад ариун сүм барих тохиромжтой олохоор өмнө нь нэлээд хэдэн удаа оролдсон ч, нэг нь ч амжилттай болоогүй ажээ. Францын Сүмийн гишүүд ихэвчлэн хөрш зэргэлдээх Европын орнууд уруу очиж ариун сүмд ордог байна.

Аудио судруудын шинэ формат

Сүм Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн жишиг бүтээлүүдийн аудио хувилбарыг iTunes буюу MP3 форматаар audiobook (iTunes-ээр “өргөжүүлсэн аудио ном” гэсэн нэртэй) болгон гаргалаа.

Бүрэн жишиг бүтээлийн аудио хувилбар англи, испани хэлээр тавигдсан бөгөөд япон, португаль, солонгос хэлээрх гурамсан судруудын аудио хувилбар гарлаа.

Эдгээр эх сурвалжуудад нэвтрэхийн тулд iTunes.lds.org-дахь Сүмийн сувгийн судрын хэсэгт ор. ■

Жишиг бүтээлүүдийн аудио хувилбар эдүгээ iTunes.lds.org-т нэлээд олон хэлээр тавигдаад байна.



Зүрх сэтгэл минь талархлаар дүүрч билээ

Лиахона сэтгүүл сар бүр ирэхэд миний хамгийн түрүүнд унших дуртай өгүүлүүдийн нэг нь үргэлж Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн дуу хоолой байдаг. Жишээ нь, би “Та тэнгэр элч байлаа” (Лиахона, 2010 оны 12-р сар, 38) гэсэн өгүүллийг хамгийн түрүүнд уншсан. Уг өгүүлэл сүнсний агуу хүчээрээ надад нөлөөлж, Аврагчийнхаа үүрэг зорилгын төлөө, Түүний нэрээр амь бие хайргүй үйлчилдэг хүмүүсийн төлөө талархах талархлаар зүрх сэтгэл минь дүүрч билээ. Гайхалтай туршлагаа хуваалцсаных нь төлөө Хейди Виндиш Фернандезд би онцгой баярлан талархаж байна.

Ларри Д. Камп, Баруун Виржини, АНУ

Лиахона өөрчлөлт гаргаж байна

Хувь хүн, эцэг, нөхөр, удирдагчийн хувьд Лиахона-гийн захиасууд надад үргэлж дэмжлэг болдог. Бас ерөнхий чуулганы дугаарууд манай гэрт онцгой сүнслэг байдлыг авчирдаг. Би чуулгын дугааруудыг үргэлж өөртөө, эхнэртээ, хөвгүүддээ тус бүрд нь захиалдаг болохоор бид чуулганы захиасуудыг тус бүрдээ уншиж, тэмдэглэдэг. Иймээс бид сэтгүүлийг ээлжлэн унших гэж хүлээдэггүй. Бид жилийн эцэст сэтгүүлүүдээ үдэж, илүү дугааруудыг идэвх султай гишүүд, гишүүн бус найз нартаа өгдөг. Лиахона сэтгүүл бидний амьдралд өөрчлөлт гаргадгийг би гэрчилж байна.

Фабио Аллегретти Купер, Бразил

Санал зөвлөмжөө liahona@ldschurch.org хаягаар илгээнэ үү. Ирүүлсэн материалуудыг хэмжээ, тодорхой байдлын хувьд хянан засварласж болно. ■

Энэ дугаарт гэр бүлийн үдэшт ашиглахуйц өгүүлэл, үйл ажиллагаанууд байгаа болно. Зарим жишээг доор харуулав.

“Ганц бие гишүүн миний үйлчлэл,”

хуудас 12: Бөрдетт эгчийн түүхийг уншсаны дараа Сүмд үйлчилснээс ирдэг адислалуудын тухай ярилц. Дуудлагаараа үйлчлэх үед тохиолдсон чухал туршлагынхаа тухай хуваалцахыг гэр бүлийн гишүүдээс хүсч болно

“Аврагч амьдыг мэдэхээс ирдэг амар амгалан ба баяр баясал,”

хуудас 18: Аврагчийн төлөө ирэх жил юу хийж чадахыг нь гэр бүлийн гишүүдээс асуу. “Түүнд өгөх бидний бэлэг” өгүүллийн сүүлчийн догол мөрүүдийг унш. Их Эзэнд бидний өргөн барих хамгийн агуу бэлгийг юу гэж Ахлагч Нелсон хэлсэн бэ?

“Ирцгээ, Түүнийг бишрэн шүтэцгээ,”

хуудас 42: Гэр бүлдээ хамгийн сайн тохирох хэсэг буюу хэсгүүдийг хичээлийн өмнө залбиран сонгож ав. Хэрэв та хоньчдын тухай хэсгийг сонговол, “сүнсний өдөөлтийг дагахаа хэзээ ч бүү хойшлуул” гэсэн Ерөнхийлөгч Монсонгийн зөвлөгөөг

Хөрвөлт ба Сүнсийг хуваалцсан нь

Би залуу насанд хүрэгчдийн тойрогт байхдаа тойргийнхоо нэг гэр бүлтэй гэр бүлийн үдэш хийдэг байлаа. Миний оролцсон хамгийн дурсгалтай, санаанаас гардаггүй нэг гэр бүлийн үдэш бол бүрэн цагийн номлогчид хариуцан хийсэн гэр бүлийн үдэш байлаа.

Ахлагч нар манай тойргийн нэлээд хэдэн хөрвөгчийг хөрвөлтийнхөө түүхээс хуваалцахыг уриу. Хөрвөгчдийг ярьж байхад Сүнс бидний оршихуйд байсан нь илт мэдэгдэж байв.

Тэднийг хөрвөлтийн түүхээ хуваалцсаны

хуваалцаж, уг зөвлөгөөний ач холбогдлын тухай гэр бүлтэйгээ ярилцаж болно. Энэ санааг хүүхдүүддээ заахын тулд, зөвлөгөөг тэдний чихэнд шивнэн хэлж, үүнийг дагахад нь урамшуулан дэмж.



“Иосеф Ахтай уулз,” хуудас 58: Өгүүллээс түүний тухай үйл явдлуудын жагсаалтыг унших үед Иосеф Смитийн зургийг үзүүлэхийг бод. Гэрийнхэн чинь хэчнээн үйл явдлыг эргэн санаж чадахыг харахын тулд хичээлийн дараа ямар нэг тоглоом тоглож болно.

“Бүдүүлэг үгс,” хуудас 60: Гэр бүлээрээ уг өгүүллийг уншсаны дараа хэрэв хэн нэг нь тэдний дэргэд бүдүүлэг үг хэлбэл гэр бүлийн гишүүд нь юу гэж хэлэхийг ярилцаж болно. Египетээс Гарсан нь 20:7 (мөн С ба Г 63:60–64-ийг үз)-д Их Эзэний нэрийг дэмий хоосноор хэрэглэхгүй байхыг яагаад бидэнд зарлигласныг бага насны хүүхдүүдэд тайлбарлаж болно. ■

дараа миний санаа бодол бүрэн цагийн болоод насан туршдаа номлогч байх өөрийн туршлага уруу чиглэлээ. Сайн мэдээг өдөр тутам хуваалцдаг хувийн үйл ажиллагаагаар эргэн харж дүгнэлт хийгээд ойрын ирээдүйд юу хийхээ тунгаан бодлоо. {nb}

Хожим нь би тойрогтоо гэр бүлийн үдшийг хариуцахаар дуудагдсан үедээ “хөрвөлтийн түүхийн үдшийг” үе үе идэвхтэйгээр үргэлжлүүлэх санаа төрж, тойргийнхоо олон хөрвөгчөөс үүнд оролцохыг хүсч билээ. ■

Жанна МкФерсон, Калифорни, АНУ

ХҮҮГИЙН ГЭРЭЛ

Жефф С.Мкинтош

Их дэлгүүрүүдэд эрэгтэйчүүдийн хувцас худалдаж, хэдэн жил ажилласны дараа би худалддаг костюмууддаа цамц, зангиа тааруулан сонгож авахад ихэд туршлагажсан байлаа. Костюм, цамц, зангиаг хослуулан сонгох нь урамтай ажил бөгөөд худалдан авагчид маань миний санал болгосон хослолыг ихэнхдээ дуртай худалдаж авдаг байв.

Гэтэл нэгэн дэлгүүрт костюмуудыг гэрэл гэгээтэй газар харин цамц зангиануудыг чийдэнгийн улаан гэрэлтэй өөр газарт дэлгэж тавьдаг байлаа. Гэрэлтүүлгийн энэ ялгаа нэлээд төвөг учруулдаг байж билээ.

Худалдан авагч нэг юм уу хоёр костюм авахаар шийдсэний дараа би үүнд нь тохирох цамц, зангиа сонгож авахаар гүйх хэрэгтэй болно. Харин нэг удаа цамц, зангианы тасгийг костюмны дэргэд авчран байрлуулсан байв. Гэтэл юу болсон гээч! Шинэ гэрэлтүүлэгт цамц, зангианы өнгө өөрчлөгдөж, костюмтайгаа огт тохирохгүй болсныг хараад их гайхав.

Костюмыг цамц, зангианы тасагт аваачаад харвал арай дээр харагдаж байлаа. Энэ тохиолдолд ч гэсэн костюмууд худалдан авагчдын сонгож авах үед харагдсан өнгөнөөсөө өөр өнгөтэй болсон мэт харагдаж, тэднийг гайхахад хүргэдэг байв. Цагаан гэрэлд сааралдуу ногоон өнгөтэй харагддаг костюм улаан гэрэлд саарал, бор саарал, эсвэл бор хүрэн өнгөтэй болж харагдана. Хар, бараан, хар хөх өнгийн костюмны өнгө мөн л өөр болж харагдана.



Үнэнийг олж, үүнийгээ илүү тод харахад гэрэл бидэнд тусалдаг.

Тиймээс би, дандаа биш ч гэсэн худалдан авагчдыг хаалганы ойролцоо гадаа гарч, сонгосон хувцсаа өдрийн гэрэлд харахыг санал болгосноор уг асуудлыг шийдсэн юм. Нарны гэрэлд харснаар жинхэнэ өнгийг тэр дор нь мэдэж, тохирох сонголтыг хийдэг байв.

Их дэлгүүрээс гаднах ертөнцөд бид өдөр бүр янз бүрийн сонголттой тулгардаг. Зарим үед эдгээр сонголтуудад хүмүүний үзэл бодол нөлөөлдөг. Заримдаа эдгээр сонголтуудад энэ дэлхийн уруу таталт нөлөөлнө. Бидний өмнө тулгарсан сонголтын хувилбарууд зөв биш юм шиг санагдаж болно, эсвэл юу бодитой, юу бодит бус болох тухайд будилж ч мэднэ. Юу зөв болохыг ялган таних тухайд мөн эргэлзэж мэднэ.

Энэ асуудлын шийдэл нь сонголтоо гэрэлд, жишээ нь, Хүүгийн гэрэлд хийх явдал гэдгийг би мэдсэн юм. Учир нь Тэрбээр “Би аглаг буйдаа та нарын гэрэл байх болно; мөн би та нарын өмнө замыг бэлтгэнэ, хэрэв та нар миний зарлигуудыг дагавал; . . . мөн та нар надаар удирдагдаж байгаагаа мэдэх болно (1 Нифай 17:13; онцлон тэмдэглэлт нэмэгдсэн).

Зөв гэрлээр сонгохыг хичээх нь гэр бүлийнхээ болон өөрийнхөө төлөө зөв сонголт хийхэд бидэнд туслах болно. Ариун Сүнсний удирдамжаар дамжуулан Бурханд найдвар тавьснаар бид мэхлэгдэхгүй харин муугаас сайныг ялган таньж мэддэг болно (Моронай 7:16-г үз).

Түүнийг дагахаар сонголт хийсэн үед бидний хайрт Аврагч Өөрийн гэрлийг бидэнтэй хуваалцахаар амласан юм: “Бурханаас буй тэр нь гэрэл болой; мөн гэрлийг хүлээн авдаг мөн Бурханд үлддэг тэр нь илүү их гэрэл хүлээн авдаг; мөн тэрхүү гэрэл төгс өдрийг хүртэл улам хурц болон өсдөг” (С ба Г 50:24). ■



Мариагийн өвөр дээр, Симон Дьювей

“Болгоогтун, дэлхийн үүслээс хүмүүний үрсэд миний мэдүүлсэн тэр бүх зүйлийг гүйцэлдүүлэхээр, мөн Эцэгийн мөн Хүүгийн—миний учир Эцэгийн мөн биемахбодийн минь учир

аль алиных нь тааллыг үйлдэхээр би өөрийнхөндөө ирнэ. Мөн болгоогтун, цаг нь ойртлоо, мөн энэ шөнө тэмдэг өгөгдөх болно” (3 Нифай 1:14).



Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Ахлагч Рассел М.Нелсон,
 “Есүс Христ бол амьд Бурханы тэнгэрлэг Хүү гэдгийг би
 гэрчилж байна. “Хэрэв та нар Түүнийг хайрлаж, зарлигуудыг
 нь сахих юм бол Тэр та нарыг хайрлаж, өргөн дэмжиж,
 Өөрийгөө та нарт харуулах болно (Иохан 14:21 -ийг үз).
 Үнэн хэрэгтээ, ухаалаг эрэгтэй, эмэгтэйчүүд одоо ч
 гэсэн Түүнийг шүтэн биширсээр байдаг билээ” хэмээн
 бичжээ. “Аврагч амьд гэдгийг мэдсэнээс ирдэг амар
 амгалан ба баяр баясал” өгүүллийг үз, х.18.